# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

/2021 оны жилийн эцэс/

2022 оны 02 дугаар сарын 14

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэр, зүйл, заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2021 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, зүйл, заалтыг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар тасалбар болгон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын **5 дугаар хавсралтын** дагуу салбар тус бүрээр Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэсэн таван ангиллаар хэрэгжилтийг гаргуулав.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.**

2021 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 179 шийдвэрийн 269 зүйл, заалтыг дээр дурдсан агуулгаар ангилж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **91.8** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

- Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 23 шийдвэрийн 29 зүйл, заалтын хэрэгжилт - 87.1%;

- Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 34 шийдвэрийн 52 зүйл, заалтын хэрэгжилт - 94.1%;
- Уул уурхайн бодлогын 55 шийдвэрийн 90 зүйл, заалтын хэрэгжилт - 90.8%;
- Хүнд үйлдвэрийн бодлогын 12 шийдвэрийн 15 зүйл, заалтын хэрэгжилт - 84.6%;
- Нийтлэг асуудлын 55 шийдвэрийн 83 зүйл, заалтын хэрэгжилт - 94.3%-ийн тус тус биелэлттэй байна.

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

/2020 оны жилийн эцэс/

Хүснэгт-1

| Салбар, чиглэлийн нэр | Хяналтанд авсан тоо | | Хэрэгжилтийн явц /хувиар/ | | | | | Үнэлгээ /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шийдвэр | Зүйл, заалт | 100% | 70% | 30% | 0% | Үнэлээгүй | |
| **НЭГ. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 2 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| УИХ-ын тогтоол | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 12 | 14 | 11 | 1 | 2 | 0 | 0 | 87.8 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 7 | 10 | 4 | 4 | 1 | 0 | 1 | 78.8 |
| ГЭББ-ын дүн | 23 | 29 | 20 | 5 | 3 | 0 | 1 | **87.1** |
| **ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 3 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| УИХ-ын тогтоол | 2 | 3 | 2 | 1 | 0 | 0 | 0 | 90.0 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 3 | 6 | 6 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 6 | 8 | 6 | 2 | 0 | 0 | 0 | 92.5 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 20 | 32 | 26 | 5 | 1 | 0 | 0 | 93.1 |
| ГТГТББТНТБ-ын дүн | 34 | 52 | 43 | 8 | 1 | 0 | 0 | **94.1** |
| **ГУРАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 4 | 8 | 6 | 2 | 0 | 0 | 0 | 92.5 |
| УИХ-ын тогтоол | 10 | 22 | 18 | 3 | 0 | 0 | 1 | 95.7 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 3 | 8 | 2 | 6 | 0 | 0 | 0 | 77.5 |
| ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 15 | 21 | 14 | 5 | 0 | 0 | 2 | 92.1 |
| Ерөнхий сайдын захирамж | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 21 | 29 | 17 | 10 | 0 | 0 | 2 | 88.8 |
| УУБ-ын дүн | 55 | 90 | 59 | 26 | 0 | 0 | 5 | **90.8** |
| **ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| УИХ-ын тогтоол | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 3 | 5 | 1 | 2 | 2 | 0 | 0 | 60.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 5 | 6 | 5 | 1 | 0 | 0 | 0 | 95.0 |
| ХҮБ-ын дүн | 12 | 15 | 10 | 3 | 2 | 0 | 0 | **84.6** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ТАВ. НИЙТЛЭГ АСУУДАЛ | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 3 | 4 | 3 | 1 | 0 | 0 | 0 | 92.5 |
| УИХ-ын тогтоол | 5 | 7 | 7 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 3 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Ерөнхийлөгчийн зарлиг | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 11 | 13 | 9 | 2 | 1 | 0 | 1 | 89.1 |
| Ерөнхий сайдын захирамж | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 24 | 29 | 25 | 3 | 0 | 0 | 1 | 96.7 |
| ЗГ-ын албан даалгавар | 4 | 22 | 15 | 7 | 0 | 0 | 0 | 90.4 |
| Нийтлэг асуудлын дүн | 55 | 83 | 67 | 13 | 1 | 0 | 2 | **94.3** |
| **НИЙТ ДҮН** | **179** | **269** | **199** | **55** | **7** | 0 | **8** | **91.8** |

Нийт 179 шийдвэрийн 269 зүйл, заалтын 8 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй бөгөөд хэрэгжилтийг дүгнэсэн 261 зүйл, заалтын 199 зүйл, заалт буюу 76.2% нь "бүрэн хэрэгжсэн" 100 хувийн биелэлттэй, 55 зүйл, заалт буюу 21.1% нь "хэрэгжих шатанд" 70 хувийн биелэлттэй, 7 зүйл, заалт буюу 2.6% нь "хэрэгжилт хангалтгүй" 30 хувийн биелэлттэй байна.

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ
### /Хууль тогтоомжийн төрлөөр/

Хүснэгт-2

| | | Бүгд | Монгол Улсын хууль | Улсын Их Хурлын тогтоол | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын албан даалгавар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтад авагдсан шийдвэрийн тоо | | **179** | 14 | 20 | 10 | 1 | 3 | 47 | 3 | 77 | 4 |
| Заалтын тоо | | **269** | 20 | 35 | 18 | 1 | 3 | 61 | 3 | 106 | 22 |
| Үнээс | "бүрэн хэрэгжсэн" 100% | **199** | 17 | 30 | 12 | 1 | 3 | 41 | 3 | 77 | 15 |
| | "хэрэгжих шатанд" 70.0% | **55** | 3 | 4 | 6 | 0 | 0 | 12 | 0 | 23 | 7 |
| | "хэрэгжилт хангалтгүй" 30.0% | **7** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 5 | 0 | 2 | 0 |
| | "хэрэгжээгүй" 0% | **0** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| | Үнэлгээ өгөөгүй | **8** | 0 | 1 | 0 | 0 | 0 | 3 | 0 | 4 | 0 |
| | **Үнэлгээ** | **91.8** | **95.5** | **96.4** | **90.0** | **100.0** | **100.0** | 87.7 | **100.0** | **91.8** | **90.4** |

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 14 хуулийн 20 заалтын хэрэгжилт – 95.5%;
- Улсын Их Хурлын 20 тогтоолын 35 заалтын хэрэгжилт – 96.4%;
- УИХ-ын Байнгын хорооны 10 тогтоолын 18 заалтын хэрэгжилт – 90.0%;
- Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалтын хэрэгжилт – 100.0%;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 шийдвэрийн 3 заалтын хэрэгжилт – 100.0%;
- Засгийн газрын 47 тогтоолын 61 заалтын хэрэгжилт – 87.7%;
- Ерөнхий сайдын 3 захирамжийн 3 заалтын хэрэгжилт – 100.0%;
- Засгийн газрын хуралдааны 77 тэмдэглэлийн 106 заалтын хэрэгжилт – 91.8%;
- Засгийн газрын 4 албан даалгаврын 22 заалтын хэрэгжилт – 90.4% байна.

**Дөрөв. Дүгнэлт**.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан 179 шийдвэрийн 269 зүйл, заалтын 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийг **91.8** хувийн биелэлттэй гэж дүгнэлээ.
2. Нийт 269 зүйл, заалтын 8 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй, 199 зүйл, заалт “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 55 зүйл, заалт “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй, 7 зүйл, заалт “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй байна.
3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа боловч хэрэгжилтийг тайлагнахдаа ажлын гол үр дүнг товч тодорхой (тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан), баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.
4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, дараагийн шийдвэрүүд гарсан, мөн тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй зэрэг шалтгаанаар нийт 47 зүйл, заалтыг хяналтаас хасуулах саналыг холбогдох нэгжүүдээс ирүүлсэн байна.

**Тав. Зөвлөмж**.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Шинэ сэргэлтийн бодлого" зэрэг баримт бичгүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлттэй уялдуулан тайлагнах;
2. Төрийн захиргааны удирдлагын газраас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг (дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж) нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой байдлаар (тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан) гаргуулах,

холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгүүдийн огноо, дугаарыг тодорхой бичүүлэх;

3. “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй дүгнэгдсэн, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа ажлуудыг эрчимжүүлэх, он удаан жил хэрэгжилт хангагдахгүй байгаа холбогдох шийдвэрийн зүйл, заалтыг хүчингүй болгуулах, дараагийн шийдвэрийг гаргуулах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах.

Жич: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга Ц.Одхүү

Үнэлгээ хийж, танилцуулга боловсруулсан:
ХШҮДАГ-ын шинжээч Н.Цогтбаяр

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР БАТЛАГДСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
/2021 оны жилийн эцсийн байдлаар/

2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр

| № | Шийдвэрийн дэс дугаар | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| САЛБАР ЧИГЛЭЛ: 1. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО | | | | | | |
| 1.а. Монгол Улсын хууль | | | | | | |
| 1 | 1 | 1 | **Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009-07-16 Дугаар 2009.07.16** 4.3. Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно. (4.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.) | ЗГ-ын 2011.06.08-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн заагийг хавсралтаар баталсан. Уг тогтоолд ЗГ-ын 2014 оны 260, 2015 оны 130 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон. Монгол Улсын ЗГ-ын 2012.06.05-ны өдрийн 194 дүгээр тогтоолоор МУ-ын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийг 1 дүгээр, Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг 2 дугаар, Ойн сан бүхий газрын хилийн заагийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсан. ЗГ-ын 2014 оны 260, 2014 оны 281, 2015 оны 130, 302, 2016 оны 155 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон. ЗГ-ын 2015.03.03-ны өдрийн 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам"-ыг, 2 дугаар хавсралтаар "Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээний загвар"-ыг тус тус баталсан. ЗГ-ын 2015.07.07-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор ЗГ-ын 2012 оны 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "МУ-ын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг"-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 1 дүгээр, уг тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Ойн сан бүхий газрын хилийн зааг"-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 2 дугаар хавсралтаар баталсан. Мөн | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хилийн заагийг хэсэгчлэн тогтоох тухай" ЗГ-ын 174 дүгээр тогтоол, "Хилийн заагийг тогтоох" тухай 194 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болгосон. Засгийн газрын 2015.03.03-ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан "Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам"-д заасны дагуу Энгийн хамгаалалтын бүсэд гэрээ байгуулсан 38 аж ахуйн нэгжийн 40 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гэрээний хугацааг АМГТГ-аас сунгаж ажилласан. | | | |
| 2 | 2 | 2 | **Цөмийн энергийн тухай 2009-07-16 Дугаар 2009.07.16** 28.10. Энэ хуулийн 28.9-д заасан мөнгөн хөрөнгийн хэмжээг нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдлийг харгалзан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. (28.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулна.) | Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Ерөнхий сайдын 2015 оны 21 дүгээр захирамжаар Уул уурхайн сайдын ахалсан ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Ажлын хэсгийн гол зорилго нь уурхайн нөхөн сэргээлт, хаалтын үйл ажиллагаанаас тусдаа зөвхөн гэнэтийн аюул, осолтой холбогдон нийгэмд бий болох хохирлыг /эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй байдал/ арилгахад шаардагдах мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтооход чиглэсэн.<br>Ажлын хэсэг нь ураны хайгуул, олборлолт, боловсруулалт явуулдаг улс орнуудын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хаалт хийх үйл ажиллагаанд зориулан тусгай сан үүсгэдэг туршлага, зарим тохиолдолд урьдчилан төлөвлөөгүй, гэнэтийн осол аваарын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан тусдаа сан үүсгэх эсхүл дээрх сантай нэгдмэл байдлаар зохицуулдаг талаарх судалгааг хийж гүйцэтгэсэн. Мөн Улсын байгууллагуудын /OECD-Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, IAEA-Олон улсын атомын энергийн агентлаг/ судалгааны үр дүнг судалж холбогдох санал зөвлөмжийг гаргасан.<br>Цөмийн энергийн тухай хуулийн 45.3-т "Нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн ослын хор уршгийг арилгах ажлын зардлыг Засгийн газар хариуцна." гэж заасан байх тул санд төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээг аль болох их хэмжээнд байлгах асуудлыг УУХҮЯ-ны зүгээс баримталж Ажлын хэсгийн дүгнэлтээр төслийн хэмжээнд гэнэтийн ослын санд төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ нийт төслийн хугацаанд дунджаар 1.6 тэрбум доллар, туршилтын хугацаанд 0.8 сая доллар байх асуудлаар төслийн хөрөнгө оруулагч "Арева Монгол" ХХК-ийн удирдлагатай зөвшилцөж 900,000.0 ам.долларыг Төрийн санд байршуулахаар тогтсон.<br>Ингээд Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоо ордын ашиглалтын MV-018915 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч "Бадрах энержи" ХХК нь ураны ордын технологийн туршилт явуулахтай холбогдуулан нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрсдэлийг харгалзан байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон 900,000.0 /есөн зуун мянга/ ам.доллартой тэнцэх мөнгөн хөрөнгийг “Бадрах энержи” ХХК-иас гаргуулан Төрийн сангийн холбогдох дансанд байршуулах тухай Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоол гарсан. Тогтоолын дагуу УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал болон Бадрах энержи ХХК-ийн гүйцэтгэх захирал Закария Эл Марзуки нар 2019.11.15-ны өдөр “Зөөвч овоо ордын технологийн туршилттай холбогдуулан Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулах тухай гэрээ”-г байгуулж УУХҮЯ-ны Тусгай зөвшөөрлийн барьцаа нэртэй Төрийн сангийн 100900018450 тоот дансанд 900,000.0 ам.доллартой тэнцэх тухайн үеийн Монголбанкны ханшаар 2,433,204,000.0 төгрөгийг байршуулсан. | | |
| 3 | 2 | 3 | 15.2. Дараах үйл ажиллагааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ: 15.2.1.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх; 15.2.2.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах; 15.2.3.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх. | Цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах чиглэлээр тайлангийн хугацаанд шинээр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоогүй.<br>2021.12.20-ны өдрийн байдлаар Геологи, уул уурхайн кадастрын мэдээллийн санд шүүлт хийж үзэхэд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын 5, ашиглалтын 9 тусгай зөвшөөрөл хүчинтэй бүртгэлтэй байна.<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.11.02-ны өдрийн 128/ШШ2020/0713 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021.01.27-ны өдрийн 67 дугаар магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн 2021.04.05-ны өдрийн 99 дүгээр тогтоол, Улсын дээд шүүхийн 2021.06.28-ны өдрийн 53 дугаар тогтоолыг биелүүлж “Гурвансайхан” ХХК-ийн эзэмшлийн Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Улбаян сумдын нутаг Өлзийт нэртэй 10662.22 гектар талбайд цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын MV-020634 дүгээр тусгай зөвшөөрлийг олгосон Кадастрын даргын /хуучин нэрээр/ 2016.07.22-ны өдрийн 512 дугаар шийдвэрийг хүчингүй болгосон Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2021.10.13-ны өдрийн 402 дугаар шийдвэр гаргасан. | 100% | |
| 1.6. Улсын Их Хурлын тогтоол | | | | | | |
| 4 | 1 | 1 | **Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (УИХ 2016.07.21-ний 12 дугаар тогтоолд “21.Үндэсний геологийн алба” гэж нэмсүгэй) 2020-01-30 Дугаар 2020 №12**<br>3.. Үндэсний геологийн албыг УУХҮСайдын батлагдсан төсөв, | УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албыг Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолоор байгуулсан. Тус тогтоолоор Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт зөвшөөрсөн. Үндэсний геологийн албаны орон тооны дээд хязгаарыг 68 байхаар тогтоосон болович Засгийн газрын 38 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 35 байхаар өөрчлөлт оруулсан. Өнөөдрийн | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | орон тооны хязгаарт багтаан байгуулж ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай. | байдлаар Үндэсний геологийн албаны үйл ажиллагаа жигд явагдаж байна. | ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 5 | 1 | 1 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай БОХХААБХ/ӨБХ/ 2019-05-28 Дугаар 2019 №04/01** 1.1/. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн биелэлтийг нийслэл болон Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт хангасан талаар танилцуулах; | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5-д заасанаар хайрга, дайрганы түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох эрх нь орон нутгийн удирдлага Засаг даргад хадгалагддаг.<br>Орон нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход Ашигт малтмал, газрын тосны газраас дүгнэлт гаргадаг бөгөөд Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар давхцал байгаа тохиолдолд олгох боломжтой дүгнэлтийг гаргахгүй, хориотой юм.<br>Харин урт нэртэй хууль гарахаас өмнө Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Төв аймгийн Алтанбулаг, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт олгогдсон байдаг бөгөөд уг газруудыг Засаг дарга цуцлаад шийдвэр болон холбогдох мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газарт ирүүлсэн тохиолдолд УУККС бүртгэх боломжтой. | 100% | |
| 1.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 1.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | | |
| 1.е. Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 6 | 1 | 1 | **Төслийн нэгж байгуулах тухай 2019-05-01 Дугаар 2019_176** 3.. Төслийн нэгжийг 5 жилийн хугацаатай ажиллуулж, үр дүнгийн тайланг тухайн жилийн 12 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК (П.Ганхүү)-д даалгасугай. | Газрын ховор элементийн төслийн нэгж нь Ховор металл, газрын ховор элементийн чиглэлээр дараах судалгааг хийсэн байна. Үүнд:<br>-ГХЭ-ийн зах зээлийн болон технологийн талаар, мөн хөгжингүй орнуудын ховор, газрын ховор элементийн талаар баримталж байгаа бодлогын талаарх судалгаа хийж байна.<br>-Монгол орны газрын ховор элемент болон ордуудын тухай мэдээлэл, Төслийн нэгжийн судалгааны мэдээллийг бэлтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн.<br>-Монгол орны газрын ховор элементийн ашиглалтын тусгай зөвшөөрөл, ханшийн судалгааны ажлыг гүйцэтгэж байна.<br>-Монгол орны газрын ховор элементийн хайгуул хийгдсэн ордууд, илрэлүүд, эрдэсжсэн цэгүүдтэй холбогдолтой тайлан, мэдээллүүдийг Геологи мэдээллийн төв архив болон аж ахуйн нэгжүүдээс цуглуулж, цахим болон цаасан хэлбэрээр архив, суурь мэдээлэл бэлтгэсэн.<br>-Төслийн хүрээнд ХБНГУ-ын Элчин сайдын яам, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугатын ГХЭ-ийн хүрээлэн, Хятад-Монголын технологи дамжуулах төв, ОХУ-ын Росатом зэрэг байгууллагуудтай ГХЭ-ийн техник, технологийн | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | талаарх мэдээлэл болон мэргэжилтэн солилцох хамтарсан төсөл хэрэгжүүлэхээр санамж бичиг байгуулсан. | | | |
| 7 | 2 | 2 | **Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-01-15 Дугаар 2020_17** 1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн иж бүрдлийг бүрэн хангуулах, цахим мэдээллийн төрөлжсөн санг 2020 оны I улиралд багтаан байгуулах, тус мэдээллийн санг холбогдох төрийн байгууллагууд ашиглах, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгасугай. | Уул уурхайн компьютержсон кадастрын системд нэмэлтээр цахим архивын систем хийгдсэн бөгөөд ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн цаасан материалуудыг цахимжуулах ажил хийгдэж байна. Одоогоор хүчин төгөлдөр 2700 гаруй тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийг цахимжуулаад байна. Бусад төрийн байгууллагуудад мэдээллийн санг холбогдох сервис гаргаж ажиллаж байна. Одоогоор Байгаль орчин аялал жуулчлалын яам холбогдон ажиллаж байгаа бөгөөд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга болон Ашигт малтмал, газрын тосны газрын дарга нарын 2020.12.18-ны өдрийн А/140, А/270 дугаар хамтарсан тушаалаар Ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл олгосон газрын зураг зүйн болон Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн сангуудын нэгдсэн уялдаа холбоог хангах, мэдээллээ саадгүй солилцох, шинэчлэх боломжтой "Дундын мэдээллийн сан"-г байгуулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байна. | | 70% | |
| 8 | 2 | 3 | 5.. Ашигт малтмалын ордын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам"-ыг шинэчлэн боловсруулж 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт үүрэг болгосугай. | АМГТГ-ын даргын 2020.04.03-ны өдрийн А/35 дугаар тушаалаар "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам"-ын явц, хэрэгжилтийн үр дүн, биелэлтийг судалж, цаашид авах арга хэмжээний саналыг танилцуулах үүрэг бүхий 9 гишүүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ажлын хэсэг хуралдаагүй болно. | | 30% | |
| 9 | 2 | 4 | 11.. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон | УУХҮСайдын 2020 оны А/33 дугаар тушаалаар "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг хүчингүй болгох асуудлыг судалж санал | | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөөгүй, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээн авсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэргүй болон Монгол Улсын хилийн зурваст олгосон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах, бичил уурхайтай холбогдох хуулийн зохицуулалтыг хүчингүй болгох асуудлыг тус тус судалж, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зохих журмын дагуу боловсруулж, 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт үүрэг болгосугай. | дүгнэлт гаргах, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2020 оны А/37 дугаар тушаалаар Бичил уурхайн журам, Засгийн газрын 355 дугаар тогтоолын явц, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж танилцуулах ажлын хэсэгт тус тус ажиллаж, өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн.<br>УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, хуулийн төслийг боловсруулж байна. | | |
| 10 | 3 | 5 | **Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай 2020-03-25 Дугаар 2020_110**<br>4. Ашигт малтмалын ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу болон бичил уурхай эрхлэх зориулалтаар ашиглах талбайн мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд тухай бүр бүртгэж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, | Уул уурхайн компьютержсон кадастрын бүртгэлийн системд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэл болон бичил уурхай эрхлэх зориулалтаар ашиглах талбайн мэдээллийг бүртгэдэг бөгөөд газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний талбайг бүртгэх нэмэлт модулийг нэвтрүүлж бүртгэлийн ажил эхэлсэн. 2012 онд газрын нэгдсэн санд бүртгэл хийлгэсэн, үүнээс хойш талбайн хэмжээнд ямарваа нэгэн өөрчлөлт ороогүй. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | | | |
| 11 | 4 | 6 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай**<br>**2020-04-29**<br>**Дугаар 2020_153**<br>4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг концессын гэрээгээр гүйцэтгэх "Макс рөүд" ХХК-д тус замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын 54 талбайг хайх, ашиглах эрхийг холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан талбайтай давхцуулахгүй олгосон. Тус компани замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай 1,549,000 м.куб элс, дайрга, хайргыг ашиглахаар уг тогтоолд тусгасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалыг бүрэн ашиглаж замын ажлыг дуусгасан байна. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 12 | 5 | 7 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай**<br>**2020-10-07**<br>**Дугаар 2020_135**<br>3. Авто замын барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай.<br>4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай. | 3. Зам, гүүрний бүтээн байгуулалтын ажил дуусмагц гүйцэтгэгч аж ахуйн нэгж талбайн нөхөн сэргээлтийг хийх бөгөөд хяналтыг тухайн орон нутаг тавих тул УУХҮЯ-наас биелэлт гаргахгүй болно.<br>4. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын бүтээн байгуулалтын ажилд ашиглагдах талбайнуудаас ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал нь замын материалын стандартад тохирохгүй, нөөцийн хэмжээ бага тул дахин талбай ялган Засгийн газрын 2021 оны 322 дугаар тогтоолоор нэмэлт оруулж үйл ажиллагааг дэмжин ажилласан. | 100% | |
| 13 | 6 | 8 | **Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай**<br>**2020-11-04**<br>**Дугаар 2020_170**<br>2. Энэ тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж байгаа газар, | Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай, Дорноговь аймгийн Мандах, Сайхандулаан, Улаанбадрах, Сайншанд сумдын нутаг дэвсгэрийг дамнан баригдах Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.2 километр төмөр замын зурвас газар болох 5802 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж байгаа газар, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг нөхөх олговортойгоор эргүүлэн авах, эсхүл солиход гарах зардлын хэмжээ, нүүлгэн шилжүүлэх хугацааг | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг нөхөх олговортойгоор эргүүлэн авах, эсхүл солиход гарах зардлын хэмжээ, нүүлгэн шилжүүлэх хугацааг тохиролцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт даалгасугай. | тохиролцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаалаар ГЗБГЗЗГ, ЗТХЯ, Монгол төмөр ТӨХК, АМГТГ, Дорноговь аймгийн ГХБХБГ, Өмнөговь аймгийн ГХБХБГ, холбогдох сумдын газрын даамал нар ажиллаж байна | | |
| 14 | 7 | 9 | **Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай 2021-05-05 Дугаар 2021_130** 2. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 361 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол"-ын 61 дэх заалтын дараа хавсралтад дурдсан агуулгатай 62-76 дахь заалтыг нэмсүгэй. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | Тогтоолын хавсралтад нэмэлтээр оруулсан түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайнуудыг хуулиар хориглосон, хязгаарласан болон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудтай давхцуулахгүйгээр боловсруулан нэмэлт оруулж батлуулсан. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлыг харьяалах аймгийн Засаг даргын тамгын газар зохицуулах арга хэмжээг авч, замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнуудаас шаардлагатай материалыг замын бүтээн байгуулалтын ажилд ашиглаж байна. ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100% | |
| 15 | 8 | 10 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай 2021-07-16 Дугаар 2021_208** 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд | Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км хатуу хучилттай авто замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайнуудыг хуулиар хориглосон, хязгаарласан болон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудтай давхцуулахгүйгээр боловсруулан батлуулсан. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлыг харьяалах аймгийн Засаг | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддоржид, авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | даргын тамгын газар зохицуулах арга хэмжээг авч, замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнуудаас шаардлагатай материалыг замын бүтээн байгуулалтын ажилд ашиглаж байна. ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | | | |
| 16 | 9 | 11 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай**<br>**2021-07-20**<br>**Дугаар 2021_214**<br>2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | Улсын төсвийн санхүүжилтээр Зам, тээврийн хөгжлийн яамны ЗТХЯ/20191015 дугаар гэрээний дагуу хэрэгжих Сүхбаатар аймгийн төвийн 4 дүгээр тойргийн 9.1 км, 5 дугаар тойргийн 5.65 км, Баруун-Урт хотын сувилал чиглэлийн 3.03 км хатуу хучилттай замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайнуудыг хуулиар хориглосон, хязгаарласан болон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудтай давхцуулахгүйгээр боловсруулан батлуулсан.<br>Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлыг харьяалах аймгийн Засаг даргын тамгын газар зохицуулах арга хэмжээг авч, замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнуудаас шаардлагатай материалыг замын бүтээн байгуулалтын ажилд ашиглаж байна. ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | | 100% | |
| 17 | 10 | 12 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай**<br>**2021-07-20**<br>**Дугаар 2021_215**<br>2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын | Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2016 онд байгуулагдсан Зээлийн хэлэлцээр МОН-3387 дугаартай "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтын тусгаарлах зурвас бүхий авто зам, авто зогсоол, боомтын зам талбайн барилга угсралтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайнуудыг хуулиар хориглосон, хязгаарласан болон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудтай давхцуулахгүйгээр боловсруулан батлуулсан. | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлыг харьяалах аймгийн Засаг даргын тамгын газар зохицуулах арга хэмжээг авч, замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнуудаас шаардлагатай материалыг замын бүтээн байгуулалтын ажилд ашиглаж байна. ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | | |
| 18 | 11 | 13 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай<br>2021-09-08<br>Дугаар 2021_281**<br>2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Хэнтий аймгийн Чингис хот-Дадал сум чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Хэнтий аймгийн Засаг дарга Ц.Идэрбат, авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Хэнтий аймгийн Чингис хот-Дадал сум чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайнуудыг хуулиар хориглосон, хязгаарласан болон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудтай давхцуулахгүйгээр боловсруулан батлуулсан.<br>Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлыг харьяалах аймгийн Засаг даргын тамгын газар зохицуулах арга хэмжээг авч, замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнуудаас шаардлагатай материалыг замын бүтээн байгуулалтын ажилд ашиглаж байна. ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | 12 | 14 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах талбайн солбицлыг батлах тухай 2021-09-22 Дугаар 2021_293** 2. Азийн хөгжлийн банкны МОН-3679/3786 зээлийн хөрөнгөөр "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд хэрэгжих Хүйтэний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын шинэчлэл, их засварын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдорж, авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | Азийн хөгжлийн банкны МОН-3679/3786 зээлийн хөрөнгөөр "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд хэрэгжих Хүйтэний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын шинэчлэл, их засварын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайнуудыг хуулиар хориглосон, хязгаарласан болон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудтай давхцуулахгүйгээр боловсруулан батлуулсан. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлыг харьяалах аймгийн Засаг даргын тамгын газар зохицуулах арга хэмжээг авч, замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнуудаас шаардлагатай материалыг замын бүтээн байгуулалтын ажилд ашиглаж байна. ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | | 100% | |
| 1.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | | |
| 1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 20 | 1 | 1 | **2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл 2020-11-04 Дугаар 2020_58** XYI.2. -. "Геологийн судалгааны төв" болон "Геологийн төв лаборатори" ТӨҮГ-ыг Үндэсний | Үндэсний геологийн албаны харьяанд Геологийн судалгааны төв болон Геологийн төв лабораторийг ажиллуулах талаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж яамдаас санал авсан. Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Засгийн газрын тогтоол гаргах шаардлагагүй талаар санал ирүүлсэн тул тус 2 байгууллагын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан удирдлагын багийг Үндэсний геологийн албаны харьяанд ажиллуулахаар зохицуулсан. | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | геологийн албаны харьяанд ажиллуулах боломжийг судлан саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Үндэсний геологийн алба (О.Чулуун), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | | | |
| 21 | 1 | 2 | XYI.4. . Дорноговь аймагт явагдаж байгаа цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагааны талаар Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. ЗГХЭГ-ын даргын 2020.05.18-ны өдрийн 31 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсгээс гаргасан зөвлөмжийн дагуу хүхрийн хүчлээр газрын дор ураныг уусган олборлох технологийн нөлөөллийг судлах ажлыг тухайн чиглэлийн холбогдох эрдэмтэд, судлаачдыг оролцуулан зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч Д.Рэгдэл нарт даалгав. | Засгийн газрын 2020.11.04-ний өдрийн хуралдааны 58 дугаар тэмдэглэлийн дагуу ШУА-ийн ерөнхийлөгчийн баталсан ажлын хэсэг эрдэмтэн, судлаачдын баг Дорноговь аймгийн Улаанбадрах суманд ажиллаж дүгнэлт, зөвлөмжөө Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2022.01.05-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэл гарсан. | 100%<br><br>Дараагийн шийдвэрүүд гарч хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 22 | 1 | 3 | XYI.4. 2. Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, туршилтын олборлолт, ашиглалтын үйл ажиллагааны талаарх бодит мэдээллийг олон нийтэд хүргэх | Цахим хуудас, олон нийтийн сүлжээнд нийт 12 дотоод мэдээ, 33 гадаад мэдээ, 16 видео мэдээ, 15 контент тус тус байрлуулж нийт 138,946 хандалт авсан.<br>Цөмийн энергийн салбарын олон нийтэд хүргэх, нийтийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд "Цөмийн нэгдсэн групп"-ийг 2020.09.04-ний | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шат дараатай гүйцэтгэх, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оролцуулан газар дээрээс мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав нарт даалгав. | өдөр үүсгэсэн. Нэгдсэн групп 2020.12.15-ны өдрийн байдлаар нийт 750 гишүүн, 16 орны 56 хотуудаас элссэн бөгөөд группд зочилж мэдээлэл авч байгаа гишүүдийг насны ангиллаар авч үзвэл 25-34 насны гишүүд 41.6 хувь, 35-44 насны гишүүд 24.9 хувийг тус тус эзэлж байна. | | | |
| 23 | 2 | 4 | **2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 74 дүгээр тэмдэглэл 2020-12-30 Дугаар 2020_74**<br>XXIX.7. . “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн эзэмшдэг “Овоот хяр” нэртэй XY-21670 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай дахь “Хойд бүргэд” нэртэй алтны үндсэн ордод “Геологийн судалгааны төв” ТӨҮГ болон “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн хамтран гүйцэтгэсэн геологи-хайгуулын ажлын үр дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Хойд бүргэд” нэртэй алтны үндсэн ордын нарийвчилсан хайгуулын ажлыг дуусгах, уг тусгай зөвшөөрөл бүхий талбайд илэрсэн алт, алт-зэсний илрэлүүдэд нөөц тогтоох эрэл, хайгуулын нэмэлт ажилд шаардагдах эх үүсвэрийн асуудлыг судлан саналаа боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн шийдвэрээр “Овоот хяр” хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хийгдэх нарийвчилсан хайгуулын ажилд шаардагдах санхүүжилтийг 2020 оны орлогоос буюу өөрийн хөрөнгөөр гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/37 дугаар тушаалаар геологи, хайгуулын ажлын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. Үүнд:<br>Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Геофизикийн соронзон хайгуулын ажил, Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Геофизикийн цахилгаан хайгуулын ажил, Шар хөндий-Хан худгийн хайгуулын талбайнуудад гүйцэтгэх өрөмдлөгийн ажил, Бүргэдийн хайгуулын талбайнуудад гүйцэтгэх өрөмдлөгийн ажил, Овоот хярын хайгуулын талбайд гүйцэтгэх өрөмдлөгийн ажил, Топогеодези /цооногийн топо холболт, байр зүйн зураг/-ийн ажил, Лабораторийн шинжилгээ, Овоот хярын эрлийн талбайн геологийн нөөцийн тайлан боловсруулах ажил, Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Археологийн судалгаа, Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн судалгаа хийх ажлын тендерийг www.tender.gov.mn цахим хуудаст байршуулан сонгон шалгаруулах ажиллагааг явуулж гүйцэтгэгчийг шалгаруулсан. Шалгарсан гүйцэтгэгч нар гэрээний дагуу геологи-хайгуулын хээрийн судалгааны ажлыг хэрэгжүүлж дууссан. Өнөөдрийн байдлаар суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна. | | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгав. | | | |
| 24 | 3 | 5 | **2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2021-02-17 Дугаар 2021_11** XII.12. 8. Бүс нутгийн логистикийн төвүүдийн байршлыг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан тодорхойлох судалгааг хамтран хийж, 2021 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт; | МУ-ын Ерөнхий сайдын 2021.03.24-ний өдрийн 76 дугаар захирамжаар байгуулагдсан Богдхан төмөр зам төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг 2021.04.05-ны өдөр хуралдаж бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг ажлын хэсгийн гишүүдээс авсан. Салбарын яамны зүгээс бэлтгэл ажлын төлөвлөгөөнд холбогдох саналыг боловсруулан 2021.04.08-ны өдөр Ажлын хэсэгт хүргүүлсэн. Шинэчлэн боловсруулсан төмөр замын чигтэй давхцалтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийг бэлтгэн ЗТХЯ-нд 2021.09.23-ны өдөр хүргүүлэн хамтран ажиллаж байна. | 100% | |
| 25 | 4 | 6 | **2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14** XII.4. 9. Монгол Улсын төрийн өмчит "Мон-Атом" компани, Бүгд Найрамдах Франц Улсын "Орано" группын хамтран хэрэгжүүлж буй "Бадрах Энержи" ХХК-ийн төслийн талаарх байр суурь тодорхой болгох, цаашид авах арга хэмжээний тухай саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Монгол Улсын төрийн өмчит "Мон-Атом" компани, Бүгд Найрамдах Франц Улсын "Орано" группын хамтарсан "Бадрах Энержи" ХХК-ийн хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт байрлах Зөөвч овоогийн ордыг ашиглах туршилтын олборлолтыг 2021.07.09-ний өдрөөс эхлүүлсэн. | 70% | |
| 26 | 5 | 7 | **2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр 53 дугаар тэмдэглэл 2021-09-29 Дугаар 2021_53** XIX.3. . Эдийн засгийг дэмжих шинэ сэргэлтийн бодлого | Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2019 онд байгуулсан "Монгол Улсын хилийн боомт дэд бүтцийн бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх гэрээ"-ний хүрээнд хийгдэх Замын-Үүд, Гашуунсухайт боомтын авто зам, талбайн барилга угсралтын ажил гүйцэтгэхэд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | (Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үеийн эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төслийн боловсруулалтын явц, хилийн Гашуунсухайт боомтын дахь чингэлэг тээврийн терминалын талаар авах зарим арга хэмжээний тухай)-ын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2019 онд байгуулсан "Монгол Улсын хилийн боомт дэд бүтцийн бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх гэрээ"-ний хүрээнд хийгдэх Замын-Үүд, Гашуунсухайт боомтын авто зам, талбайн барилга угсралтын ажил гүйцэтгэхэд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал (элс, хайрга, дайрга)-ын талбайн солбицол тогтоох болон ашиглах эрх олгох тухай асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав. | олгуулахаар хүсэлт ирүүлсэн талбайнууд нь хуулиар хориглосон, хязгаарласан талбайтай давхцалтай байна. Иймд хариуцсан төслийн нэгжтэй хамтран талбайн байршлыг өөрчлөн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шинэ солбицол хүлээж байна. | | |
| 27 | 6 | 8 | **2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 56 дугаар тэмдэглэл**<br>**2021-10-20**<br>**Дугаар 2021_56**<br>ҮIII.8. . Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх талаар Уул уурхай, | Засгийн газрын 2021 оны хуралдааны 56 дугаар тэмдэглэлээр өгсөн даалгаврын дагуу 2022 оны 1 дүгээр улиралд багтаан улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх ажлын явцын талаар танилцуулгыг хийнэ. | /-/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх геологи, судалгааны ажлын явц, эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх талаар жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | | | |
| 28 | 7 | 9 | **2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 59 дүгээр тэмдэглэл 2021-11-10 Дугаар 2021_59** XIII.5.. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. 1. Үүнтэй холбогдуулан уг төслийн талаар дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд нарт даалгав: 1.1. Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн хэрэгжилтийг улам эрчимжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; 1.2. Байгалийн хий нийлүүлэх магистраль шугамнаас Монгол Улс өөрийн дотоодын хийн хэрэглээгээ авах эсэх асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар дахин | УИХ-аас баталсан МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар УУХҮСайдын төсвийн багцад батлагдсан геологи-хайгуул судалгааны ажлын санхүүжилтийн эх үүсвэрээр байгалийн хий нийлүүлэх магистраль шугамын дагуух талбайд геологийн суурь судалгааны ажлыг гүйцэтгэхээр төсөв, төлөвлөгөө, геологийн даалгаврыг баталсан. 2022 оноос судалгааны ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж 2022-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. | 30% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | 7 | 10 | хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх нарт; 1.3. Уг төслийг хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ авах асуудлыг судлахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт. | | | | |
| 29 | 7 | 10 | XIII.8. . "Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын хамтарсан зөвлөл"-ийн ээлжит 3 дугаар хуралдааныг 2021 оны 10 дугаар сарын 13, 15-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулсан тухай дүнг тус хамтарсан зөвлөлийн Монголын хэсгийн дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын хамтарсан зөвлөл"-ийн 3 дугаар хуралдаанаас гаргасан шийдвэрийн мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хамтарсан зөвлөлийн Монголын хэсгийн дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | "Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын хамтарсан Зөвлөлийн 3 дугаар хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх Ажлын төлөвлөгөөний төсөл"-д холбогдох яамд, байгууллагуудаас 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн албан бичгээр санал авсан. Ажлын төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын хамтарсан Зөвлөлийн Монголын хэсгийн дарга Г.Ёндон баталсан бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 01/3080 дугаартай албан бичгээр Гадаад харилцааны яам, Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | | 100% | |
| | 23 | 29 | Геологи, эрдэс баялгийн бодлогын дундаж: 87.1 хувь | | | | |

| |
|---|
| САЛБАР ЧИГЛЭЛ: 2. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО |
| 2.а. Монгол Улсын хууль |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 30 | 1 | 1 | **Хөрөнгө оруулалтын тухай 2013-10-03 Дугаар 2013.11.01** 11.2.1.. Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих; (11.2.Доор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:) | Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 2019.11.28-ны өдөр батлагдсан хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, гаалийн албан татварыг хөнгөлөх тухай Монгол Улсын Засгийн газрын 2020.05.13-ны өдрийн 172 дугаар тогтоол батлагдан гарсан. Тус тогтоолоор Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт барих газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга, байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах дотоодын үйлдвэрээс хангах боломжгүй импортоор оруулж ирэх бараа материалын жагсаалтыг баталсан. | 100% ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 31 | 2 | 2 | **Газрын тосны тухай /Шинэчилсэн найруулга/ 2014-07-01 Дугаар 2014_06** 8.1.9. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах; | Хуулийн тус заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд АМГТГ-аас ОХУ-ын "Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн орчуулгад тулгуурлан "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн төслийг боловсруулсан. Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан тус дүрмийн төслийг төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах хэлэлцүүлгийг Нээлттэй нийгэм форумтой хамтран 2018.03.21-ний өдөр зохион байгуулсан ба дүрмийн төсөлтэй холбоотой тодорхой санал, шүүмжүүдийг ирүүлсэн. Энэхүү дүрмийн орчуулгын эх хувь болох ОХУ-ын "Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм 2018 онд шинэчлэгдсэн, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018.06.21-ний өдрийн 27 дугаар тогтоолоор MNS ISO 45001:2018 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-Шаардлага, хэрэглэх заавар" стандартыг баталж, 2018.07.16-ны өдрөөс мөрдөж эхэлсэн, мөн манай улсын газрын тосны салбарт хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой олон улсын стандартууд, дүрэм, заавар, зааварчилгааг судлан нэгтгэх, дүрмийн төсөлд тусгах, уялдуулах зэрэг хүчин зүйлс, учир шалтгаантай холбоотойгоор тус дүрмийн төслийг орчин үеийн нөхцөл, байдалд нийцүүлэн боловсруулах хэрэгцээ, шаардлага тулгарсан. Иймд газрын тосны салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх олон улсын туршлага, стандарт, дүрэм журмын талаар суурь болон | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | харьцуулсан судалгаа хийж, холбогдох бичиг баримт, материалыг орчуулах, санал, дүгнэлт боловсруулах эрдэм шинжилгээ, судалгааны зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгүүлэх төсвийг УУХҮСайдын 2021 оны төсвийн багцад суулгаж, УУХҮЯамны ТНБД-ын 2021 оны А/01 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо тус судалгааны ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.<br>Тус сонгон шалгаруулалтад "Эрхэс сувд" ХХК шалгарч, зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээг 2021.11.20-ны өдөр байгуулж, ажлыг гүйцэтгэж байна. Мөн Канадын Мерит төслийн дэмжлэгтэйгээр газрын тосны салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх олон улсын туршлага, стандарт, дүрэм журмын талаарх судалгааг хамтран гүйцэтгэж байна.<br>Эдгээр судалгаа шинжилгээний ажлын үр дүн, тайланг нэгтгэн, дүрмийн төслийг боловсруулж байна. | | |
| 32 | 3 | 3 | **Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих**<br>**2021-01-29**<br>**Дугаар 2021.01.29**<br>3.3. Энэ хуульд заасан харилцааг нарийвчлан зохицуулах Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална. | Засгийн газрын 2021.08.11-ний өдрийн хуралдаанаар Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмын төслийг хэлэлцүүлж, 241 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100%<br><br>ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| | | | 2.6. Улсын Их Хурлын тогтоол | | | |
| 33 | 1 | 1 | **Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай**<br>**2012-01-05**<br>**Дугаар 2012 №01**<br>1.1.. 1.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай: 1.1. Газрын тос боловсруулах бага болон дунд хүчин чадлын үйлдвэрийг газрын тосны ордод түшиглэсэн байдлаар ойрын хугацаанд барьж байгуулах ажлыг түргэтгэх; | ҮАБЗ-ийн 2014.03.17-ны өдрийн хуралдаанаас газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах зөвлөмж гаргасан. БНЭУ-аас олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар шийдвэрлэж, Монгол Улсын70 Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд 2016.04.28-ны өдөр байгуулсан "Зээлийн ерөнхий хэлэлцээр"-ийг Монгол Улсын Их хурал 2017.05.31-ний өдөр соёрхон баталсан. Засгийн газрын 2017.03.20-ны өдрийн 92 дугаар тогтоолоор ГТБҮ-ийн төслийг хэрэгжүүлэх төрийн өмчит компанийг байгуулсан. Үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг БНЭУ-ын төрийн өмчит "Инженерс Индиа Лимитэд" компани боловсруулж, 2018 оны 11 дүгээр сард УУХҮЯамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэж, хүлээн авсан. Газрын тос боловсруулах үйлдвэр нь үндсэн технологийн 12 байгууламж болон дагалдах, туслах барилга байгууламжуудаас бүрдэнэ. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК нь Төслийн менежментийн зөвлөх (ТМЗ) үйлчилгээ үзүүлж буй Engineers India Limited компанитай хамтран | 100%<br><br>УИХ-ын тогтоолын заалт нь бүрэн хэрэгжээгүй, цаг хугацааны ач холбогдолгүй болсон, ҮАБЗ, УИХ, ЗГ-аас гарсан шийдвэрүүдээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | үйлдвэрийн анхдагч процессын байгууламжууд, хангамжийн систем, дагалдах байгууламж, цахилгаан станцыг Монгол орны нөхцөл, стандартын шаардлагад нийцүүлэн төлөвлөж, ерөнхий дизайн, инженерчлэлийн багц (Basic design engineering package, BDEP) болон суурь инженерчлэлийн зураг төсөл (Front End Engineering Design, FEED)-ийг боловсруулсан. Төслийн хүрээнд үйлдвэрийн гаднах дэд бүтэц (17,5 км тусгай зориулалтын хүнд даацын авто зам, 27,7 км салаа төмөр зам, дэд өртөөний барилга байгууламж, 18,2 км 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10кВ-ын дэд станц)-ийн барилга байгууламжийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр барьж байгуулан, 2019 оны 11 дүгээр сард ашиглалтад хүлээн авсан. Мөн газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл нь үндсэн 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд:<br>EPC-1: Технологийн бус барилга байгууламж<br>EPC-2: Анхдагч процессын болон дагалдах байгууламж<br>EPC-3: Үйлдвэрийн цахилгаан станц<br>EPC-4: Лицензит технологийн байгууламж<br>2021 оны жилийн эцсийн байдлаар EPC-2-ын тендерийг хүлээн авсан, EPC-3-ын хураангуй жагсаалтад орсон компаниудын дунд хэлэлцээ хийгдэж байгаа, EPC-4-ийн техникийн үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд EPC-1-ийн барилга угсралтын ажил 36,0%-ийн гүйцэтгэлтэй байна. | төслийн зорилго үйл ажиллагаа өөрчлөгдсөн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 34 | 1 | 2 | 1.2.. Дотоодын түүхий эдийг боловсруулах үйлдвэр барих санаачилга гаргаж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих замаар бензин, түлш шатахууныхаа хэрэгцээг хангах зорилтыг хэрэгжүүлэх; | Уул уурхайн яам /хуучнаар/-наас газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг нийт 15 компанид олгосон хэдий ч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хөрөнгө санхүүжилт, техник технологи болон зарим тодорхойгүй шалтгааны улмаас дорвитой ажил хийгдээгүй. Нүүрс шингэрүүлж шатахуун үйлдвэрлэхээр тусгай зөвшөөрөл авсан "Багануур Энержи Корпорэйшн", "Гермон Газ", “МАК Си Ти Эл” компаниуд тодорхой ажлууд хийж эхэлсэн ч үйл ажиллагаа нь удааширч зогссон. Заримыг дурдвал “Дархан-Газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК жилд 2 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дархан хотод, “Хэт” ХХК жилд 120 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорнод аймагт, “М-Ойл” ХХК жилд 300 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Улаанбаатар хот, Рашаант өртөөнд, “Сүмбэр Ойл” ХХК-ийн жилд 100 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, “М Ойл энд Жи” ХХК нь жилд 330 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорноговь аймгийн Зүүнбаянд тус тус барих төсөл ирүүлснийг яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. ҮАБЗ-ийн 2014.03.17-ны өдрийн 14/06 дугаар зөвлөмжөөр газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах зөвлөмж гарсантай холбогдуулан Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт | 100%<br><br>УИХ-ын тогтоолын заалт нь бүрэн хэрэгжээгүй, цаг хугацааны ач холбогдолгүй болсон, ҮАБЗ, УИХ, ЗГ-аас гарсан шийдвэрүүдээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн зорилго үйл ажиллагаа өөрчлөгдсөн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг байгуулах төслийг хэрэгжүүлж байна. | тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 35 | 2 | 3 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016-11-17 Дугаар 2016 №69** 2/2.. Түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах. (2/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:) | Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 хувь байна гэж хуульчилсан бөгөөд 2014 онд Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд болох Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт орших БХГ-97 талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд газрын тосны нөөц ашигласны төлбөр 7%, Дорнод аймгийн Тамсагийн сав газарт орших Тосон-Уул-XIX талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд газрын тосны нөөц ашигласны төлбөрийг шууд авахаар дурдаагүй хэдий ч Монгол Улсад ногдох хувь хэмжээнд нөөц ашигласны төлбөрийг хамаарахаар гэрээнд тусгасан байдаг, харин Тамсаг-XXI талбайн хувьд газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 7.5%-иар гэрээнд тусгаж өгсний дагуу экспортолж буй газрын тосноос нөөц ашигласны төлбөрийг гэрээнд заасны дагуу авч Улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна. УУХҮСайдын 2018 оны А/12 дугаар тушаалаар байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх хэлэлцээр хийх үүрэг бүхий ажлын хэсэг Гэрээлэгч компаниудтай хэлэлцээр хийж, холбогдох арга хэмжээг авч ажилласан бөгөөд хайгуулын үе шатанд хэрэгжиж буй бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг бүрэн шинэчилсэн. Харин газрын тосны ашиглалт, экспортын үйл ажиллагаа явуулж буй Гэрээлэгч компаниудтай удаа дараа хэлэлцээр хийсэн боловч Гэрээлэгч тал өнөөг хүртэл хөрөнгө оруулалтаа нөхөж аваагүй алдагдалтай ажиллаж байгаагаас гадна 2014 онд батлагдсан Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын холбогдох заалтууд нь хууль батлагдахаас өмнө БХГ байгуулсан Гэрээлэгчийн эрх ашиг, эдийн засгийн нөхцөл байдалд хохирол учруулах, сөрөг нөлөө үзүүлэхээр байгаа тул гэрээлэгч компанийн зүгээс нэгэнт байгуулсан гэрээг өөрчлөхгүй байх зарчмын байр суурийг тухай бүр илэрхийлсээр байна. Жилийн уулзалт бүрт уг асуудлыг хөндөж байгаа боловч үр дүнд хүрээгүй байна. | 70% | |
| | | | | 2.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | |
| 36 | 1 | 1 | **Валютын ханш, газрын тосны бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах талаар цаашид авах арга хэмжээний тухай** | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2013.02.07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр ГТБ-ниййг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр тусгасан. Мөн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т импортлогч нь "газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр импортлох" үүрэг | 100% Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2012-02-08**<br>**Дугаар 2012 №10 ЭЗБХ**<br>1.8.. Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн тоог ОХУ-ын болон бусад нийлүүлэгч компанийн тооноос хамааруулан цөөлөх, газрын тосны бөөний худалдаа эрхлэгч томоохон аж ахуй нэгжүүдээс уул уурхайн салбарын томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй шатахуунд онцгой албан татварын болон аливаа татварын хөнгөлөлтийг үзүүлэхгүй байх, газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаанд үнийг хямд, тогтвортой байлгах зорилгоор өрсөлдөөнийг дэмжих бусад бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | хүлээхээр хуульчилсан. Түүнчлэн УУХҮС-ын 2018.01.12-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлагдсан "Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам"-д ГТБ импортлох тусгай зөвшөөрлийг бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд олгох нэмэлт зохицуулалт оруулсан. Онцгой албан татварын тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу тус хуулийн 6.2-т заасан хэмжээгээр автобензин, дизелийн түлшийг импортлох үед онцгой албан татварыг авч байгаа тул уул уурхайн салбарын томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй шатахуунд онцгой албан татварын болон бусад аливаа татварын хөнгөлөлтийг үзүүлээгүй болно. | хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 37 | 2 | 2 | **Чиглэл өгөх тухай**<br>**2017-06-30**<br>**Дугаар 2017 №07 ЭЗБХ**<br>1.1/. Зээлийн ерөнхий хэлэлцээрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн явц, хэрэгжилтийн талаар хагас жил тутам Байнгын хороонд мэдээлэл хийж байх; | БНЭУ-ын Эксим банкны санал болгосон компаниудын дунд Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, УУХҮЯамны Төрийн нарийн бичгийн даргын 2017.05.26-ны өдрийн Б/208 дугаар тушаалаар байгуулагдсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, хэлэлцээр хийх" ажлын хэсэг 2017.06.06-ны өдөр "Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах шугам хоолой"-н нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахаар шалгарсан БНЭУ-ын Зөвлөх болох EIL компанийн төлөөлөгч нартай холбогдох уулзалтыг зохион байгуулж, гэрээний төсөл болон бусад асуудлуудаар хэлэлцээр хийсэн. Улмаар УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдлын байнгын хороодоор тус тус хэлэлцүүлж, Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу тус хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017.05.31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон баталсан. Төслийн хэрэгжилтийн явц, холбогдох танилцуулга мэдээллийг тухай бүр ЗГХЭГ-т танилцуулж байна. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 38 | 2 | 3 | 1.2/. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банк | ЗГ-ын тэмдэглэлийн дагуу уг асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлсэн. Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хоорондын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нарийвчилсан техник эдийн засгийн үнэлгээ, зээлийн эдийн засгийн үр нөлөө, эргэн төлөгдөх нөхцөл болон төслийн хэрэгжилтийн явцын талаар хэрэгжилтийг хангаж ажиллаж буй холбогдох яамд, байгууллагууд Байнгын хорооны хуралдаанд танилцуулах. | олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017.05.31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон баталсан. | Зээлийн хэлэлцээрийг соёрхон баталсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 39 | 3 | 4 | **Чиглэл өгөх тухай**<br>**2018-10-30**<br>**Дугаар 2018 №32 ЭЗБХ**<br>2.2/. Газрын тосны зарим төрлийн бэлэн болон завсрын бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах, экологийн ангилал, импортолж байгаа боомтоос хамааруулан автобензин, дизелийн түлшний албан татварыг ялгавартай тогтоох, шатахууны үнийн өгцөм хэлбэлзлийг онцгой албан татварын хувь хэмжээгээр тухай бүр шуурхай зохицуулах зэрэг асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | Тус заалтын хэрэгжилтийг хангах, автобензин, дизелийн түлшний Онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан, импортолж буй боомтоос хамааруулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд тус яамнаас Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2017 оны 12 дугаар сар, 2018 оны 12 дугаар сар, 2019 оны 03 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сар, 2021 оны 1 дүгээр сард тус тус Сангийн яаманд албан бичгээр явуулж, эрхлэх асуудлын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг хүргүүлж ажилласан. СЯ-наас тухай бүр дэмжих боломжгүй хариу ирүүлж байсан. Тухайлбал 2021.01.05-ны өдрийн 4-2/04 дүгээр албан бичгээр тус асуудал нь Засгийн газрын тухай хуулийн 20.4.6-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарахыг анхааруулж, уг саналыг цар тахлын эдийн засгийн үед авч үзэх боломжгүй тухай хариу ирүүлсэн. Иймд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2021 оны арга хэмжээний төлөвлөгөөнд автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан тогтоох эрх зүйн орчин бүрдүүлэх, агаарын чанар сайжруулах бусад Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг тусгуулан батлуулж, ОББҮХ-ны ажлын албатай хамтран ажилласан. ОББҮХ-ноос агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаар Засгийн газрын 2021.12.08-ны өдрийн хуралдаанд танилцуулсан ба Засгийн газрын 2021.12.08-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлээр Автобензин, дизель түлшний онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан тогтоох, Евро-5 стандартаас доош чанартай шатахууныг жижиглэнгээр худалдан борлуулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар судалж, Засгийн газрын хуралдаанд | 100%<br>Тогтоолын дагуу УУХҮЯ-наас шалтгаалах холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | танилцуулахыг холбогдох сайд нар болон Нийслэлийн Засаг даргад даалгасан. | | |
| 40 | 3 | 5 | 2.4/. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн олон талт эх үүсвэртэй байх бодлого баримтлах, Гашуунсухайт-Ганц модны боомтоор шатахуун импортлох ажлыг эхлүүлэх. | Манай улс БНХАУ-аас бага хэмжээний газрын тосны бүтээгдэхүүнийг зөвхөн Замын-Үүд боомтоор импортолж байгаа ба 2018 онд 52.6 мянган тонн, 2019 онд 53.58 мянган тонн, 2020 онд 75.0 мянган тонн, 2021 онд 79.2 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортолсон. БНХАУ-ын нийлүүлэгч "Чайна Ойл" компани болон Монголын шатахуун импортлогч компаниуд 2016 оноос Ганц Мод-Гашуун сухайт боомтоор шатахуун нийлүүлэх, импортлох талаар хэлэлцээр хийж бэлтгэл ажлыг хангах явцад Хятадын талын холбогдох байгууллагаас Ганц модны боомт дээр аюултай бүтээгдэхүүн тээвэрлэх автомашины тусгай зогсоол, гарах терминал байгуулах шаардлагатай гэсэн тул түр хугацаагаар хойшлуулсан. БНХАУ-ын "Чайна Ойл" компаниас 2018 оны 07 дугаар сард Гашуун сухайт боомтоор газрын тосны бүтээгдэхүүн Монгол Улс руу экспортлох асуудал нааштайгаар шийдвэрлэгдэж байгааг мэдэгдсэн. Үүнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэнгийн боомтоор автоцистернээр шатахуун импортлоход тухайн боомтуудын хил, гаалийн нөхцөл байдал, тусгай терминал байгуулах шаардлагатай эсэх, тээвэрлэлтийн асуудлаар ЗТХЯ, ГЕГ, Автотээврийн үндэсний төв зэрэг газруудаас тодруулга мэдээлэл авсан. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай хоёр улсын Зам, тээврийн яам хоорондын протоколд улс хоорондын аюултай ачаа тээвэрлэлт гүйцэтгэхэд "Г" төрлийн онцгой зөвшөөрөл авахаар заасан ба тус зөвшөөрлийг Автотээврийн үндэсний төвөөс олгож байгаа талаар ЗТХЯ-наас, Гашуунсухайт боомтоор шатахуун импортлоход гаалийн байгууллагын хүний нөөц, гаалийн хяналтын бүсийн нөхцөл шаардлага, эрх зүйн зохицуулалтын хувьд хүндрэл гарахгүй, бүх төрлийн шатахууны гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардлагатай гаалийн лаборатори одоогоор байхгүй байгаа боловч 2019 оны төсөвт тус боомтод гаалийн лаборатори байгуулахаар тусгагдсан талаар ГЕГ-аас мэдэгдсэн. Гашуунсухайт-Ганцмод боомтоор газрын тосны бүтээгдэхүүн импортлох асуудлаар 2019 оноос эхлэн БНХАУ-ын гол нийлүүлэгч Чайна ойл ХХК-тай удаа дараа уулзалт хэлэлцээр хийж, хил гаалийн бүрдүүлэлт, тээвэрлэлттэй холбоотой зөвшөөрөл, бичиг баримтын бүрдлийг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд М-Ойл компани болон Чайна ойл компаниудын хооронд байгуулсан шатахуун худалдах, худалдан авах гэрээний дагуу 2019 онд хятадын талын шатахуун тээврийн 4 автоцистернд хоёр талын тээврийн байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авсан боловч Хятадын талын боомтын аюултай ачаанд | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хяналт хийх талбайн бүтээн байгуулалттай холбоотойгоор тус асуудал түр хойшилсон. 2021 оны 2 дугаар сард Хятадын талын нийлүүлэгч Чайна ойл ХХК-тай хоёр талын газрын тосны бүтээгдэхүүний чиглэлийн хамтын ажиллагаа, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөлдөх цахим уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтын үеэр Гашуунсухайт-Ганц мод, Шивээхүрэн-Сэхэ, Булган-Такашикен болон бусад боомтуудаар шатахуун нийлүүлэх, импортлох боломж, нөхцөлийн талаар хэлэлцэж, мэдээлэл солилцсон. Хятадын талаас Гашуунсухайт-Ганц мод боомтоор дизелийн түлш экспортод гаргах, нэвтрүүлэх асуудал шийдэгдсэн ба одоогоор “КОВИД-19” цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор түр хүлээлтийн байдалд байгаа талаар мэдээлэл хийсэн. Булган-Такашикен боомтын хувьд өнгөрсөн жил хил, гаалийн бүрдүүлэлттэй холбоотой ажлууд хийгдсэн ба улс хоорондын аюултай ачаа тээвэрлэх “F” төрлийн зөвшөөрөл авах ажил хийгдэж байна. Энэ хүрээнд тус боомтоор шатахуун импортлохтой холбогдуулан “Шунхлай” ХХК, “М-Ойл” ХХК-ууд улс хоорондын аюултай ачаа тээвэрлэх “F” төрлийн зөвшөөрөл авах хүсэлтээ 2021 оны 4 дүгээр сард Автотээврийн үндэсний төвд гаргаж зөвшөөрөл авсан. Энэхүү зөвшөөрлийн хүрээнд 2021 оны 5 дугаар сард 6 автоцистернээр туршилтын тээвэрлэлт хийж, евро-5 стандартын дизелийн түлш импортолсон. Хэдийгээр хоёр талын холбогдох байгууллагуудын хүчин чармайлтын үр дүнд Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхэ боомтуудаар газрын тосны бүтээгдэхүүн импортлох асуудал ахицтай байгаа боловч тухайн боомтуудын ойр орчим газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шилжүүлэн ачих байгууламж байхгүйтэй холбоотойгоор импортын үйл ажиллагаанд тодорхой хүндрэлүүд үүсэхээр байна. Тухайлбал, Гашуунсухайт боомтоос хамгийн ойр зайд буюу Оюу толгойд байрлах М-Ойл ХХК-ийн 2000 м3 багтаамжтай газрын тосны бүтээгдэхүүний агуулах нь боомтоос 104 км зайд орших байгаа нь импортын хэмжээг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийг хурдан шуурхай зохион байгуулахад сөргөөр нөлөөлөхөөр байна. Мөн Хятад талын шатахуун тээврийн автоцистернүүд Монголын нутагт тээвэрлэлт явуулахад F төрлийн зөвшөөрөл авах, даатгал, бусад бичиг баримт бүрдүүлэх зэрэгт тодорхой хэмжээний зардал гаргахаар байгаа нь импортолж байгаа шатахууны өртгийг нэмэгдүүлж, дотоодод борлуулах шатахууны үнэд нөлөөлөх юм. Иймд Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутагт орших Шивээхүрэн, Ханбогд сумын нутагт орших Гашуунсухайт хилийн боомтуудаар БНХАУ-аас газрын тосны бүтээгдэхүүн импортлох нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдуулан дээрх боомтууд орших хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулах барьж, байгуулах зориулалтаар газар ашиглуулах тухай | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. | | |
| 41 | 3 | 6 | 3.. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд даалгасугай. | Автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан, боомтоос хамааруулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2019.09.07-ны өдрийн 01/2545 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 2.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 2.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | | |
| 2.е. Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 42 | 1 | 1 | **Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-01-08**<br>**Дугаар 2020_14**<br>2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан охин компанийг байгуулах, түүнд хөрөнгө оруулах, бүтээгдэхүүн нийлүүлэх сонирхол илэрхийлсэн гадаадын хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулж, дүнг 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | Засгийн газрын 2020.01.08-ны өдрийн 14 дүгээр тогтоол, мөн өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэл, УУХҮСайдын 2020.04.21-ний өдрийн А/81 тушаалыг үндэслэн төрийн өмчит "Эрчис ойл" ХХК-ийг үүсгэн байгуулсан. “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжтай холбоотой асуудлаар Оросын талтай хамтран ажиллах талаар “Эрчис ойл” ХХК, “РН-Аэро” ХХН-ийн хооронд тус тус цахим уулзалтуудыг тогтмол зохион байгуулж ажиллаж байна. Тус цахим уулзалтуудаар “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжтай холбоотой асуудлууд, тухайлбал Монгол улсын “Эрчис ойл” ХХК болон ОХУ-ын “РН-Аэро” ХХН-ийн хамтын ажиллагааны хэлбэр, хамтарсан компани байгуулахтай холбоотой хувь эзэмшил, хэлбэр, гэрээний хугацаа, үйл ажиллагааны эхлэл төсвийн хэмжээ, хүний нөөц, бүрэлдэхүүн, сумалгааны тариф, агаарын хөлгийн түлшний хил үнэ, зах зээлийн өрсөлдөөн, шатахууны олон талт эх үүсвэр, зээлийн эргэн төлөлт, агаарын тээвэрлэгч нарын худалдан авах ажиллагаа, ТС-1 төрлийн агаарын хөлгийн түлшний борлуулалтын талаар тус тус хэлэлцсэн болно.<br>Үүний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2021.10.06-ны өдрийн хуралдаанаар “Эрчис ойл” ХХК болон “РН-Аэро” ХХН хооронд байгуулах хамтын ажиллагааны гэрээний төсөл болон "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн талаар танилцуулах шийдвэрийг гаргасан. Үүнтэй холбогдуулан "Эрчис ойл" ХХК-ийн зүгээс УУХҮЯ болон ОХУ-ын “Роснефть” НХН-ийн хооронд байгуулах санамж бичгийн төслийг боловсруулж, талууд солилцоод байна. Мөн Монгол | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Улсын Засгийн газрын 2021.11.17-ны өдрийн 60 дугаар тэмдэглэлд тусгаснаар “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.2-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэх шийдвэр гаргуулсан.<br>2021.11.22-ны өдрийн Ардын намын бүлгийн хурлаар хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой танилцуулгыг хэлэлцүүлж, холбогдох байнгын хороодоор яаралтай хэлэлцүүлэх шийдвэрийг гаргуулсан.<br>Улмаар 2021.11.29-ний өдөр УИХ-ын даргад “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг өргөн барьсан болно. | | |
| 43 | 2 | 2 | **Журам батлах тухай**<br>**2021-03-17**<br>**Дугаар 2021_68**<br>2. “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. 2. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгасугай. | Журам батлагдсантай холбогдуулан тус журамд заасны дагуу газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээний үлгэрчилсэн загвар, мэдээ тайлан гаргах маягтын загварыг УУХҮСайдын 2021.04.28-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар баталсан. Тус тушаал, журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллах тухай 2021.04.30-ны өдрийн 01/1150 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн ба журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100% | |
| 44 | 3 | 3 | **Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**<br>**2021-03-24**<br>**Дугаар 2021_74**<br>1. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлт, Оросын Холбооны Улсаас нийлүүлж буй шатахууны импортын үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор дотоодын зах зээл дээр борлуулж буй шатахууны хангамж доголдож болзошгүй нөхцөл байдал үүссэн тул өргөн хэрэглээний АИ-92 автобензиний хангамжийн | Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу улсын нөөцийг нэмэгдүүлэх АИ-92 төрлийн автобензиний худалдан авалтын ажлыг зохион байгуулахыг төрийн өмчит “Монгол ГТБҮ” ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл болон “Эрчис ойл” ХХК-нд чиглэл болгосон.<br>УУХҮЯ, АМГТГ, "Эрчис ойл" ХХК-ийн бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулж худалдан авах ажиллагааг зарласан. Эхний худалдан авах ажиллагаанд нэг ч оролцогч материал ирүүлээгүй бөгөөд хоёр дахь удаагийн худалдан авах ажиллагаанд нэг оролцогч оролцсон боловч ирүүлсэн материал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуульд заасан тендерийн баримт бичиг ирүүлээгүй, шаардлагад нийцээгүй уг тендерийг зогсоож, дахин зарлаагүй. Үүнээс гадна 2021 оны 1 дүгээр сараас хойш ОХУ-аас нийлүүлэх бүтээгдэхүүний хилийн үнэ 60%-аас 72%-иар өссөн тул | 100%<br>УУХҮЯ-ны зүгээс холбогдох ажлыг зохион байгуулсан, хэрэгжилт тооцох боломжгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтвортой байдлыг хангах ажлын хүрээнд тус бүтээгдэхүүний улсын нөөцийг 30,000 (гучин мянга) тонноор нэмэгдүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т тус тус үүрэг болгосугай. | худалдан авах ажиллагааг зохион байгуулах нь ач холбогдолгүй болсон. | | |
| 45 | 3 | 4 | 3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 2022 онд нэмж бүрдүүлэхэд шаардагдах зардлын санхүүжилтийг Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 2022 онд нэмж бүрдүүлэхэд шаардагдах зардлын санхүүжилтийг Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулан 2021.05.31-ний өдрийн 01/1380 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 100% | |
| 46 | 4 | 5 | **Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах эрх олгох тухай**<br>**2021-07-07**<br>**Дугаар 2021_203**<br>2. Газрын тосны хайгуулын "Гурвантэс XXXV" талбайд уламжлалт бус газрын тосны (нүүрсний давхаргын метан хий) үйл ажиллагаа явуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээг "Тэлмэн ресурс" ХК-тай холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах эрхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т олгосугай.<br>2. Энэ тогтоол болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд тус тус хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгасугай. | Газрын тосны хайгуулын "Гурвантэс XXXV" талбайд уламжлалт бус газрын тосны (нүүрсний давхаргын метан хий) үйл ажиллагаа явуулах талаарх Бүтээгдэхүүн хуваах гэрээг Ашигт малтмал, газрын тосны газар болон "Тэлмэн ресурс" ХК хооронд 2021.07.27-ны өдөр байгуулсан. | 100% | |
| 47 | 5 | 6 | **Газрын тосны хайгуулын талбай олгох тухай**<br>**2021-08-25**<br>**Дугаар 2021_266** | Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд газрын тос хайх тусгай зөвшөөрлийг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д хууль тогтоомжийн дагуу олгох асуудлын хүрээнд Давст XXXI талбайд хамаарах хайгуул, судалгааны ажлын тайлан, материал, мэдээллийг | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд газрын тос хайх тусгай зөвшөөрлийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д хууль тогтоомжийн дагуу олгох, хайгуулын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т даалгасугай. | хүлээлцэх ажил хийгдэж байгаа бөгөөд уг ажлыг хийж дуусган актаар хүлээлцсэний дараа “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу газрын тос хайх тусгай зөвшөөрлийг олгох асуудлыг шийдвэрлэнэ. | | |
| 48 | 5 | 7 | 3. Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд хамаарах хайгуул, судалгааны ажлын тайлан, материал, мэдээллийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д шилжүүлэх арга хэмжээ авахыг Үндэсний геологийн алба (О.Чулуун), Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн), “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК (Д.Алтанцэцэг)-д тус тус үүрэг болгосугай. | Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд хамаарах хайгуул, судалгааны ажлын тайлан, материал, мэдээллийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д шилжүүлэх талаар УУХҮСайдын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2772, 01/2773, 01/2774 дүгээр албан бичгүүдээр АМГТГ, ҮГА болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-т тус тус чиглэл хүргүүлээд байна. Мэдээлэл, тайлан хуулбарлах ажил хийгдэж байна. | | 100% |
| 49 | 6 | 8 | **Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц тогтоох тухай 2021-10-06 Дугаар 2021_311**<br>2. Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн 2022 оны компанийн нөөцийн хэмжээ, бүтээгдэхүүний нэр, төрлийг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | Тус тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 28 аж ахуйн нэгжүүд 2022 онд 45 хоногийн нөөц буюу нийт 193500 тонн компанийн нөөц бүрдүүлэхээр тогтоосон. Засгийн газрын тогтоолоор компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн аж ахуйн нэгжүүдэд 45 хоногийн компанийн нөөцийг биетээр бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд арилжааны банкуудаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох ажлыг Монголбанктай хамтран зохион байгуулж байна. Мөн 2022 онд бүрдүүлэх компанийн нөөц өмнөх жилүүдээс нэмэгдэж 45 хоногийн нөөц бүрдүүлэхээр тогтоосон тул холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх шаардлага тулгарсан. Иймд Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журмыг шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авахаар төслийг 2021.12.27-ны өдөр УУХҮЯ-ны цахим хуудсанд байршуулаад байна. | | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт даалгасугай. | | | |
| | | | **2.ё. Ерөнхий сайдын захирамж** | | | |
| | | | **2.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | |
| 50 | 1 | 1 | **2020 оны 2 дугаар сарын 12-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2020-02-12 Дугаар 2020_9** XYI.5. . Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаас Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх дотоодын түүхий тосыг дамжуулах хоолойгоор тээвэрлэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан төслийн санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр дамжуулах хоолойн санхүүжилтийг шийдвэрлэх санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Засгийн газрын 2020.02.19-ний өдрийн хуралдаанаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар танилцуулга хийж 11 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Дээрх шийдвэрийн дагуу тус яамнаас дамжуулах хоолойн санхүүжилтийн талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаанаар танилцуулж өгөх хүсэлтийг УУХҮСайдын 2020.02.17-ны өдрийн 01/464 дүгээр болон 2020.04.10-ны өдрийн 01/1002 дугаар албан бичгүүдээр Сангийн сайдад хандсан. Дамжуулах хоолойд хөрөнгө оруулах, барьж байгуулах ажлыг гүйцэтгэх компанийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар шалгаруулах талаар ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төслийг 2020.12.09-ний өдрийн хуралдаанд танилцуулж 69 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Уг тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу УУХҮЯамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.01.25-ны өдрийн А/08 дугаар тушаалаар "Түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах" Үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хороо мэргэжил, санхүүгийн чадавхтай олон улсын компаниудыг тендерт оролцуулах зорилгоор урьдчилсан сонголтын урилгын зарыг АНУ-ын “Gulf Publishing” компанийн “Pipeline and Gas Journal” сэтгүүл болон вебсайтад нийтэлсэн бөгөөд урьдчилсан сонголтод 9 улсын 22 компани оролцох хүсэлтээ ирүүлсэн. Эдгээрээс шалгуур хангасан 15 компанид тендерийн баримт бичгийг 2021.04.23-ны өдөр хүргүүлсэн. Тендерийг 2021.10.23-ны өдөр нээж шалгаруулалтыг хийж захиалагчаас тендерт оролцогчдод мэдэгдэл хүргүүлсэн. Шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахаар ажиллаж байна. | 100% Дараагийн шийдвэрүүд гарч хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 51 | 2 | 2 | **2020 оны 2 дугаар сарын 19-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2020-02-19 Дугаар 2020_11** XIX.1. . Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын | Уг тэмдэглэлийн дагуу тус яамнаас дамжуулах хоолойн санхүүжилтийн талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаанд танилцуулж өгөх хүсэлтийг УУХҮСайдын 2020.02.17-ны өдрийн 01/464 дүгээр албан бичгээр хандсан. СЯ-ны 2020.03.03-ны өдрийн 8-3/1247 дугаар албан бичигт уг төсөл нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан байх шаардлагыг хангаагүй тул Өрийн удирдлагын тухай хуулийн 33.11-д заасныг үндэслэн өрийн баталгаа гаргахгүйгээр шийдвэрлэх талаар хариу ирүүлсэн. Дээрх албан бичгийн хариуг 2020.04.10-ны өдрийн | 100% Дараагийн шийдвэрүүд гарч хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг дор дурдсан Засгийн газрын гишүүдэд даалгав: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт: 2.1. Санхүүгийн эх үүсвэр шийдэгдэж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэний дараа бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах. | 01/1002 дугаар албан бичгээр ЗГ-ын 2019 оны 290 дүгээр тогтоолоор уг төсөл нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан тул зохих дэмжлэг үзүүлэх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн. Газрын тос дамжуулах хоолойг барих төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын урилга, туршлагын талаарх маягтуудад санал авахаар 2020.12.04-ний өдрийн 01/2971 дүгээр албан бичгээр СЯ-нд хандаж саналыг 2020.10.04-ний өдрийн 6-1/7563 дугаар албан бичгийг хүлээн авсан. Мөн газрын тос дамжуулах хоолойг барих төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах танилцуулгыг 2020.12.09-ний өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулж 69 дүгээр тэмдэглэл гаргуулсан. | тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 52 | 3 | 3 | **2020 оны 3 дугаар сарын 19-ний өдөр 18 дугаар тэмдэглэл 2020-03-19 Дугаар 2020_18** III.2. . Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т даалгав: 1. Дэлхийн зах зээл дээр түүхий газрын тосны үнэ буурч байгаатай холбогдуулан Монгол Улсад шатахууны жижиглэнгийн үнийг үе шаттайгаар бууруулах; 2. Шатахууны үнэ хямд байгаа үед шатахууны улсын нөөцийг нэмэгдүүлэх талаар зохих арга хэмжээ авах. | ОХУ-ын “Роснефть” компаниас нийлүүлж буй шатахууны 2020 оны 04 дүгээр сарын хилийн үнэ өмнөх сартай харьцуулахад А-80, Аи-92, Аи-95, Аи-98 автобензин тонн тутамдаа 209 ам.доллар, дизелийн түлш тонн тутамдаа 187 ам.доллароор буурсан ба А-80 автобензин 330 ам.доллар/тн, Аи-92 автобензин 360 ам.доллар/тн, Аи-95 автобензин 430 ам.доллар/тн, Аи-98 автобензин 480 ам.доллар/тн, дизелийн түлш 369 ам.доллар/тн болж тус тус буурсан. Үүнтэй холбоотойгоор 4 дүгээр сарын 13-наас эхлэн шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд шатахууны жижиглэнгийн үнийг 300-350 төгрөгөөр үе шаттайгаар бууруулсан ба шатахууны жижиглэнгийн үнэ дунджаар А-80 автобензин 1390 төгрөг, Аи92 автобензин 1470 төгрөг, Аи95 автобензин 2000 төгрөг, ДТ 2150 төгрөг болж тус тус буурсан. Шатахууны улсын нөөцийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам”-ыг Засгийн газрын 2021.03.17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба 68 дугаар тогтоолоор журмыг баталсан. Мөн газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын 2021.03.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн, 74 дүгээр тогтоолоор улсын нөөцийг 30000 тонноор нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. | 100% Дараагийн шийдвэрүүд гарч хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 53 | 4 | 4 | **2020 оны 8 дугаар сарын 5-ны өдөр 43 дугаар тэмдэглэл 2020-08-05 Дугаар 2020_43** YI.4. 5. Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөлд зохион байгуулах түр журмын дагуу газрын тосны экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт) болон тухайн боомт байрлах аймгийн Засаг дарга болон Онцгой комиссын дарга нарт. | Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд өөрийн аймгийн нутаг дэвсгэрт орших хилийн боомтоор явагдах газрын тосны экспортын тээвэрлэлтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх үйл ажиллагааг холбогдох талуудтай хамтран зохион байгуулж, холбогдох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн, хамтран ажиллах тухай 2020.08.13-ны өдрийн 01/1977 дугаар албан бичгийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар нарт тус тус хүргүүлсэн. Баянхошуу болон Бичигт боомтоор явагдаж буй газрын тосны экспортын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байгаа ба өнөөдрийн байдлаар дээрх боомтуудаар явагдаж буй газрын тосны экспортын тээврийг 48 автоцистернээр гүйцэтгэж байсныг нэмэгдүүлэн, өдөрт 70-74 автоцистерн болгон нэмэгдүүлээд байна | 100%<br><br>Дотоод хяналтандаа авч ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 54 | 4 | 5 | YI.5. . Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан "Зээлийн ерөнхий хэлэлцээр"-ийн хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж, түүнтэй хэлэлцээ хийж дууссан талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажлыг сонгон | Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ын ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан БНЭУ-ын "JMC Projects (India) Ltd" компанитай 2020.10.13-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. | 100%<br><br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгаруулалтын нөхцөл, хэлэлцээний үр дүн, зайлшгүй шаардлагатай бусад шаардлагыг харгалзан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт даалгав. | | | |
| 55 | 5 | 6 | **2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл 2020-11-04 Дугаар 2020_58** XҮI.2. ". Монгол Улсын Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, газрын тос дамжуулах хоолойн төслийн техникийн даалгаврыг боловсруулах, сонгон шалгаруулалт зарлах боломжтой эсэхийг судлан танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК (Д.Алтанцэцэг) нарт; | Дамжуулах хоолойд хөрөнгө оруулах, барьж байгуулах ажлыг гүйцэтгэх компанийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар шалгаруулах талаар ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төслийг 2020.12.09-ний өдрийн хуралдаанд танилцуулж 69 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус барилгын ажил /EPC-I/-ын гүйцэтгэл 2021.12.15-ны өдрийн байдлаар 36.0%-ийн гүйцэтгэлтэй байна. /EPC-II /, /EPC-III/ багц ажлын тендер шалгаруулалт дуусаж ерөнхий гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулах шатанд байна. Тос дамжуулах хоолойн гүйцэтгэгчийг олон улсын сонгон шалгаруулалтаар шалгаруулж мөн гэрээ байгуулах шатанд байна. | 100% | |
| 56 | 5 | 7 | XҮI.2. 6. Автобензин, дизель түлшний онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах чиглэлээр Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2017 оны 12 дугаар сар, 2018 оны 12 дугаар сар, 2019 оны 03 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сар, 2021 оны 1 дүгээр сард тус тус Сангийн яаманд хүргүүлж ажилласан. СЯ-аас тухай бүр татгалзсан хариу ирүүлж байсан бөгөөд 2021.01.05-ны өдрийн 4-2/04 дүгээр албан бичгээр тус асуудал нь Засгийн газрын тухай хуулийн 20.4.6-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарахыг анхааруулж, уг саналыг цар тахлын эдийн засгийн үед авч үзэх боломжгүй тухай хариу ирүүлсэн. Иймд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2021 оны арга хэмжээний төлөвлөгөөнд автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан тогтоох эрх зүйн орчин бүрдүүлэх, агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг тусгуулан батлуулж, ОББҮХ-ны | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажлын албатай хамтран ажилласан. ОББҮХ-ноос агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаар Засгийн газрын 2021.12.08-ны өдрийн хуралдаанд танилцуулсан ба Засгийн газрын 2021.12.08-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлээр Автобензин, дизель түлшний онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан тогтоох, Евро-5 стандартаас доош чанартай шатахууныг жижиглэнгээр худалдан борлуулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох сайд нар болон Нийслэлийн Засаг даргад даалгасан. | | | |
| 57 | 5 | 8 | XYI.2. 7. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт. | Монгол Улсын Ерөнхий сайд УИХ-д газрын тосны салбарын талаар танилцуулга хийхтэй холбогдуулан БХГ-ний хэрэгжилт, салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж, УУХҮСайдын 2021.05.21-ний өдрийн 01/1335 дугаар албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга Ж.Энхбаярт хүргүүлсэн. | | 100%<br><br>Дотоод хяналтандаа авч ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 58 | 6 | 9 | **2020 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 69 дүгээр тэмдэглэл 2020-12-09 Дугаар 2020_69**<br>XYI.8. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт дотоодын түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барьж байгуулах гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулах талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрт дотоодын түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барьж байгуулах гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд олон | УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021.01.25-ны өдрийн А/08 дугаар тушаалаар "Түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах" Үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хороо мэргэжил, санхүүгийн чадавхтай олон улсын компаниудыг тендерт оролцуулах зорилгоор урьдчилсан сонголтын урилгын зарыг АНУ-ын "Gulf Publishing" компанийн "Pipeline and Gas Journal" сэтгүүл болон вебсайтад нийтэлсэн бөгөөд урьдчилсан сонголтод 9 улсын 22 компани оролцох хүсэлтээ ирүүлсэн. Эдгээрээс шалгуур хангасан 15 компанид тендерийн баримт бичгийг 2021.04.23-ны өдөр хүргүүлсэн. Тендерийг 2021.10.23-ны өдөр нээж БНХАУ-ын Норинко интэрнэйшнл коопэрэйшн лимитэд компанийг шалгаруулсан. Шалгарсан компанитай байгуулах гэрээний хэлцлийг шуурхай зохион байгуулж, эцэслэн боловсруулсан гэрээний төслийг даруй ирүүлэх чиглэлийг 2022.01.31-ний өдрийн 01/242 дугаар албан бичгээр МГТБҮ ТӨХХК-д хүргүүлээд байна. Гэрээ байгуулах хэлцэл хийгдэж байна. | | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | улсад нээлттэй сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй байгуулах гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | | | |
| 59 | 7 | 10 | **2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 73 дугаар тэмдэглэл 2020-12-23 Дугаар 2020_73**<br>XIX.4. . Стратегийн ач холбогдол бүхий өргөн хэрэглээний АИ-92 автобензинийн үнийг тогтвортой хадгалах зохицуулалтын хүрээнд санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан үнийг тогтворжуулах гэрээний хэрэгжилт болон олон улсын зах зээл дээрх үнийн өсөлтөөс шалтгаалан, дотоодод үүсэх эрсдэлийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан өргөн хэрэглээний АИ-92 автобензиний жижиглэнгийн үнийг тогтворжуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт даалгав. | Санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан бүх төрлийн шатахуун, дизель түлшний жижиглэнгийн үнийг тогтворжуулах боломж нөхцөлийг судлах, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, дүнг тухай бүр танилцуулж ажиллах чиглэл хүргэх тухай 2020.12.03-ны өдрийн 01/2963 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн.<br>Өнгөрсөн оны 11 дүгээр сараас эхлэн тодорхой хүчин зүйлсийн нөлөөллөөр дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ тасралтгүй өссөн ба үүнийг дагаад ОХУ-аас манай улсад нийлүүлж буй газрын тосны бүтээгдэхүүний импортын үнэ сар бүр нэмэгдэж ирсэн.<br>Иймд газрын тосны бүтээгдэхүүний хангамж, гадаад зах зээлийн нөхцөл байдал, жижиглэн борлуулалтын үнэ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, холбогдох танилцуулгыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮСайдын 2021.03.01-ний өдрийн 01/460 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Өргөн хэрэглээний АИ-92 автобензиний үнийг тогтворжуулах, хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх, харилцааг зохицуулах "Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам"-ыг Засгийн газрын 2021.03.17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба 68 дугаар тогтоолоор журмыг баталсан.<br>Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээний үлгэрчилсэн загвар, мэдээ тайлангийн маягтын загварыг УУХҮСайдын 2021.04.28-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар баталсан. Тус тушаал, журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллах тухай 2021.04.30-ны өдрийн 01/1150 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн ба журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>Мөн газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын 2021.03.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба ЗГ-ын 74 дүгээр тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 30000 тонноор | 100%<br><br>Дараагийн шийдвэрүүд гарч хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу улсын нөөцийг нэмэгдүүлэх АИ-92 төрлийн автобензиний худалдан авалтын ажлыг зохион байгуулахыг төрийн өмчит “Монгол ГТБҮ” ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл болон “Эрчис ойл” ХХК-д чиглэл болгосон. Үүний дагуу улсын нөөцийн 30000 тонн АИ-92 автобензинийг худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. | | |
| 60 | 8 | 11 | **2021 оны 2 дугаар сарын 14-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2021-02-14 Дугаар 2021_10** I.2. 19. Халдварт цар тахлын хүндрэлтэй нөхцөлд бүх төрлийн шатахуун, дизель түлшний жижиглэнгийн үнийг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Засгийн газрын 2021.02.14-ний өдрийн 10 дугаар тэмдэглэлийн 19 дүгээр заалтын дагуу газрын тосны бүтээгдэхүүний хангамж, гадаад зах зээлийн нөхцөл байдал, жижиглэн борлуулалтын үнийн талаарх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, холбогдох танилцуулгыг бэлтгэж, УУХҮСайдын 2021.03.01-ний өдрийн 01/460 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100% | |
| 61 | 8 | 12 | I.2. 21. Хариуцсан салбартаа тулгамдаж байгаа асуудалтай газар дээр нь биечлэн танилцаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд. | Түүнчлэн тус салбарт нэн яаралтай тулгамдаж байгаа асуудалгүй бөгөөд шийдвэрлэж болохуйц асуудалд тухай бүр арга хэмжээ авч ажиллаж байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус барилгын ажил /EPC-I/-ын явц байдалтай газар дээр нь танилцах ажлаар 2021.08.02, 2021.11.14-15-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дахь төслийн талбайд ажиллаж барилга угсралт, бараа материалын татан авалтад үүсч байсан саатал, бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллав. | 100% | |
| 62 | 9 | 13 | **2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14** XII.4. 4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолой барих санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, сонгон шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, тус бүтээн байгуулалтын ажлыг ойрын үед эхлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул | ЗГ-ын 2020 оны 69 дүгээр тэмдэглэлээр газрын тос боловсруулах үйлдвэрт дотоодын түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барьж байгуулах гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй байгуулах гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг СС, УУХҮС нарт даалгасан. Үүний дагуу УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021.01.25-ны өдрийн А/08- дугаар тушаалаар "Түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах" Үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хороо сонгон шалгаруулалтыг зохион байгуулж тендерийг 2021.10.23-ны өдөр нээж гүйцэтгэгчийг шалгаруулсан. Шалгарсан компанитай байгуулах гэрээний хэлцлийг шуурхай зохион байгуулж, эцэслэн | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт, Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг ОХУ болон бусад улсаас нийлүүлэх боломжийг судлахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | боловсруулсан гэрээний төслийг даруй ирүүлэх чиглэлийг 2022.01.31-ний өдрийн 01/242 дугаар албан бичгээр МГТБҮ ТӨХХК-д хүргүүлээд байна. Гэрээ байгуулах хэлцэл хийгдэж байна. | | |
| 63 | 10 | 14 | **2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2021-03-10 Дугаар 2021_17** XII.7.6. "Чингис хаан" олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг хангуулах, агаарын хөлгийн шатахууныг олон эх үүсвэрээс нийлүүлэх болон "Жет А-1" төрлийн түлш импортлох боломжийг судалж шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Иргэний нисэхийн ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн өмчит "Эрчис ойл" ХХК-тай хамтран Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын шатахуун хангамжийн байгууламжийг ашиглах санал ирүүлсэн хөрөнгө оруулагчтай гэрээ, хэлэлцээр хийх бэлтгэл ажлын хүрээнд гэрээлэгчтэй хамтран ажиллах зарчмыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2021.03.12-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2020.01.08-ны өдрийн шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай 14 дүгээр тогтоолын дагуу шинэ олон улсын нисэх буудлын шатахуун хангамжтай холбоотой үйл ажиллагааг эрхлэх зорилгоор "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн дэргэд "Эрчис ойл" ХХК-ийг 2020.04.22-ны өдөр үүсгэн байгуулсан. Мөн УУХҮСайдын 2021.03.15-ны өдрийн А/50 дугаар тушаалаар төрийн өмчит "Эрчис ойл" ХХК-тай хамтран "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийг хамтран ашиглах санал ирүүлсэн гадаадын хөрөнгө оруулагчтай гэрээ, хэлэлцээр хийх бэлтгэл ажлын хүрээнд гэрээлэгчтэй хамтран ажиллах зарчмыг тодорхойлох үүрэг бүхий ХЗДХЯ, УУХҮЯ, ЗТХЯ, ИНЕГ, "Эрчис ойл" ХХК-ийн төлөөлөл бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг уг шатахуун хангамжийн байгууламжийг ашиглаж болох боломжит хувилбаруудаас сонгон ОХУ-ын "РН-Аеро" ХХК-тай гэрээ, хэлэлцээрийг хийж байна. | 70% | |
| 64 | 11 | 15 | **2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2021-07-07 Дугаар 2021_41** XXYII.2.. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаа болон охин компаниудын өнөөгийн байдал, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд аудит хийсэн дүн, Ажлын хэсгийн дүгнэлтийг Монгол Улсын сайд, | Газрын тосны хайгуулын Матад XX талбайн Цэн Тогоруу ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэн, зөвлөлийн 2020.12.25-ны өдрийн СТР-02-01 дүгээр дүгнэлтийг үндэслэн, УУХҮСайдын 2021.03.02-ны өдрийн "Матад-XX талбайн нөөц бүртгэх тухай" А/36 дугаар тушаалаар газрын тосны нөөцийг "баталгаат (1P)" зэрэглэлээр 1,151,194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137,931.0 тонн (1.04 сая баррель)-оор, "баталгаат+магадлалтай (2P)" зэрэглэлээр 3,051,724.0 тонн (23.01 сая баррель)-оор, "баталгаат+магадлалтай+боломжтой (3P)" зэрэглэлээр 5,385,942.0 тонн (40.61 сая баррель)-оор ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий газрын тосоор тогтвортой тасралтгүй, найдвартай хангах судалгаа, тооцоог хийж, нөөц болон олборлолтыг өсгөх ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав; | | | | |
| 65 | 12 | 16 | **2021 оны 7 дугаар сарын 28-ны өдөр 44 дүгээр тэмдэглэл 2021-07-28 Дугаар 2021_44** Х.1. 2. . Эдийн засаг, стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн тээвэрлэж буй ачаа барааны талаарх мэдээлэл хүсэлтийг Замын-Үүд хилийн Боомтын зөвлөлд тухай бүр хүргүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт даалгав. | Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр Дорноговь аймгийн Алтаншираэ сумын нутагт хэрэгжүүлж буй стратегийн чухал ач холбогдол бүхий газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн технологийн бус барилга байгууламжийн ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын Жэй Эм Си Прожектс компанийн захиалгатай 445 тонн арматурын төмөр болон 30 тонн барилгын хэв хаш бүхий ачаа, бараа БНХАУ-ын Эрээн боомтын гаалийн талбайд тодорхой хугацаанд саатсан. Үүнтэй холбогдуулан эдийн засаг, стратегийн ач холбогдол бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай БНХАУ-ын Эрээн боомтын гаалийн талбайд саатаад байгаа ачаа, барааг татан авах тээврийн хэрэгслийг улсын хилээр түргэн шуурхай нэвтрүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллах тухай 2021.08.24-ний өдрийн 01/2074 дүгээр албан бичгийг Замын-Үүд хилийн Боомтын зөвлөлд явуулсан. Эдийн засаг, стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй 9 аж ахуйн нэгж, байгууллагын 104 авто тээврийн хэрэгсэл чиргүүлийн хамт, 18 вагон тээвэрлэж буй ачаа барааны талаарх хүсэлтийг Боомтын зөвлөлд тухай бүр уламжилж шуурхай шийдвэрлэх арга хэмжээг авч ажилласан. | | 100% | |
| 66 | 13 | 17 | **2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 45 дугаар тэмдэглэл 2021-08-04 Дугаар 2021_45** XII.5. . Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, гадаад зах зээлийн нөхцөл байдал, жижиглэн борлуулалтын үнэ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. | Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 30,000 (гучин мянган) тонноор нэмэгдүүлэх, АИ-92 автобензинийн жижиглэнгийн үнийг зохих түвшинд бууруулах, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн хэлбэлзлээс дотоодын зах зээлийг хамгаалах, дунд хугацаанд үнийг тогтворжуулах арга хэмжээний талаарх санал, шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газрын 2021.08.18-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Засгийн газрын 2021.08.18-ны өдрийн 47 дугаар тэмдэглэлээр шатахууны үнийг тогтворжуулах сан байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт, санхүүжилтийн эх үүсвэрийн талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнтэй холбогдуулан газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 30,000 (гучин мянган) тонноор нэмэгдүүлэх, АИ-92 автобензинийн жижиглэнгийн үнийг зохих төвшинд бууруулах, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн хэлбэлзлээс дотоодын зах зээлийг хамгаалах, дунд хугацаанд үнийг тогтворжуулах арга хэмжээний талаарх саналаа шийдвэрийн төслийн хамт боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасан. | | | |
| 67 | 14 | 18 | **2021 оны 8 дугаар сарын 18-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2021-08-18 Дугаар 2021_47** XIY.5. . Шатахууны үнэ тогтворжуулах сангийн үйл ажиллагаа болон бусад улс орны туршлага, эрх зүйн орчин, хүрэх үр дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан шатахууны үнийг тогтворжуулах сан байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт, санхүүжилтын эх үүсвэрийн талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | Үүнтэй холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл, шатахууны үнэ тогтворжуулах сангийн зохион байгуулалт, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын төсөл боловсруулах, сангийн хөрөнгийг Газрын тосны бүтээгдэхүүний онцгой албан татвар болон газрын тосны экспортоос улсын төсөвт төвлөрүүлж буй орлого болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх эрх зүйн боломж, нөхцөлийг судалж санал, дүгнэлт гаргах хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллуулах саналыг 2021.09.03-ны өдрийн 01/2150 дугаар албан бичгээр Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нарт хүргүүлсэн. Шатахууны үнэ тогтворжуулах сан байгуулах асуудал нь эрх зүйн орчин бүрдүүлэх, сангийн санхүүжилтийг тодорхойлох, сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам боловсруулах зэрэг өргөн хүрээтэй судалгаа, салбар хоорондын хамтын ажиллагаа, зөвшилцөл шаардлагатай тул хамтарсан ажлын хэсгийг яаралтай байгуулж ажиллуулах шаардлагатай байгаа болно. | | 30% | |
| 68 | 15 | 19 | **2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 52 дугаар тэмдэглэл** | БНХАУ-ын "Петрочайна Интернэйшнл" ХХК-ийн Хөх хотын газрын тос боловсруулах үйлдвэрээс худалдан авахаар захиалсан 43,440 тонн шатахуун /автобензин 33,300 тонн, дизелийн түлш 10,140 тонн/ ачсан | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **2021-09-22** **Дугаар 2021_52** IX.2.2. Шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд эхний ээлжинд Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас худалдан авсан 43,440 тонн шатахуун (авто бензин 33,300 тонн, дизелийн түлш 10,140 тонн) ачсан 724 вагонцистерны төмөр замын тээвэрлэлт болон цаашид хийгдэх тээвэрлэлтийг саадгүй явуулах асуудлыг хятадын талын холбогдох эрх бүхий байгууллагад тухай бүр нь уламжлаж, шийдвэрлүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | 724 вагонцистернийг Хятадын төмөр замын хуваарьт оруулах, төмөр замын тээвэрлэлтийг саадгүй явуулах асуудлыг Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол Улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яамтай хамтран Хятадын талын холбогдох байгууллагад уламжилж, холбогдох арга хэмжээ авч ажилласан. Үүний үр дүнд Хятадын тал Монгол Улс руу АИ-92 автобензин тээвэрлэх 200 вагоныг тус улсын 09 дүгээр сарын төмөр замын хуваарьт нэмэлтээр оруулж, тээвэрлэлтийг тусгай горимоор зохион байгуулж, 50 вагонцистернтэй 4 цуваагаар Эрээн боомтод 2021.09.25-28-ны өдрүүдэд татан ирж, хил нэвтрүүлсэн. Үлдсэн 524 шатахуун ачсан вагонцистернийг Хятадын төмөр замын 10 дугаар сарын хуваарьт оруулах асуудлаар Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол Улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яамтай хамтран Хятадын талын холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлсэн. Хятадын тал нийт 524 вагонцистернийг Хөх хотын төмөр замын 10 дугаар сарын хуваарьт үе шаттайгаар 3 хуваан оруулж, тээвэрлэлтийг хэвийн горимоор саадгүй зохион байгуулсан. | | | |
| 69 | 15 | 20 | IX.2.3. Замын-Үүд боомтоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас импортлох шатахууны тоо, хэмжээ нэмэгдэж байгаатай холбогдуулан Эрээн боомтод ирсэн шатахуун ачсан вагонцистерныг яаралтай татан авах, шилжүүлэн ачих, буцаах, гаалийн бүрдүүлэлт хийх, дотоодын төмөр замаар тээвэрлэх ажлыг нэн яаралтай горимоор шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Замын-Үүд хилийн Боомтын зөвлөл, “Улаанбаатар төмөр зам” ХНН (И.В.Милостных), “Шингэн түлш | БНХАУ-аас Эрээн боомтод 2021.09.25-28-ны өдрүүдэд ирсэн АИ-92 автобензин бүхий 200 вагонцистернийг яаралтай татан авах, гаалийн бүрдүүлэлт хийх, шилжүүлэн ачих вагонцистерний цуваа бүрдүүлэх, бэлтгэл ажлыг хангах, шилжүүлэн ачих, хоосон вагонцистернийг буцаах, Замын-Үүд боомтоос дотоодын төмөр замаар шуурхай тээвэрлэн Улаанбаатар хотод авч ирэх, агуулахад буулгах, хуваарилах зэрэг ажлыг Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол Улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яам, ГЕГ, Улаанбаатар төмөр зам, Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж, ААН-үүд болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран шуурхай зохион байгуулж, тус асуудлаар холбогдох байгууллагуудын төлөөлөл Замын-Үүд боомтод ажилласан. 2021.09.26-29-ний өдрүүдэд Замын-Үүд боомтоор 50 вагонцистерн бүхий 4 цуваг шуурхай татан авч, гаалийн бүрдүүлэлтийг шуурхай горимоор гүйцэтгэн, шилжүүлэн ачих ажлыг “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ бүх хүчин чадал, нөөц боломжоо дайчлан шилжүүлэн ачиж, дотоодын 180 вагоноор 2021.09.28-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хот руу явуулсан. Энэхүү зохион байгуулалтын үйл ажиллагаа нь АИ-92 автобензины тасалдал, хомстлыг арилгахад тодорхой үр нөлөө үзүүлсэн. 2021 оны 10 дугаар сард БНХАУ-аас нийт 524 шатахуун ачсан вагонцистернийг татан авах, гаалийн бүрдүүлэлт хийх, шилжүүлэн ачих вагонцистерний цуваа | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шилжүүлэн ачих байгууламж" Төрийн өмчит үйлдвэрийн газар (Г.Гансүх)-т; | бүрдүүлэх, бэлтгэл ажлыг хангах, шилжүүлэн ачих, хоосон вагонцистернийг буцаах, Замын-Үүд боомтоос дотоодын төмөр замаар тээвэрлэн Улаанбаатар хотод авч ирэх, агуулахад буулгах, хуваарилах зэрэг ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгуулсан. Тус арга хэмжээ нь манай улсын АИ-92 автобензины хангамжийг тогтворжуулах, нөөцийг бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан болно. | | | |
| 70 | 15 | 21 | IX.2.4. Замын-Үүд дэх "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж"-ийн хүчин чадалтай холбоотойгоор импортоор орж ирсэн шатахууны тодорхой хувийг авто замаар тээвэрлэх зохицуулалтын арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн), Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд), "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" Төрийн өмчит үйлдвэрийн газар (Г.Гансүх)-т | "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ нь Замын-Үүд боомтоор импортоор орж ирсэн шатахууныг шилжүүлэн ачих ажлыг бүх нөөц, хүчин чадлаа ашиглан, ердийн үеийн ачааллыг 3-4 дахин нэмэгдүүлж, онцгой горимоор шуурхай гүйцэтгэж, дотоодын вагонцистернд ачих, УБ төмөр зам ХНН нь шилжүүлэн ачих вагонцистерний цуваа бүрдүүлэх, бэлтгэл ажлыг хангах, хоосон вагонцистернийг буцаах, дотоодын төмөр замаар тээвэрлэх хуваарийг гарган, нарийн зохион байгуулалттай ажилласан тул шатахууныг авто замаар тээвэрлэх шаардлага гараагүй болно. | | 100% | |
| 71 | 15 | 22 | IX.2.5. Шатахууны нийлүүлэлт хангамжийн асуудал хэвийн болох хүртэлх шатахууны нөөцийг татан, түгээлтийг шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй ярьж хүндрэл багатай зохион байгуулах зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т; | 2021.09.22-ны өдрийн байдлаар Улсын хэмжээнд үлдээд байсан АИ-92 автобензины үлдэгдэл, нөөцийг эхний ээлжийн импорт, татан авалт орж ирэх хүртэлх хугацаанд зохистой, оновчтой хуваарилах, түгээх, импортоор орж ирсэн бага хэмжээний шатахууныг жигд хуваарилахтай холбогдуулан үлдэгдлийн мэдээг УБ хот, аймаг, сум, дүүрэг, агуулах, ШТС тус бүрээр нарийвчлан гаргаж, улсын хэмжээнд борлуулалтын сүлжээ бүхий томоохон аж ахуйн нэгжүүдтэй өдөр бүр уулзалт хийж, хуваарилалт, түгээлтийн төлөвлөгөөг хамтран боловсруулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. | | 100% | |
| 72 | 15 | 23 | IX.2.7. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн асуудлаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд. | Гадаад хүчин зүйлсээс шалтгаалан 2021 оны 9 дүгээр сарын сүүлчээр газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтэд тасалдал, хомстол үүсэх нөхцөл байдалд хүрсэн нь цаашид газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөц, хэмжээг нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага тулгарсан. Иймд газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс санал авч, Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн хэмжээг 45 хоногийн хэрэглээний нөөцтэй байхаар тохиролцсон. Газрын тосны | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн 2022 оны компанийн нөөцийн хэмжээ, бүтээгдэхүүний нэр, төрлийг тогтоох асуудлыг Засгийн газрын 2021.10.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2021.10.06-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 28 аж ахуйн нэгжүүд 2022 онд 45 хоногийн нөөц буюу нийт 193500 тонн компанийн нөөц бүрдүүлэхээр тогтоосон. | | |
| 73 | 16 | 24 | **2021 оны 10 дугаар сарын 6-ны өдөр 54 дүгээр тэмдэглэл 2021-10-06 Дугаар 2021_54** ҮI.2. Шатахууны эрсдэлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль болон хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулан, 2021.10.07-ны өдрийн 01/2431 дугаар албан бичгээр Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн. Хуулийн төслийг холбогдох яамд дэмжээгүй, үзэл баримтлалыг хамтран батлаагүйтэй холбоотойгоор Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага хангагдаагүй тул ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх боломжгүй болсон. | 100% УУХҮЯ-ны зүгээс хуулийн төслийг боловсруулсан, ХЗДЯ, СЯ дэмжээгүй тул заалтыг ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 74 | 16 | 25 | ҮIII.2. Хуульд заасан УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээ, Засгийн газраар батлагдсан тус яамны үйл ажиллагааны стратегийн 2.5.5.3-т заасныг хэрэгжүүлж газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн компанийн нөөц бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Тус тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 28 аж ахуйн нэгжүүд 2022 онд 45 хоногийн нөөц буюу нийт 193500 тонн компанийн нөөц бүрдүүлэхээр тогтоосон. Засгийн газрын тогтоолоор компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн аж ахуйн нэгжүүдэд 45 хоногийн компанийн нөөцийг биетээр бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд арилжааны банкуудаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох ажлыг Монголбанктай хамтран зохион байгуулж байна. Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн компанийн нөөц бүрдүүлэх талаар гэрээний загварыг УУХҮ-ийн сайдын 2022 оны 02 сарын 01-ний өдрийн А/18 дугаар тушаалаар батлуулан аж ахуйн нэгжүүдтэй АМГТГ гэрээг байгуулан, хяналт тавьж ажиллаж байна. | 100% | |
| 75 | 16 | 26 | ҮIII.3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журмын дагуу газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн мэдээ, борлуулалтын тайлан, нөөцийн үлдэгдлийн балансыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Уул уурхай, хүнд | Өнөөдрийн байдлаар Улсын хэмжээнд Засгийн газрын эрсдэлийн сан болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2012 онд бүрдүүлсэн 10191,7 тонн зуны дизелийн түлш, 2538,8 тонн нь АИ-92 автобензин нийт 12730,6 тн улсын нөөцийн шатахууныг сэлгэн хадгалах гэрээний дагуу нэр бүхий аж ахуйн нэгжүүд хадгалж байна. | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлдвэрийн сайд Г.Ёндонд үүрэг болгов. | | | | |
| 76 | 16 | 27 | XIII.5. . Засгийн газрын 2020 оны 14 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон тулгарч байгаа зарим асуудлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Эрчис Ойл” ХХК болон “РН-Аэро” ХХК хооронд байгуулах хамтын ажиллагааны гэрээний төсөл болон Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаарх саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавартай холбогдуулан УУХҮЯ болон Роснефть НХН хооронд байгуулах Санамж бичгийн төсөл болон Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаарх авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын 2021.12.14-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Засгийн газрын 2021.12.14-ний өдрийн хуралдааны 64 дүгээр тэмдэглэлээр Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн үйл ажиллагааг эрхлэх хамтарсан компани байгуулах тухай УУХҮЯ болон Роснефть НХН хоорондын харилцан ойлголцлын Санамж бичигт импортыг хамтарсан компаниар хийх тохиолдолд дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг эхний ээлжид борлуулах нөхцөлийг тусгах арга хэмжээ авахыг УУХҮСайд Г.Ёндонд даалгасан. | | 100% | |
| 77 | 17 | 28 | **2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55** XY.13.2. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэргэдэх “Эрдэнэс газ” төслийн нэгжийг татан буулгаж, төрийн өмчийн хувьцаат компани байгуулах шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Хаянхярваад; | "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2021.12.07-ны өдрийн хурлаар "Эрдэнэс Газ" төслийн нэгжийн үйл ажиллагааг хэлэлцэж уг төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх судалгааны ажлыг эрчимжүүлэх, шинээр хуулийн төсөл боловсруулах, гэрээ, хэлэлцээрийн төслийг бэлтгэх, мөн тусгай зориулалтын компанийн үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг төслийн удирдагчид даалгаж шийдвэрлэсэн. | | 100% | |
| 78 | 18 | 29 | **2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2021-11-03 Дугаар 2021_58** | Засгийн газрын 2020.12.23-ны өдрийн 232 дугаар тогтоолоор байгуулагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн хуралдааныг 2021.11.19-ний өдөр зохион байгуулж, | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | XII.6.8. Гадаад зах зээлийн шатахууны үнийн хэт өсөлтөөс хамаарсан дотоодын жижиглэнгийн үнийн огцом хэлбэлзлийг бууруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | шатахууны хангамжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, гадаад хүчин зүйлсээс хамаарч дотоодод борлуулах шатахууны жижиглэнгийн үнийн огцом хэлбэлзлийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, холбогдох зөвлөмжийг гаргасан. Тус хуралдаанаас өргөн хэрэглээний Аи-92 автобензиний хангамж, нөөцийг Засгийн газрын холбогдох тогтоолд заасан хэмжээгээр бүрдүүлж, тус бүтээгдэхүүний жижиглэн борлуулалтын үнийн өөрчлөлтийг огцом хэлбэлзэлгүйгээр, зах зээлийн горимд аажмаар шилжүүлэх бодлого баримтлан ажиллахыг УУХҮЯ, АМГТГ болон шатахууны худалдаа эрхлэгч ААН-үүдэд зөвлөмж болгосон. Мөн Аи-92 автобензиний жижиглэн борлуулалтын үнийн өөрчлөлтийг огцом хэлбэлзэл үүсгэхгүйгээр сүүлийн 6 сарын хөдөлгөөнт дундаж үнээр тооцож өөрчлөлт оруулах, цаашид үе шаттайгаар зах зээлийн горимд аажмаар шилжүүлэх нь зүйтэй гэж үзсэн. | | | |
| 79 | 19 | 30 | **2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл 2021-12-08 Дугаар 2021_63** XY.3.1.2. Бусад салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний инфляцид үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд; | Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн 2022 оны компанийн нөөцийн хэмжээ, бүтээгдэхүүний нэр, төрлийг баталсан. Үүнтэй холбоотой 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр УУХҮ-ийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, Арилжааны банкуудын хамтарсан “Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдэд шатахууны нөөц бүрдүүлэх зорилгоор олгох санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г эцэслэсэн. Үүний үр дүнд Монголбанкны хөнгөлөлттэй зээлийг компанийн нөөц бүрдүүлэгч 28 аж ахуйн нэгжид олгох нөхцөл бүрдсэн. Үүнээс 18 аж ахуйн нэгжийн хүсэлтийг шийдвэрлэн, 399,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна. Шатахууны гадаад зах зээлийн үнийн огцом өсөлтөөс сэргийлэх, тасалдал хомстол үүсэхгүй байх нөхцөл тодорхой хэмжээгээр бүрдээд байна. | | 100% | |
| 80 | 19 | 31 | XY.5.4. Автобензин, дизель түлшний онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, Евро-5 ангиллаас доош чанартай шатахууныг жижиглэнгээр худалдан борлуулахыг үе шаттай хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал | ОХУ-аас манай улсад нийлүүлж буй Евро-5 стандартын шатахууны импортын үнэ ердийн шатахууны үнээс тонн тутамдаа төрлөөс хамааран 25-60 ам.доллараар өндөр байдгаас шалтгаалан Евро-5 стандартын шатахууны жижиглэн борлуулалтын үнэ литр тутамдаа ердийн шатахуунаас 100-150 төгрөгөөр өндөр байдаг. Үнийн энэхүү зөрүүг багасгах, Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээг дэмжих хүрээнд автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох шаардлага тулгарч ирсэн. УУХҮЯ-наас Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулан 2017 оны 12 дугаар сар, 2018 оны 12 дугаар сар, 2019 оны 03 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сар, 2021 оны 02 дугаар сарууд тус тус Сангийн яаманд хүргүүлж байсан | | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | жуулчлалын сайд Н.Уртнасан, Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | бөгөөд хуулийн төсөл, үзэл баримтлал, тооцоо судалгааг бүрэн боловсруулсан.<br>Мөн автотээврийн хэрэгслээс ялгаруулах агаарын бохирдлыг үр дүнтэй бууруулахын тулд Агаарын чанарыг сайжруулах бүсэд экологийн Евро-5 ангиллын стандартын шаардлагад хангаагүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлага тулгарч ирсэн. УУХҮЯ нь Агаарын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулан 2020 оны 09 дүгээр сард БОАЖЯ-нд хүргүүлж байсан.<br>Дээрх хуулийн төслүүдийг дахин хянан үзэх, үндэслэл, тооцоо судалгааг нарийвчлах чиглэлээр холбогдох яамд, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороотой хамтран ажиллаж байна. Хэрэгжих шатанд. | | | |
| 81 | 20 | 32 | **2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 64 дүгээр тэмдэглэл**<br>**2021-12-14**<br>**Дугаар 2021_64**<br>XIY.11. . Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон “Роснефть” НХН хооронд байгуулах харилцан ойлголцлын санамж бичгийн төсөл болон “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн үйл ажиллагааг эрхлэх хамтарсан компани байгуулах тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон “Роснефть” НХН хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт импортыг хамтарсан компаниар хийх тохиолдолд дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг эхний | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон “Роснефть” НХН хооронд байгуулах харилцан ойлголцлын санамж бичигт “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн үйл ажиллагаа явуулах хамтарсан компани нь дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг эхний ээлжид борлуулах нөхцөлийг тусгах талаар хоёр тал зарчмын тохиролцоонд хүрч, Санамж бичгийн төсөлд тусгаад байна. | | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эзлжид борлуулах нөхцөлийг тусгах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | | | | |
| | 34 | 52 | Газрын тосны бодлогын дундаж: 94.1 хувь | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| САЛБАР ЧИГЛЭЛ: 3. УУЛ УУРХАЙН БОДЛОГО | | | | | | | |
| 3.а. Монгол Улсын хууль | | | | | | | |
| 82 | 1 | 1 | **Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/** 2006-07-08 **Дугаар 2006.08.26** 3.2.. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална. | Засгийн газрын 2017.05.24-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг батлуулж, мөрдөж байна. Бичил уурхайн эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хууль бусаар ашигт малтмал олборлох, бичил уурхайн эрх зүйн орчныг буруугаар ашиглах явдал байсаар байна. Сум, дүүргийн засаг дарга нар эрх мэдлээ хэтрүүлэн дүгнэлт гараагүй талбайд гэрээ байгуулах, журамд тусгасан тоног төхөөрөмжийн хүчин чадлыг хэтрүүлэн ажиллуулах зэргээр бичил уурхайн журмыг дагаж мөрдөхгүй байгаа нь журмын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Дээрх хууль бус асуудлыг зохицуулах, улмаар таслан зогсоох талаар Засгийн газраас удаа дараа арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй. 2019.09.18-ны өдөр 355 дугаар "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай", 2020.01.15-ны өдрийн 17 дугаар "Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолууд тус тус гарсан.<br>Засгийн газрын 355 дугаар тогтоолын 1.1-д "Бичил уурхай эрхлэгч этгээдэд тавигдах шаардлагыг хангахгүй болсон, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдийн гэрээг цуцлах, бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох дүгнэлт гарсан талбайд бичил уурхай эрхлэх гэрээ шинээр байгуулахгүй байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасан"-аас үүдэн бичил уурхайн гэрээ одоог хүртэл шинээр байгуулахгүй байгаа.<br>Засгийн газрын 17 дугаар тогтоолтой холбогдуулан УУХҮСайдын 2020.11.09-ний өдрийн А/279 дүгээр тушаалаар "Бичил уурхайн зохицуулалтын талаар" Ажлын хэсэг байгуулагдан журмын шинэчлэл дээр ажиллаж байна. | | 100% | |
| 83 | 2 | 2 | **Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан** | Засгийн газрын 2015.03.30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор баталсан "Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай**<br>**2009-07-16**<br>**Дугаар 2009.07.16**<br>2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тухайн аймгийн Засаг дарга гэрээ байгуулж, хяналтыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ. | явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам"-ын дагуу гэрээ байгуулсан 38 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2020 оны гэрээний хэрэгжилтийг 2021.02.02-ны өдөр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, геологи уул уурхайн хяналтын газрын Геологи уул уурхайн хяналтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч С.Батмөнх-Эрдэнэ (МХЕГ, ГУУХХ), улсын ахлах байцаагч Д.Сансардарьмаа (МХЕГ, ГУУХХ), Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах шинжээч Б.Буяннэмэх (БОАЖЯ, ХБОБНУГ), ахлах мэргэжилтэн М.Отгонтөгс (БОАЖЯ, ОУТГЗКХ), Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, судалгааны хэлтсийн мэргэжилтэн Д.Маасүрэн (АМГТГ, УУСХ), мэргэжилтэн Г.Дөл (АМГТГ, УУСХ) нар хуралдаж гэрээг дүгнэсэн.<br>- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын дагуу 2021 онд 2 тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй /Шарын гол ХК, Мон-Ажнай ХХК/ олон талт гэрээ байгуулж, 1 тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах шатандаа явж байна.<br>- Мөн эзэмшигч нь өөрчлөгдсөн 3 аж ахуйн нэгжтэй гэрээг шинэчлэн байгуулахаар ажиллаж байна.<br>Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.15, 25.1.7 дахь заалтын дагуу 2021 онд шинээр ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 45 тусгай зөвшөөрлийн талбай бүрд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг өргөдлийн материалд хавсарган авч шийдвэрлэсэн байна. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 25.1.6 дахь заалтын дагуу тухайн компани үйл ажиллагаа явуулахдаа байгальд сөрөг нөлөө үзүүлсэн эсэх талаар орон нутгийн Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн тодорхойлолтыг хүлээн авч ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэхдээ хяналт тавьж ажиллав. | | |
| 84 | 2 | 3 | 3 дугаар зүйл. Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загварыг Засгийн газар батална. Уг журам, гэрээнд тусгай зөвшөөрөл | "Журам, гэрээний загвар батлах тухай" Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам" болон 2 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу 38 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан гэрээг 2021.02.02-ны өдөр сунгав. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эзэмшигчээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг 100 хувь урьдчилан байршуулах нөхцөл, хяналт тавих төрийн байгууллагын албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тус тус тусгасан байна. | | | |
| 85 | 3 | 4 | **Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай /Шинэчилсэн найруулга/ 2013-01-31 Дугаар 2013.03.04**<br>6.3.. Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын болон шинжээчийн эрх олгох, сунгах, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Журмыг УУХҮСайдын 2021.08.04-ний өдрийн А/202 дугаар тушаалаар батлуулж, ХЗДХЯ-наас Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021.10.14-ний өдрийн 5493 дугаарт бүртгүүлсэн. | 100% | |
| 86 | 3 | 5 | 17.3.. Монгол Улсад ашиглах үзвэрийн болон хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийн жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | УУХҮСайдын 2017 оны А/80 дугаар тушаалаар “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах, “Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг тус тус боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд дараах ажлыг гүйцэтгээд байна. Үүнд:<br>“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг боловсруулан ЗГ-ын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд мөрдөн ажиллаж байна.<br>ЗГ-ын 2020 оны 175, 2021 оны 128 дугаар тогтоолуудаар “Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг батлуулсан бөгөөд жагсаалтыг жил бүр шинэчлэн батлуулдаг тул энэ жилийн жагсаалтыг батлуулахаар яамдуудаас санал авч байна.<br>Пиротехникийн асуудлаар ЗГ-ын 2016 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан хуучин дүрмийг мөрдөн ажиллаж байна. | 70% | |
| 87 | 3 | 6 | 17.6.. Пиротехникийн хэрэгслийн мэргэжилтний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн | УУХҮСайдын 2017 оны А/80 дугаар тушаалаар “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах, “Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт"-ыг тус тус боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд дараах ажлыг гүйцэтгээд байна. Үүнд: "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийг боловсруулан ЗГ-ын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд мөрдөн ажиллаж байна. ЗГ-ын 2020 оны 175, 2021 оны 128 дугаар тогтоолуудаар "Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт"-ыг батлуулсан бөгөөд жагсаалтыг жил бүр шинэчлэн батлуулдаг тул энэ жилийн жагсаалтыг батлуулахаар яамдуудаас санал авч байна. Пиротехникийн асуудлаар ЗГ-ын 2016 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан хуучин дүрмийг мөрдөн ажиллаж байна. | | | |
| 88 | 3 | 7 | 5.2.. Засгийн газар энэ хуулийн 5.1.5-д заасан жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн жил бүр шинэчлэн тогтооно. (5.1.5.Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалтыг батлах;) | Жагсаалтыг 2021.05.05-ны өдөр Засгийн газрын 2021 оны 128 дугаар тогтоолоор батлуулсан. Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 79 аж ахуйн нэг, байгууллага Засгийн газрын 2021 он 128 дугаар тогтоолоор баталсан жагсаалтын дагуу үйл ажиллагаа явуулж, улирал бүр тайлангаа УУХҮЯ-нд ирүүлж байна. | | 100% | |
| 116 | 3 | 5 | I.3. Үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, агаарын бохирдлыг бууруулах төслүүд /Тавантолгойн цахилгаан станц, нүүрс баяжуулах, кокс-химийн, төрөл бүрийн сайжруулсан түлшний үйлдвэр, метан хийн болон дамжуулах хоолойн төслүүд, тэдгээртэй холбоотой бусад барилга байгууламж/ | 1. Үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, кокс-химийн үйлдвэр байгуулах хүрээнд:<br>ЭБМЗ-ийн 2021.03.05-ны өдрийн БҮ-2021-01-03 дугаар дүгнэлтээр ТиТи Си Өү Кей И ХХК-ийн захиалгаар Ти Ти Си Өү Кей И ХХК болон ThyssenKrupp Uhde группын хамтран боловсруулсан Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт байрлах жилд 2 сая тонн кокс үйлдвэрлэх хүчин чадалтай “Коксын үйлдвэр”-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг; ЭБМЗ-ийн 2021.07.06-ны өдрийн БҮ-2021-02-02 дугаар дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2021.07.27-ны өдрийн 1/144 дугаар тушаалаар Энержи ресурс ХХК-ийн захиалгаар Белохоризонт ХХК-ийн боловсруулсан “Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Ухаа худаг ордыг түшиглэн байгуулах жилд 1 сая тонн хүчин чадалтай коксын үйлдвэр”-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг;<br>ЭБМЗ-ийн 2021.10.15-ны өдрийн БҮ-2021-03-02 дугаар дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2021.10.28-ны өдрийн 1/205 дугаар тушаалаар Баян кокс энержи ХХК-ийн захиалгаар уул уурхайн зураг, төслийн Гүрэн ХХК-ийн боловсруулсан, Төв аймгийн Баян сумын нутагт хэрэгжүүлэх “Металлургийн кокс, цэвэр эрчим хүчний үйлдвэрийн | | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | цогцолбор" төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг тус тус хүлээн авч Геологийн баримтын төв архивт хүлээлгэн өгсөн байна.<br>Тавантолгойн ордыг түшиглэн "Кокс-Эрчим хүчний үйлдвэрийг байгуулах ТЭЗҮ, БОННҮ-г боловсруулж, батлуулах"-аар "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд 231.0 сая төгрөгийг төсөвлөөд байна.<br>2. "Тавантолгой цахилгаан станц"-ын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоолоор "Тавантолгой цахилгаан станц" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан. Улмаар Засгийн газрын 2020 оны "Тавантолгой дулааны цахилгаан станц төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 175 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийн нийт хувьцааны 30 хувийг зохих журмын дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-д эзэмшүүлэхээр тогтсугай" гэж заасан.<br>"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-д үйл ажиллагааны санхүүжилт хэлбэрээр 5.6 тэрбум төгрөг шилжүүлсэн бөгөөд "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийн дүрэмд нийт хувьцааны 30 хувийг "Эрдэнэс Тавантолгой" ХК эзэмшиж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлнэ гэж тусгасан ч "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн болон "Тавантолгой дулааны цахилгаан станц" хооронд хувьцаа эзэмшигчдийн гэрээ хийгдээгүй байна.<br>"Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК нь Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц, 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугамын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад хүлээлгэн өгөх ажлын гүйцэтгэгч шалгаруулах тендерийг 2021.10.21-ний өдөр зарласан бөгөөд 2022.01.19-ний өдөр нээж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.<br>Дээр дурдсан тендерийн үр дүнгээс хамаарч хөрөнгө оруулалт дүнд өөрчлөлт орж болзошгүй тул санхүүжилтийн гэрээ хийгдээгүй байгаа ба дүн тодорхой болмогц Хувьцаа эзэмшигчдийн гэрээ, санхүүжилтийн гэрээг эцэслэн байгуулахаар төлөвлөж байна.<br>2. Засгийн газрын 2021 оны "Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай" 113 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу 2021 оны 3 дугаар улиралд багтаан эхлүүлж, 2023 онд ашиглалтад оруулахыг Уул уурхай, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай” гэж заасан.<br>Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг БНХАУ-ын “Чайна металлуржикал инженеринг компани” /CMEC/ боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021.04.01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, бүртгүүлсэн.<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс “Чайна металлуржикал инженеринг” компанитай байгуулсан гэрээний дагуу 2 дугаар шатны ажил болох нүүрс баяжуулах үйлдвэрийн FEED буюу урьдчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 2021 оны 8 дугаар сард дуусган хүлээж авсан байна. 2021.08.13-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 956,447,866,100 төгрөгийн өртөг бүхий тендерийг зарласан бөгөөд 2021.09.27-ны өдөр нээсэн. Тендерийн хугацаанд нийт 20 газар тендерийн бичиг баримт авснаас дөрвөн газар оролцохоор материалаа ирүүлсэн боловч тендер шалгаруулалтын хүчинтэй хугацаа дуусгавар болсон учир амжилтгүй болсон. Улмаар 2021.11.15-ны өдөр дахин тендер зарласан бөгөөд 2021.12.15-ны өдөр хааж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ хэлцэл хийж ажил үргэлжилж байна. | | |
| 117 | 3 | 6 | I.6. Ил уурхайн ашиглалтын өртөг, зардлыг бууруулж, олборлолтыг нэмэгдүүлэх чиглэлд далд уурхайн ашиглалтын технологийг нэвтрүүлэх боломжийг судлах | Уурхайн гүн ихсэж, шинээр байгуулсан овоолго хүрэх тээвэрлэлтийн зай нэмэгдсэнтэй холбоотойгоор тээврийн өртгийг бууруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх болон тоосжилтыг бууруулж, байгаль орчинд сөрөг нөлөө багатай орчин үеийн дэвшилтэд техник, технологийн нэг болох “Мөчлөг-урсгал технологи” буюу авто-конвейерийн иж бүрэн системийг уурхайд нэвтрүүлэх шаардлагатай болсон. 2018 оноос хойш “Конвейерийн системийн олон улсын шаардлагад нийцсэн ТЭЗҮ, FEED” боловсруулах олон улсын тендерийг зарласан боловч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зүйл заалтаас шалтгаалан өдийг хүртэл гүйцэтгэгч сонгон шалгараагүй байна.<br>Иймд төслийг компанийн уул уурхайн технологи хариуцсан газарт төвлөрүүлэн Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөх, эрдэмтдээр баг бүрдүүлэн “Авто-конвейерийн иж бүрэн систем нэвтрүүлэх ТЭЗҮ”-ийг боловсруулахаар ажиллаж байна.<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК нь жилд 70 сая.$м^3$ уулын цулыг хөдөлгөх хүчин чадал бүхий техник, тоног төхөөрөмжийг ирэх 3 жилд худалдан авахаар төлөвлөж байна. Энэ нь төслүүдийн нийт хүчин чадлын 20-25%-ийг бүрдүүлнэ. Компанийн өөрийн өмчлөлийн операторын техник, | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тоног төхөөрөмжтэй болж, олборлолтын нэг $м^3$ уулын цулын ажлын нэгж өртгийг 10% орчим хувиар бууруулна гэж тооцож байна.<br>2021 онд 130 тонны даацтай Белаз 75135 маркын 12 ширхэг автосамосвал, CATD8 маркын 1 ширхэг бульдозер, Liebherr PR764 маркын 1 ширхэг бульдозер, CAT14 загварын 1 ширхэг автогрейдер, Белаз 78231 маркын 1 ширхэг дугуйт түрэгчийг худалдан авч уурхайд нийлүүлэн нийт олборлолтын 5 хувийг өөрийн техник, тоног төхөөрөмжийг ашиглан гүйцэтгэсэн. 12 м3 утгуурын багтаамжтай Liebherr 9200 загварын 2 ширхэг экскаватор, 7 м3 утгуурын багтаамжтай Liebherr 9100 загварын 2 ширхэг экскаваторуудын гэрээ хийгдэж, уурхайд нийлүүлэгдэхээр хүлээгдэж байна.<br>"Эрдэнэс Тавантолгой" ХК 2017-2020 онд Цанхи, Бортээг болон Оорцогийн хэсгүүдэд нарийвчилсан болон урьдчилсан хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Уг хайгуулын ажлаар 1000м торлол бүхий гүний цооногуудыг байрлуулж дээрх нөөцийн талбайнуудын уул геологийн ерөнхий структурыг тодорхойлсон байдаг. Тус хайгуул судалгааны ажлын үр дүнгийн тайланг боловсруулж ордын хэмжээний 3 хэмжээст загварчлалын ажлыг 2023 оны эхний улиралд багтаан ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. | | |
| 118 | 3 | 7 | 2. Эрдэнэс-Тавантолгой хувьцаат компанийн бие даан болон бусад этгээдтэй хамтран хөрөнгө оруулж, санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг энэ тогтоолын 1 дэх заалтад тусгагдсанаар хэрэгжүүлэх, тэдгээрийг тус компанийн борлуулалтын орлого болон гадаад дотоод зах зээлд үнэт цаас гаргах, зээл авах, нүүрс урьдчилан борлуулах зэрэг эдийн засгийн үр ашигтай нөхцөлөөр санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай. | 2021 онд "Эрдэнэс-Тавантолгой" ХК нь стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготой 2 их наяд хүртэлх төгрөгийн болон ам.долларын бонд гаргах хүсэлтийг Монголын хөрөнгийн биржид хүргүүлж Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо хянаж, холбогдох зөвшөөрлийг олгосны үндсэн дээр 2 удаагийн арилжааг хийж нийт 856.0 тэрбум төгрөг, 172.8 сая ам.долларын хөрөнгийг татан төвлөрүүлсэн. | 70% | |
| 119 | 3 | 8 | 3. Төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, санхүүжилт, хувь оролцоо, эзэмшил, борлуулалтын асуудлаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран | "Эрдэнэс Тавантолгой" ХК нь Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нүүрс баяжуулах үйлдвэр зэрэг аливаа төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ төрийн эзэмшлийн хувьцааг 50 хувиас доошгүй байлгах талаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хэлцэл хийх замаар | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллахдаа менежментийн тогтвортой байдлыг хангах, компанийн засаглалыг сайжруулах арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай. | компанийн менежментийн тогтвортой байдлыг хангаж, компанийн засаглалыг сайжруулах арга хэмжээг авч ажиллаж байна. | | |
| 3.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 3.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | | |
| 120 | 1 | 1 | **Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40**<br>2.8. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, буруутай этгээдэд хариуцлага тооцох, учруулсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авах | Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтад “тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан;” тохиолдолд Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулалтыг Улсын Их Хурлын 2019.05.02-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан. Дээр дурдсан хуулийн заалтын дагуу 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бусаар алт олборлогч нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 12.01-ний өдрийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлж ажилласан. 2019.08.23-ны өдрөөс 12.1-ний өдрийг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг авч хэрэгжүүлсэн.<br>Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт “Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ” гэж заасны дагуу уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2020 онд Байгаль | 100%<br>Дотоод хяналтандаа авч ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | орчин, аялал жуулчлалын яамны Төрийн сангийн Байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд нийт 17 тэрбум төгрөгийг байршуулсан байна.<br>2020 онд "Эм жи эйч" ХХК-ийн Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт эзэмшиж байгаад цуцлагдсан ашиглалтын тусгай зөвшөөрлийн нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон 40.65 га талбайгаас 10 га талбайд хийх техникийн нөхөн сэргээлтийг тус компанийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн сангийн Байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд байршуулсан нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгөөр гүйцэтгэсэн байна. | | | |
| 3.е. Засгийн газрын тогтоол | | | | | | | |
| 121 | 1 | 1 | **Тогтоол хүчингүй болгох тухай**<br>**2017-03-20**<br>**Дугаар 2017_96**<br>4. Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг үндэслэн Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн боомтын төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд оруулах нийт хөрөнгө оруулалтад нь багтаан тооцуулах талаар хөрөнгө оруулахыг сонирхож байгаа этгээдтэй хэлэлцээ хийж тохиролцохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай. | "Гашуун Сухайтын Төмөр Зам" ХХК-д оруулсан хувь хөрөнгийн хэмжээг татан авах ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, холбогдох дүгнэлтийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулсан. ТУЗ-өөс хувь хөрөнгөө татан авах ажлыг гүйцэтгэхийг даалгасан тогтоолыг 2017.05.25-нд гаргасан. Үүний дагуу "Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт" аудитын шалгалт хийлгэх зардлыг шийдвэрлэх хүсэлтийг хүргүүлсэн. Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замыг барьж байгуулах, ашиглалтад оруулах хөрөнгө оруулагчийг татах чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн чиглэл болон Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд төмөр замын суурь бүтцийг өмчлөх эрх нь зөвхөн төрд хамаарах тул хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлээс бус төрийн өмчит компанийн санхүүжилтээр шийдвэрлэх шаардлага бий болсон. Энэ хүрээнд Тавантолгой ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай төмөр замын дэд бүтцийг барьж байгуулах чиглэлээр УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолыг батлуулсан. Тус тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоол батлагдан уг төмөр замыг барьж байгуулах этгээдээр төрийн өмчит компани болох ЭТТ ХК болон Монголын төмөр зам ХХК-ийн хамтарсан охин компани болох Тавантолгой төмөр зам ХХК-г байгуулж, холбогдох төмөр зам барих тусгай зөвшөөрлийг уг компанид өгсөн. Монголын төмөр зам болон ЭТТ оруулсан хөрөнгийн хэмжээгээр тус компанид хувьцаа эзэмших бөгөөд төмөр зам эхлүүлэх ажлыг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхийг ЭТТ-д зөвшөөрч төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд 2022.07.01-ний өдөр ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. | | 100% | |
| 122 | 2 | 2 | **"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.10 дахь заалтын дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019.07.30-ны өдрийн 32 дугаар тогтоолоор "Дотоодын болон гадаадын санхүүгийн | | /-/ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **2018-08-08**<br>**Дугаар 2018_245**<br>1.. Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалахтай холбогдсон бэлтгэл ажлыг хангахад шаардагдах мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан үйлчилгээг үзүүлэх чадвартай гүйцэтгэгчийн тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, холбогдох гэрээг байгуулан хэрэгжүүлж ажиллахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгасугай. | зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжихтай холбоотой зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам"-ыг баталсан. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019.07.30-ны өдрийн 28 дугаар тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой Майнинг" ХХК охин компани байгуулагдсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019.09.02-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор олон улсын зөвлөх үйлчилгээг "Эрдэнэс Тавантолгой Майнинг" ХХК, дотоодын зөвлөх үйлчилгээг "Эрдэнэс Тавантолгой" ХК журмын дагуу тус тус зохион байгуулсан.<br>"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьд 2020.05.08-ны өдрийн байдлаар дотоодын хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардлагатай дараах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгож, холбогдох гэрээг байгуулан тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:<br>-Дотоодын андеррайтерийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Би Ди Сек" ХК, "MICC" ХХК-нэгдлийг;<br>-Дотоодын хуулийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Батбаяр энд партнерс" ХХН-ийг;<br>-Дотоодын аудитын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Конфиденсе аудит" ХХК-ийг;<br>-Дотоодын хөрөнгийн үнэлгээний зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "БДО аудит" ХХК-ийг;<br>-Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээний тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Экологийн бүтээмж" ХХК-ийг;<br>-Уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн сан бүрдүүлэх, хаалтын төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр RWE болон "Евро-Хан" ХХК-ийн нэгдлийг;<br>-Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "PwC Mongolia" ХХК-ийг;<br>-Мэдээллийн сан, проспектус, үнэт цаас танилцуулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "МЭК" ХХК-ийг;<br>-Зах зээлийн судалгааны тайлан бэлтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Шанхи Фенвэй Энержи Имформэйшин Сервис, "Прожект майнинг" ХХК-ийн нэгдлийг;<br>-Брэнд бүтээх, хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Жамух интернэйшнл" ХХК-ийг сонгон шалгаруулсан.<br>Гэвч Засгийн газрын 2020.04.27-ны өдрийн хуралдаанаар 2019 оны Засгийн газрын 296 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай шийдвэр гаргасан тул гадаадын зах зээлд хувьцаа гаргах ажил зогсонги байдалд орсон.<br>Иймд компанийн зүгээс "Эрдэнэс Тавантолгой Майнинг" ХХК-аас шаардлагатай баримт материалыг хүлээн авах, гадаад дотоодын | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зөвлөхүүдтэй байгуулсан гэрээг дүгнэх, зарим тайлан, дүгнэлтийг эцэслэн авах чиглэлээр ажиллаж байна. Цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдлын улмаас авч хэрэгжүүлсэн хөл хорио, сул зогсолтын арга хэмжээний улмаас энэ ажлыг дуусгах чиглэлээр ажиллах боломж хязгаарлагдаад байна. | | | |
| 123 | 2 | 3 | 7.. Азийн хөгжлийн банктай байгуулсан “Засаглал, менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн зээлийн хөрөнгийн ашиглалтыг Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалах үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү нарт тус тус үүрэг болгосугай. | Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоол болон Засгийн газрын 2018 оны 245, Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолуудаар Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалах үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай холбогдох шийдвэрүүд гарсан.<br>Гэвч Засгийн газрын 2020.04.27-ны өдрийн хуралдаанаар 2019 оны Засгийн газрын 296 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай шийдвэр гаргасан тул гадаадын зах зээлд хувьцаа гаргах ажил зогсонги байдалд орсон. | | /-/ | |
| 124 | 3 | 4 | **Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2019-04-10**<br>**Дугаар 2019_135**<br>3.. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд шаардагдах хөрөнгийн үлдэгдэл санхүүжилтийг Монголбанкны дэмжлэгээр бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй. | “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК хооронд 2019.10.24-ний өдөр “Үнэт цаас худалдах, худалдан авах тухай гэрээ”-г холбогдох хууль, журмын дагуу байгуулсан.<br>2019.12.27-нд Санхүүгийн зохицуулах хорооноос 407 дугаар тогтоол гаргаж “Монголын төмөр зам” ТӨХК-ийн үнэт цаасыг албан ёсоор бүртгэж авсан. Үнэт цаас худалдан авах ажлыг “ЭТТ” ХК-аас үе шаттай зохион байгуулж 2020 оны 7 дугаар сард нийт 750 тэрбум төгрөгийн үнэт цаасны бүрэн худалдан авч төлбөрийг “Монголын төмөр зам” ТӨХК-д шилжүүлж дууссан.<br>Одоогийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Монголын төмөр зам” ТӨХК-аас гаргасан 750 мянган ширхэг үнэт цаасыг эзэмшиж “Хаан банк” ХХК-ийн кастодиан үйлчилгээний газарт хадгалуулж байна.<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өмнөх 750 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас гадна дараах санхүүжилтийг “Зүүнбаян төмөр зам” ХХК-д хийгээд байна. Үүнд:<br>– Нэмэлт санхүүжилтээр 406.4 тэрбум төгрөг<br>– Нийт 1.15 их наяд төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн байна. | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үлдэгдэл санхүүжилтийг "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК, "Зүүнбаян төмөр зам" ХХК нарын хооронд хийгдэх "Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ"-г эцэслэн байгуулсны дараа өөрийн эзэмшлийн хувь, хэмжээний дагуу үе шаттай олгохоор ажиллаж байна. | | | |
| 125 | 4 | 5 | **Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2019-07-24 Дугаар 2019_304** 4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай. | "Эрдэнэс Тавантолгой" ХК нь холбогдох шийдвэрийн дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 66 хувийг эзэмшиж байгаа бөгөөд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын санхүүжилтэд 2021 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 1,375.04 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн байна. Төслийн бүтээн байгуулалтын явц 2021 оны 11 дүгээр сарын байдлаар нийт гүйцэтгэлээр 72.7 хувийн гүйцэтгэлтэй явж байна. | | | 70% | |
| 126 | 4 | 6 | 6.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажлын явц, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн явцын талаар Зам, тээврийн хөгжлийн яамнаас тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулга хийж байна. | | | 100% | |
| 127 | 5 | 7 | **Төлөвлөгөө батлах тухай 2020-02-19 Дугаар 2020_74** 2.. "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах Ажлын ерөнхий төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай. 2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны | Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020.03.31-ний өдрийн 23 дугаар тушаалаар байгуулагдсан "Оюутолгойн ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019.12.18-ны өдрийн 174 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зохицуулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамнаас төлөөлөл ажиллаж байгаа бөгөөд Ажлын хэсгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хараат бус, консалтингийн зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврын төслийг боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн. | | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 174 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын дэд хэсгийг байгуулж, удирдамж, чиглэл өгч, биелэлтийг хангуулан ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд даалгасугай. | Ажлын хэсэг Оюу толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагч талтай хийсэн үргэлжилсэн яриа хэлэлцээний дүнд хөрөнгө оруулагч талаас Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн саналыг харгалзаж, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Улсын Их Хурлын 2021.12.30-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн. | | | |
| 128 | 5 | 8 | 3.. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хараат бус, консалтингийн зөвлөх үйлчилгээ авахтай холбоотой санхүүжилтийг олон улсын банк, санхүүгийн байгууллагын санхүүжилттэй төслийн зээл, бусад эх үүсвэрээс шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал (П.Ганхүү), “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Ц.Түмэнцогт) нарт тус тус үүрэг болгосугай. | Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020.03.31-ний өдрийн 23 дугаар тушаалаар байгуулагдсан “Оюутолгойн ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019.12.18-ны өдрийн 174 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зохицуулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамнаас төлөөлөл ажиллаж байгаа бөгөөд Ажлын хэсгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хараат бус, консалтингийн зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврын төслийг боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн. Ажлын хэсэг Оюу толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагч талтай хийсэн үргэлжилсэн яриа хэлэлцээний дүнд хөрөнгө оруулагч талаас Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн саналыг харгалзаж, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Улсын Их Хурлын 2021.12.30-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн. | | 100% | |
| 129 | 6 | 9 | **Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай 2020-09-23 Дугаар 2020_113** 2. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний үндсэн дээр барилгын ажлыг 2020 онд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул | Таван толгойн ордыг түшиглэн Цахилгаан станц, нүүрс баяжуулах үйлдвэр, нүүрс химийн үйлдвэр, ус хангамжийн цогцолбор, Таван толгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, авто зам, Таван толгой –Ханги- Мандал чиглэлийн авто зам зэрэг төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Гэвч төсөл хэрэгжүүлэгч нарт Тавантолгойн ордын нэгдсэн гадаргын төлөвлөлтийн зураг байхгүйгээс үүдэлтэй улсын нэгдсэн санд бүртгэлтэй нөөцийн биет дээр орон нутаг болон бусад төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд дэд бүтэц, барилга байгууламжийг барьж байгаа нь уул уурхайн үйлдвэрлэлд хүндрэл үүсгэхээр байна. Иймд Тавантолгойн ордыг түшиглэн баригдах дэд бүтэц, уулын үйлдвэр зэргийг багтаасан гадаргын зураг төслийг боловсруулах Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарын 2020.07.30-ны өдрийн А/198, А/139 дүгээр хамтарсан тушаалаар байгуулж, санал боловсруулж, эрх ашиг нь хөндөгдөх талуудад танилцуулж, нэгдсэн | | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | байр сууринд хүрсний дагуу Засгийн газрын 2020.09.23-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 51 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. Дээр дурдсан төлөвлөлтөд Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын асуудал тусгагдсан.<br>Холболтын төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийн төслийг "Тавантолгой төмөр зам" ХХК боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021.04.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж магадлуулсан.<br>"Тавантолгой төмөр зам" ХХК нь Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр сонгогдсон Ерөнхий гүйцэтгэгчтэй холболтын төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, уг гүйцэтгэгчээс барилгын ажлын мастер төлөвлөгөөний санал ирүүлсэн байгаа бөгөөд туслан гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулах ажил явагдаж байна. | | | |
| 130 | 7 | 10 | **Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**<br>**2020-09-30**<br>**Дугаар 2020_125**<br>2. Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тавдугаар хэсгийн 5.1.8-д "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ." гэсэн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтран баталсан 2020.12.30-ны өдрийн 167, А/698, А/336, А/242 дугаар хамтарсан тушаал гарсан. Дээрх тушаалын хүрээнд 2021 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 202 аж ахуйн нэгжийн 1,782 га талбай, 2,917.9 сая төгрөгийг дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтэд зарцуулахаар тусгасан.<br>Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.3 дугаар заалтын дагуу. ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны тайланг ирүүлэх хугацаа болоогүй байна. | | 100% | |
| 131 | 8 | 11 | **Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-11-18**<br>**Дугаар 2020_183**<br>10. Монгол, Хятадын хилийн боомтод хэрэгжүүлж буй "Ногоон гарц"-ын үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигт малтмал, | Тус яамнаас Монгол, Хятадын хилийн боомтод хэрэгжүүлж буй "Ногоон гарц"-ын журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх саналыг боловсруулж, Гадаад харилцааны яаманд 2021.02.16-ны өдрийн 01/373 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын тосны экспортыг хэвийн, тасралтгүй явуулах саналыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд дипломат шугамаар тавьж харилцан тохиролцохыг Гадаад харилцааны сайд Н.Энхтайван, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай. | | | | |
| 132 | 8 | 12 | 11. Хилийн боомтуудыг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд бүрэн хүчин чадлаар ажиллуулах, Тавантолгойн бүлэг орд, Нарийнсухайтын бүлэг орд, Оюутолгойн ордын хүрээнд байгуулагдсан ариутгал, халдваргүйжүүлэлт, хамгаалалтын аюулгүйн бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай уялдуулан Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор тээвэрлэлт хийж байгаа жолооч нарыг шинжилгээнд бүрэн хамруулж, эдгээр боомтыг “Ногоон бүс” болгон зарлаж, тээвэрлэлтийн дараалал үүсгэхгүй байхаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 30, 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 37, 39 дүгээр тушаалаар тус тус байгуулагдсан Ажлын хэсгийг Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгойн ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, хилийн Гашуунсухайт боомт, Нарийнсухайтын ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам, хилийн Шивээхүрэн боомтод ажиллуулж, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал хүн амын дунд тархахаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах, боомтын аюулгүй байдлыг хангуулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй газар дээр нь үзэж танилцаж, хяналт тавьж, заавар, зөвлөмж өгч, холбогдох зохион байгуулалтыг тухай бүр гүйцэтгэсэн.<br>Тухайлбал, Нүүрс тээврийн жолооч нарыг PCR шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж ЗӨСҮТ-ийн явуулын лабораторийг ажиллуулж байна. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ажилтан албан хаагчдыг түргэвчилсэн оношлуурт хамруулах, ажилчдын ээлж солилцох асуудлыг шийдвэрлэсэн.<br>Мөн Цагаан хадны гаалийн хяналтын бүс хилийн Гашуунсухайт боомт орчимд Дотоодын цэргийн 50 албан хаагчдыг ажиллуулж, халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах арга хэмжээг авсан болно.<br>Түүнчлэн уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч томоохон аж ахуйн нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Тавантолгой, Нарийнсухайт, Айлбаян, Ерөө-Хүдрийн бүлэг ордод нэгдсэн байдлаар, Оюутолгой, Эрдэнэт, Бор-Өндөр, Хөшөөт, Таяннуур, Улаан, Төмөртийн овоо, Багануур, Шивээ-Овоо, Адуунчулуун, Шарын голын уурхай, газрын тосны Зүүнбаян, Тосон уул, Тамсагийн орд тус бүр халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах Аюулгүйн тусгай бүсийг УУХҮСайдын 2020 оны 297 дугаар тушаалын дагуу байгуулж хэрэгжилтийг хангаж байна. | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 133 | 9 | 13 | **Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийн гарц нээх тухай**<br>**2020-12-30**<br>**Дугаар 2020_254**<br>2. Шивээхүрэн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалтаар уг боомтод нүүрс тээвэрлэлтийн чингэлэгтэй автомашины хяналтын нэмэлт гарцыг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах хуулийн этгээдтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд зөвшөөрсүгэй. 2. Энэ тогтоолын 1-д заасны дагуу барьсан нэмэлт гарцыг төрийн өмчид бүртгэн Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хил хамгаалах ерөнхий газар, “Монголын алт (МАК)” ХХК хооронд нүүрс тээвэрлэлтийн чингэлэгтэй автомашины хяналтын нэмэлт гарц барьж, хүлээлгэн өгөх тухай гэрээг 2021.03.29-ний өдөр байгуулсан бөгөөд “Монголын Алт” (МАК) ХХК Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийн 4ш гаалийн хяналтын нэмэлт гарцыг барьж, Хил хамгаалах ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. | 100%<br><br>Тогтоолын хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 134 | 10 | 14 | **Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2021-04-07**<br>**Дугаар 2021_89**<br>1. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан хянан баталгаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, барилгын ажлыг 2021 оны II улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021.05.17-ны өдрийн хурлаар Засгийн газрын 2021 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах тухай 20 дугаар тогтоолыг баталсан.<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв /салбар төмөр зам, ачих байгууламж/-ийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, хянан баталгаажуулах, магадлуулах, барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хүлээлгэн өгөх ажлыг төмөр замын тусгай зөвшөөрөл бүхий өөрийн охин компани болох “Тавантолгой төмөр зам” ХХК-аар үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхтэй холбоотой “Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн санхүүжилтийн гэрээг 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан. Улмаар “Эрдэнэс Тавантолгой” ХК төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаа хийх түүнийг магадлуулах, барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ хийх зэрэг бэлтгэл ажлын хүрээнд 2.2 тэрбум төгрөгийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д шилжүүлсэн.<br>Мөн ЭТТ бондын 2 дугаар транчаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөс төслийн ажлыг эрчимжүүлэх, үндсэн байгууламжийн урьдчилгаа | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ), барьж байгуулах ажиллагаа нь төмөр замын хөдөлгөөний болон техникийн аюулгүй ажиллагаа, барилга байгууламжийн технологийн горим, стандарт, шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт тус тус даалгасугай. | төлбөрт шаардлагатай 63 тэрбум төгрөгийг 2021.09.06-ны өдрийн нэмэлт гэрээний дагуу шилжүүлсэн.<br>Төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил дууссан бөгөөд УУХҮЯамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Улмаар төслийг хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай 15.8 тэрбум төгрөгийг техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан санхүүжилтийн хуваарийн дагуу шилжүүлсэн. | | | |
| 135 | 10 | 15 | 3. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийг ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжүүлэхээр тооцож, тус компанийн хөрөнгөд бүртгүүлэх арга хэмжээг авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай. | "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021.05.17-ны өдрийн хурлаар Засгийн газрын 2021 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах тухай 20 дугаар тогтоолыг баталсан.<br>"Эрдэнэс Тавантолгой" ХК Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв /салбар төмөр зам, ачих байгууламж/-ийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, хянан баталгаажуулах, магадлуулах, барилгын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хүлээлгэн өгөх ажлыг төмөр замын тусгай зөвшөөрөл бүхий өөрийн охин компани болох "Тавантолгой төмөр зам" ХХК-аар үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхтэй холбоотой "Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн санхүүжилтийн гэрээг 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан байна. Улмаар "Эрдэнэс Тавантолгой" ХК төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаа хийх түүнийг магадлуулах, барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ хийх зэрэг бэлтгэл ажлын хүрээнд 2.2 тэрбум төгрөгийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д шилжүүлсэн.<br>Мөн ЭТТ бондын 2 дугаар транчаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөс төслийн ажлыг эрчимжүүлэх, үндсэн байгууламжийн урьдчилгаа төлбөрт шаардлагатай 63 тэрбум төгрөгийг 2021.09.06-ны өдрийн нэмэлт гэрээний дагуу шилжүүлсэн.<br>Төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил дууссан бөгөөд УУХҮЯамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021.11.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Улмаар төслийг хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай 15.8 тэрбум төгрөгийг техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан санхүүжилтийн хуваарийн дагуу шилжүүлсэн. | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 136 | 11 | 16 | **Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай 2021-04-28 Дугаар 2021_113** 1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу 2021 оны III улиралд багтаан эхлүүлж, 2023 онд ашиглалтад оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай. | Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "Чайна металлуржикал инженеринг" компани, ШУТИС-ийн харьяа Уул уурхайн хүрээлэн хамтран /CMEC/ боловсруулж 2021.04.01-ний өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс "Чайна металлуржикал инженеринг" компанитай байгуулсан гэрээний дагуу 2 дугаар шатны ажил болох нүүрс баяжуулах үйлдвэрийн FEED буюу урьдчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 2021 оны 8 дугаар сард дуусган хүлээж авсан байна. 2021.08.13-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 956,447,866,100 төгрөгийн өртөг бүхий тендерийг зарласан бөгөөд 2021.09.27-ны өдөр нээсэн. Тендерийн хугацаанд нийт 20 газар тендерийн бичиг баримт авснаас дөрвөн газар оролцохоор материалаа ирүүлсэн болович тендер шалгаруулалтын хүчинтэй хугацаа дуусгавар болсон учир амжилтгүй болсон. Улмаар 2021.11.15-ны өдөр дахин тендер зарласан бөгөөд 2021.12.15-ны өдөр хааж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ, хэлцэл хийх ажил үргэлжилж байна. | | 70% | |
| 137 | 12 | 17 | **Жагсаалт шинэчлэн батлах тухай 2021-05-05 Дугаар 2021_128** 2. "Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан нарт үүрэг болгосугай. | Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 79 аж ахуйн нэгж, байгууллага Засгийн газрын 2021 оны 128 дугаар тогтоолоор баталсан жагсаалтын дагуу үйл ажиллагаа явуулж, улирал бүр тайлангаа УУХҮЯ-нд ирүүлж байна. | | 100% | |
| 138 | 13 | 18 | **Нийслэл Улаанбаатар хотын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-05-19 Дугаар 2021_146** | Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлд "Богдхан төмөр зам" төслийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд эхний ээлжинд зураг төсөв, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 23.0 тэрбум төгрөгийн | | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 4. Нийслэл Улаанбаатар хотод багтаамж ихтэй, шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл, арга хэмжээг судалж, боломжит эх үүсвэрийг тооцож төслийн ажлыг 2021 онд багтаан эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт зөвшөөрсүгэй. | санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төсвийн тодотголд тусган компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлсэн. “Тавантолгой Төмөр зам” ХХК-аас Богдхан төмөр замын төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж Зам, тээврийн хөгжлийн төвийн 2021.12.22-ны өдрийн 243/2024 дугаар Магадлалын ерөнхий дүгнэлтээр магадлуулсан. Мөн Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлийн 2022.01.07-ны өдрийн 01 дүгээр шийдвэр болон Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2022.01.11-ний өдрийн 01 дүгээр шийдвэрээр батлуулаад байна. | |
| 139 | 14 | 19 | **Чингэлэгт тээврийн терминал байгуулах тухай 2021-07-02 Дугаар 2021_185**<br>2. Чингэлэгт тээврийн терминал байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон нүүрс олборлон экспортолж буй аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай. | Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, 2021.09.20-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгч, улмаар 2021.10.03-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Тавантолгой” ХК-иуд бүтээн байгуулалт, санхүүжилтийн гэрээг байгуулсан. | 100%<br><br>Тогтоолын хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 140 | 14 | 20 | 4. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хилийн боомтын үндэсний зөвлөл (Б.Жавхлан), Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай. | Тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд энэ хүрээнд Гашуунсухайт боомт дахь чингэлэгт тээврийн терминалын барилга байгууламж, зам, талбайн барилга угсралт, бүтээн байгуулалтын зардлыг хамтран санхүүжүүлэх тухай 2021.10.04-ний өдрийн гэрээтэй Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд танилцаж баталгаажуулсан. | 100%<br><br>Тогтоолын хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 141 | 15 | 21 | **“Тавантолгой түлш” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-10-13 Дугаар 2021_316** 3. “Тавантолгой түлш” ХХК-ийн нийт хувьцааны 51 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д эзэмшүүлэхээр тогтоосугай. 2. “Тавантолгой түлш” ХХК-ийн Засгийн газрын эзэмшлийн 49 хувийн хувьцааны төрийн өмчийн төлөөллийн 39 хувийг Эрчим хүчний яам, 10 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлэхээр тус тус тогтоосугай. 3. Энэ тогтоолын 1, 2 дахь заалтаар “Тавантолгой түлш” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хувь хэмжээ болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн төлөөллийг хэрэгжүүлэгч этгээдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсантай холбогдуулан “Тавантолгой түлш” ХХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, хэрэгжүүлэхийг “Тавантолгой түлш” ХХК-ийн Гүйцэтгэх захирал М.Ганбаатарт даалгасугай. 4. “Тавантолгой түлш” ХХК-ийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөрийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай. | “Таван толгой түлш” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай” болон “ Түр хороо байгуулах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, ТУЗ-ийн тогтоолыг гаргасан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2022 оны төсвийн төсөлд “Таван толгой түлш” ХХК-ийн өр төлбөрийг барагдуулах хөрөнгийг тусгасан. Таван толгой түлш” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хуралдаж, компанийн шинэчилсэн дүрмийг баталгаажуулж, Улсын бүртгэлийн Ерөнхий газар бүртгүүлсэн. | | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | | | |
| 142 | 1 | 1 | **Ажлын хэсэг байгуулах тухай /Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгойн зэс-алтны ордын төслийн хэрэгжилттэй холбогдуулан 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр хөрөнгө оруулагч талтай байгуулсан "Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон Хувь нийлүүлэ 2018-02-21 Дугаар 2018_27**<br>3.. Оюутолгой төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн асуудлаар дэд ажлын хэсэг байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, эрчим хүчний асуудлаар дэд ажлын хэсгийг байгуулахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнд тус тус хариуцуулж ажлын явц, үр дүнг тухай бүр танилцуулж байхыг даалгасугай. | Монгол Улсын Ерөнхий сайд 2018 оны 27 дугаар захирамжид үндэслэн Монгол Улсын УУХҮСайдын 2018.03.27-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар Оюу Толгой төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан Дэд ажлын хэсгийг байгуулсан.<br>Ажлын хэсгийн хурлуудаар хэлэлцсэний үндсэн дээр Үндэсний хөгжлийн газрын захиалгаар Өмнийн говийн бүсийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, учир шалтгааныг илрүүлэн, шийдвэрлэх арга замыг тусгасан Өмнийн говийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн судалгааны бичиг баримтыг МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгээр гүйцэтгүүлж, ЭОТ ХХК-ийн саналын дагуу ОТ ХХК санхүүжүүлсэн.<br>МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны багийнхантай уялдаа холбоотой ажиллаж санал солилцон ажиллаж, Өмнийн говийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн судалгааг Үндэсний хөгжлийн газрын "Алсын хараа – 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан 8 дугаар бүлэгт нь "Бүсчилсэн хөгжил"-ийн бодлого түүний дотор "Говийн дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлал 2030"-ыг батлуулахаар дараах үйл ажиллагаанууд хийгдсэн.<br>-2020.01.22-нд Үндэсний хөгжлийн газрын урт хугацааны бодлого боловсруулах ажлын хэсэг, Говийн дэд бүсийн судалгааны Ажлын хэсэг амжилттай ажиллаж, үр дүнгээ Ерөнхий сайдад хүлээлгэн өгөв. Төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн барихаар шийдвэрлэсэн;<br>-2020.04.10-нд "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, "Бүсчилсэн хөгжил"-ийн үзэл баримтлалыг батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцсэн;<br>-2020.05.06-нд "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, "Бүсчилсэн хөгжил"-ийн бодлогыг УИХ-ын Байнгын хороод дэмжсэн;<br>-2020.05.13-нд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэлэлцэж, 8 дугаар бүлгийн "Бүсчилсэн хөгжил"-ийн бодлогын хэсгийг "Бүс орон нутгийн хөгжлийн бодлого" болгон өөрчилж баталсан. Үүнтэй холбогдуулж "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр"-ийг боловсруулж, УИХ-аар батлуулах үүргийг Засгийн газарт өгсөн. Үүний хүрээнд одоо шинэчлэн байгуулагдах Засгийн газар "Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөр"-ийг жишиг байдлаар УИХ-д өргөн мэдүүлж батлуулахаар болоод байна. | | 100% | | |
| 3.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 143 | 1 | 1 | **2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл**<br>**2018-07-04**<br>**Дугаар 2018_29**<br>XX.4. 2. . Байгалийн өнгөт чулуug хууль бусаар олборлох, улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг судлах, байгалийн өнгөт чулууны жишиг үнэлгээг тогтоолгохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт; | Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2014 оны 220 дугаар тогтоол, 2015 оны 102, 103, 488 дугаар тогтоол , 2016 оны 81 дүгээр тогтоолын дагуу уул уурхайн экспортын дараах бүтээгдэхүүнүүдийн олон улсын зах зээлийн үнийг Сангийн сайд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын хамтарсан 2018 оны 200/А/177 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийтэд мэдээлж байгаа болно. Үүнд: Цайр, зэс, цагаан тугалга, хар тугалга, хөнгөн цагаан, молибдени, алт, мөнгө, нүүрс, төмөр, жонш, гянтболдын хүдэр, манганий хүдэр зэрэг багтаж байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Монгол Улсад үнэт металл, эрдэнийн чулуугаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхий эдээр хангах болон худалдаалах зэрэг асуудлуудыг олон улсын чиг хандлагад нийцүүлэх зорилгоор "Үнэт металл, эрдэнийн чулууны үйлдвэрлэл, түүний эргэлтийн тухай" хуулийн төслийг үзэл баримтлалын төслийн хамтаар боловсруулж, үзэл баримтлалын төслийг батлуулахаар Хууль, зүй дотоод хэргийн яаманд 2018.07.25-ны өдрийн 01/2026 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | 70% | |
| 144 | 2 | 2 | **2020 оны 6 дугаар сарын 12-ны өдөр 35 дүгээр тэмдэглэл**<br>**2020-06-12**<br>**Дугаар 2020_35**<br>XIX.4. . "Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын нутаг дэвсгэрт орших "Асгат"-ын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах зарим арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн эзэмшиж байгаа стратегийн ач холбогдол бүхий "Асгат"-ын ордын техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулсны үндсэн дээр эдийн засгийн эргэлтэд оруулах саналаа Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Ганхүү нарт даалгав. | Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд "Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ" гэж тусгуулсан.<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу жил бүр Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Үүнд:<br>1.Асгатын мөнгөний ордын нөөцийн тодотголын тайланг боловсруулах сонгон шалгаруулалт 2020 онд зарласан. Сонгон шалгаруулалтаар "Стийл-Айрон" ХХК шалгарсан бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг 2021.06.01-ний өдөр хүртэл сунгасан. Гэрээний хугацааны дагуу боловсруулсан тайланг хүлээж авсан бөгөөд тайланд шинжээч томилуулан ажиллаж байна.<br>2.Ордын хэмжээнд 5000 га талбайд М1:2000 масштабын гадаргын бүрэн зураглал хийх, тусгай зөвшөөрлийн хил хязгаар тогтоох, шав тэмдэг тавих тендерийн баримт бичиг, техникийн даалгаврыг боловсруулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна.<br>3.Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн XII.4.2-д багтсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх | | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв”-ийн жагсаалтад улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх 500 000 000 /таван зуун/ сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр Асгатын мөнгөний ордын штольня-1, штольня-2 болон штольня-5 хэвтээ амнуудаас хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох” нарийвчилсан зураг төсөл боловсруулах арга хэмжээ батлагдсан.<br>4. Эрдэнэс Монгол ХХК-ийн саналыг харгалзан тус яам нь БХБС-ын багцад 500.0 төгрөгийг суулгуулан Эрдэнэс Монгол ХХК-ийн ирүүлсэн ажлын даалгаврын дагуу Асгатын мөнгөний ордын штолня-1, штолня-2 болон штолня-5 хэвтээ амнуудаас хүдэр тээвэрлэх технологийн зам гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт Эн Би Си Си ХХК нь шалгарч гэрээт ажлыг гүйцэтгэж байна.<br>5. Эрдэнэс Монгол ХХК нь Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших өөрийн эзэмшлийн “Асгат”-ын мөнгө, полиметаллын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай геологи хайгуулын ажил хийх, дэд бүтэц, уулын баяжуулах, боловсруулах, цэвэршүүлэх үйлдвэрийн инженерчлэл, барилгын ажлыг төлөвлөх, ашиглалтад оруулах, бүтээгдэхүүн гаргах, худалдах замаар үр ашигтайгаар ашиглах зорилгоор АНУ-ын “Commonwealth American Partners” хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлтэй “Хамтын ажиллагаа, түншлэлийн санамж бичиг”-ийг 2021.08.30-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан. Тус санамж бичгийн хүрээнд АНУ-ын “Commonwealth American Partners” хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлтэй хэлэлцээр хийсний үндсэн дээр уг асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | |
| 145 | 3 | 3 | **2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 37 дугээр тэмдэглэл<br>2020-06-23<br>Дугаар 2020_37**<br>YI.1. 5. . Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад шаардлагатай нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэх талаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан нарт; | “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК хооронд 2019.10.24-ний өдөр “Үнэт цаас худалдах, худалдан авах тухай гэрээ”-г холбогдох хууль, журмын дагуу байгуулсан.<br>2019.12.27-нд Санхүүгийн зохицуулах хорооноос 407 дугаар тогтоол гаргаж “Монголын төмөр зам” ТӨХК-ийн үнэт цаасыг албан ёсоор бүртгэж авсан. Үнэт цаас худалдан авах ажлыг “ЭТТ” ХК-аас үе шаттай зохион байгуулж 2020 оны 7 дугаар сард нийт 750 тэрбум төгрөгийн үнэт цаасыг бүрэн худалдан авч төлбөрийг “Монголын төмөр зам” ТӨХК-д шилжүүлж дууссан.<br>Одоогийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Монголын төмөр зам” ТӨХК-аас гаргасан 750 мянган ширхэг үнэт цаасыг эзэмшиж “Хаан банк” ХХК-ийн кастодиан үйлчилгээний газарт хадгалуулж байна.<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өмнөх | 100%<br><br>Дотоод хяналтандаа авч ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 750 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас гадна дараах санхүүжилтийг “Зүүнбаян төмөр зам” ХХК-д хийгээд байна. Үүнд:<br>– Нэмэлт санхүүжилтээр 406.4 тэрбум төгрөг<br>– Нийт 1.15 их наяд төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.<br>Үлдэгдэл санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК, “Зүүнбаян төмөр зам” ХХК нарын хооронд хийгдэх “Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ”-г эцэслэн байгуулсны дараа өөрийн эзэмшлийн хувь, хэмжээний дагуу үе шаттай олгохоор ажиллаж байна. | | | |
| 146 | 4 | 4 | **2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл 2020-11-04 Дугаар 2020_58**<br>XYI.2. 4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, бүртгэлжүүлэх, түүнд тавих хяналтыг цахимжуулах эрх зүйн болон техникийн орчинг бүрдүүлэх асуудлыг Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 17 дугаар тогтоолын 1, 2, 9 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд судлан зохих шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт; | Хүчин төгөлдөр 3003 тусгай зөвшөөрлийн цаасан хувийн хэргийн 471300 хуудас баримтыг бүрэн сканердаж цахим хэлбэрт оруулсан. Цахим хувийн хэргээс шаардлагатай баримт материалыг холбогдох төрийн байгууллагуудад цахим шуудангаар хүргүүлж байгаа. Цахим хувийн хэргүүдийг Уул уурхайн кадастрын компьютержсон системд /УУККС/ холбох ажлыг эхлүүлээд байна.<br>Хайгуулын болон уулын ажлын тайлан төлөвлөгөөний E-Reporting системийг УУККС-тэй холбогддог байдлаар хөгжүүлснээр тусгай зөвшөөрлийн тайлан, төлөвлөгөө, нөөц, ТЭЗҮ-ийн мэдээлэлтэй уялдах боломж бүрдсэн.<br>Тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг цахимаар явуулах эрхзүйн боломжийг судлан журмын төслийг шинэчлэн боловсруулж олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, журмыг батлуулахаар УУХҮЯ-нд хүргүүлсэн. Мөн сонгон шалгаруулалтыг цахимаар олон нийтийн хяналтын дор явуулах боломжтой мэдээллийн систем хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулж санхүүгийн дэмжлэг хүсч УУХҮЯ-нд хүргүүлсэн.<br>Журмыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлах зөвшөөрлийг авсан. Сонгон шалгаруулалтыг цахимаар явуулах программыг хөгжүүлэх ажлыг Худалдан авалтын газартай хамтарч хийж байгаа. | | 70% | |
| 147 | 5 | 5 | **2020 оны 11 дүгээр сарын 18ны өдөр 64 дүгээр тэмдэглэл 2020-11-18 Дугаар 2020_64**<br>YIII.1.2. Ашигт малтмал хууль бусаар олборлохтой тэмцэх, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Уул уурхай, хүнд | Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тавдугаар хэсгийн 5.1.8-д “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.” гэсэн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтран баталсан 2020.12.30-ны өдрийн 167, А/698, А/336, А/242 дугаар хамтарсан тушаал гарсан. Дээрх тушаалын хүрээнд 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлын дагуу 2021.04.09-ний өдрөөс 2021.04.12-ны өдөр нийт 4 хоног Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг Ялбаг, Бугант тосгонд уул уурхайн болон бичил уурхай, хууль бус олборлолтын улмаас эвдэрч олон жил орхигдсон талбайд | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлдвэрийн сайд Г.Ёндон, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга)-т; | эвдэрсэн газрын тооллого хийх зорилгыг хэрэгжүүлэн ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 17 дугаар тогтоолын 3, 2019 оны 355 дугаар тогтоолын 1.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор хяналт шалгалтыг зохион байгуулахад “Ялбаг” гэх газарт экскаватор 20, ковш 7, ачааны машин 4, алт угаах төхөөрөмж 12, “Харганат” гэх газарт экскаватор 9, ковш 6, алт угаах төхөөрөмж 2, “Өлөнт” гэх газарт экскаватор 7, ковш 3, “Хорийн даваа” гэх газарт экскаватор 10, алт угаах төхөөрөмж 2 нийт 82 техник хэрэгслийг ууланд нуусан болон нутгийн иргэдийн гадна байрлуулсан байсныг бүртгэлжүүлж 5 хэсэг газарт нэгтгэн байрлуулж, 77 техник хэрэгслийн эзэмшигчийг тогтоож, тус аймаг дахь Цагдаагийн газрын дарга, сумын удирдлагад уулнаас татан буулгах, дахин хууль бусаар ашигт малтмал олборлуулахгүй байх ажил арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэл өгсөн. Ашигт малтмал хууль бусаар олборлохтой тэмцэх чиг үүргийг Экологийн цагдаагийн алба хариуцан ажиллаж байна. | | |
| 148 | 5 | 6 | YIII.1. 6. Иргэдийг дотоод орчны угаарын хийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор “Яндангаа хөөлье” аяныг эрчимжүүлэх, агаар, орчны бохирдлын сөрөг нөлөөллийг таниулах олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл,“Таван толгой түлш” ХХК (М.Ганбаатар) нарт; | Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос зарласан “ЯНДАНГАА ХӨӨЛЬЕ” аянд Таван толгой түлш ХХК нэгдэж тус компанийн “Хэрэглэгчдэд үйлчлэх” албанаас яндан хөөлөх 400 гэрээт ажилтан гаргаж айл өрхүүдийн яндан ханан пийшин хөөлөх ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороотой хамтран 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан ОББҮХ/2020-87 дугаартай гэрээний дагуу 2020 оны 9 дүгээр сарын 5-наас эхэлж зохион байгуулан ажилласан. Нийслэлийн 6 дүүргийн гэр хорооллын айл өрхүүдээс ирсэн дуудлагуудаар “Яндангаа хөөлье” аяныг хэрэгжүүлж нам даралтын зуух болон ханан пийшинд дуудлагаар очиж яндан хөөлж , засах, шинээр ханан пийшин өрөх зэрэг үйлчилгээг үзүүлэн ажиллаж тайлант хугацаанд шинээр сургасан 400 яндан хөөлөгч 12,628 айлын яндан, пийшинг хөөлсөн. | 100%<br><br>Уг асуудал нь ЭХЯ-ны эрхлэх асуудалд хамаарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 149 | 6 | 7 | **2020 оны 12 дугаар сарын 2-ны өдөр 68 дугаар тэмдэглэл**<br>2020-12-02<br>**Дугаар 2020_68**<br>IX.2. 2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уулын ажлын төлөвлөгөө, тайланг уул уурхайн болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран хянаж, баталгаажуулдаг байх асуудлыг судалж, танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар, Уул | Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уулын ажлын төлөвлөгөө, тайланг уул уурхайн болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран хянаж судлах, дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулж, уг асуудлыг шийдвэрлэхээр шинээр бий болох хууль эрх зүйн орчинг бий болгох тухай дүгнэлт гарсан. Улмаар УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан ба тус ажлын хэсгээс уг асуудлыг тусган хуулийн төслийг 2021 онд боловсруулаад байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | | | |
| 150 | 7 | 8 | **2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл**<br>**2021-02-10**<br>**Дугаар 2021_9**<br>XII.3. 2. “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрийг шилжүүлэхэд шаардагдах зардлыг судалж танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ), “Таван толгой түлш” ХХК (М.Ганбаатар) нарт; | Баруун бүсийн үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах зүүн бүсийн үйлдвэр лүү шилжүүлэхэд шаардагдах зардлын тооцоог урьдчилсан байдлаар боловсруулсан бөгөөд Баруун бүсийн үйлдвэрийг шилжүүлэхэд шинээр баригдах барилга, байгууламжийн зардал 64.85 тэрбум төгрөг, цахилгаан хангамжийн хэсэг 3.43 тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийг буулгах, зөөх, угсрах зардал 12.10 тэрбум төгрөг болж нийт зардал 80.38 тэрбум төгрөг болох тооцоолол гарсан.<br>Баруун бүсийн 2 дугаар үйлдвэрийг шилжүүлэхэд гарах зардлын тооцоо урьдчилсан байдлаар 35.6 тэрбум төгрөг болсон бөгөөд үйлдвэрийг шилжүүлэхэд барилгын болон технологийн зураг төсөл боловсруулах, гүний худаг гаргах, үйлдвэрийн дулаан хангамж, цахилгаан хангамжийн барилга байгууламжуудыг шинээр барих шаардлагатай. /ЭХСайдын 2021 оны А/71 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг оруулав./ | 100%<br><br>Цаашид уг тэмдэглэлийн биелэлт ЭХЯ-наас гарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 151 | 8 | 9 | **2021 оны 3 дугаар сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл**<br>**2021-03-05**<br>**Дугаар 2021_15**<br>III.2.3. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замыг барьж байгуулах ажлыг эрчимжүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | Засгийн газрын 2020.09.23-ны өдрийн 113 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгож төмөр замын суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний үндсэн дээр барилгын ажлыг 2020 онд багтаан эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарт даалгасан. Улмаар Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайд нарын 2020.11.12-ны өдрийн А/217, А-293 дугаар хамтарсан тушаалаар Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх ажлыг гүйцэтгэх тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээг баталсан.<br>Улмаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021.06.29-ний өдрийн 33 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төсөвт туссан дүн болох 218,080,000,000 */Хоёр зуун арван найман тэрбум наян сая/* төгрөгийг “Тавантолгой төмөр зам” ХХК-тай гэрээ байгуулж шилжүүлэхийг зөвшөөрсөн. Дээр дурдсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Тавантолгой төмөр зам” ХХК-иас “Бодь Интернэшнл” ХХК-тай “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр зам”-ын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх 2021.08.20-ны өдрийн ТТЗ-Н21/01 дүгээр гэрээ байгуулж, барилгын ажил эхлүүлэх мэдэгдлийг 2021.09.01-ний өдөр хүргүүлсэн. Одоогоор санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Барилгын ажлын явц 2021.11.08-ны өдрийн байдлаар бэлтгэл ажил 97,25%, газар шорооны ажил 48,19%, дугуй хоолойн ажил 26,85%, жаазан гүүрний ажил 53,49%, дөрвөлжин хоолойны ажил 7,99%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.<br>Ерөнхий гүйцэтгэгч "Бодь Интернэшнл" ХХК-ийн 2021.09.29-ний өдрийн BI-CTS-LTR-0006 дугаар албан бичгээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээнд заасан нүүрсний сууръ үнийг жишиг болгон Урьдчилгаа төлбөрөөс бусад төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр буюу нүүрсээр авах боломжтойгоо илэрхийлсэн байна. | | |
| 152 | 8 | 10 | III.2.4. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай үлдэгдэл санхүүжилтийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д; | "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК хооронд 2019.10.24-ний өдөр "Үнэт цаас худалдах, худалдан авах тухай гэрээ"-г холбогдох хууль, журмын дагуу байгуулсан.<br>2019.12.27-нд Санхүүгийн зохицуулах хорооноос 407 дугаар тогтоол гаргаж "Монголын төмөр зам" ТӨХК-ийн үнэт цаасыг албан ёсоор бүртгэж авсан. Үнэт цаас худалдан авах ажлыг "ЭТТ" ХК-аас үе шаттай зохион байгуулж 2020 оны 7 дугаар сард нийт 750 тэрбум төгрөгийн үнэт цаасыг бүрэн худалдан авч төлбөрийг "Монголын төмөр зам" ТӨХК-д шилжүүлж дууссан.<br>Одоогийн байдлаар "Эрдэнэс Тавантолгой" ХК нь "Монголын төмөр зам" ТӨХК-аас гаргасан 750 мянган ширхэг үнэт цаасыг эзэмшиж "Хаан банк" ХХК-ийн кастодиан үйлчилгээний газарт хадгалуулж байна.<br>"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өмнөх 750 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас гадна дараах санхүүжилтийг "Зүүнбаян төмөр зам" ХХК-д хийгээд байна. Үүнд:<br>– Нэмэлт санхүүжилтээр 406.4 тэрбум төгрөг<br>– Нийт 1.15 их наяд төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.<br>Үлдэгдэл санхүүжилтийг "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК, "Зүүнбаян төмөр зам" ХХК нарын хооронд хийгдэх "Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ"-г эцэслэн байгуулсны дараа өөрийн эзэмшлийн хувь, хэмжээний дагуу үе шаттай олгохоор ажиллаж байна. | 70% | |
| 153 | 9 | 11 | **2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр 21 дүгээр тэмдэглэл**<br>**2021-03-31**<br>**Дугаар 2021_21**<br>YII.9. Хилийн боомтуудын экспорт, импортын хэвийн үйл ажиллагааг хангах, ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын хэмжээг | Улсын Онцгой комиссын даргын 2020 оны "Ажилчдын ээлж солих тухай" 41 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж, УУХҮСайд, Эрүүл мэндийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайдын хамтарсан тушаалаар "Ажилтнуудын ээлж солилцож, шилжилт хөдөлгөөн хийх үйл ажиллагаанд баримтлах түр журам" –ыг баталж, уурхайнууд болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгчид, тээвэрлэгчид, харуул хамгаалалтын гэрээт аж ахуйн нэгжүүдийн ажилчдын ээлж солилтыг 2020 оны 12 дугаар сараас эхлэн нэгдсэн зохион | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх, тасалдалгүй байхаар зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав. | байгуулалтаар ханган ажиллалаа. 3 дугаар сард 107 аж ахуйн нэгжийн 9926 ажилчдыг шинжилгээнд хамруулан орон нутаг руу ээлжинд гаргаж, 6328 ажилчдыг ээлжээс буулгасан ба УОК-ийн 02 дугаар тогтоол болон Өмнөговь аймгийн ОК-оос өгсөн чиглэлийн дагуу 2021.04.30-ны өдөр хүртэлх хугацаагаар ажилчдын ээлж солилтыг зогсоож, уурхайн ажилчдыг вакцинжуулах ажлын бэлтгэлийг хангаж байна.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын томоохон 31 аж ахуйн нэгжээс Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөлтэй түргэвчилсэн оношлуурыг нэгдсэн журмаар нийлүүлэхийг хүссэний дагуу Эрүүл мэндийн яамтай хамтран 2 удаагийн татан авалтаар нийт 321000 түргэвчилсэн оношлуурыг Солонгос улсаас нийлүүлсэн.<br>Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн жолооч нарыг нэн түрүүнд вакцинд хамруулах шийдвэрийг Эрүүл мэндийн яамнаас гаргуулан Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газарт 11000 вакцины тун хүргүүлснээр Гашуун сухайт боомтын 5449, Оюутолгойн тээврийн 200, Шивээ хүрэн боомтын 1658, нийт 7307 тээврийн жолооч, тээвэр хариуцсан ажилчдыг Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг вакцинд хамруулаад байна. Вакцины 2 дахь тунг 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хийх болно.<br>Мөн уул уурхайн экспортын голлох нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч уурхайнуудын 38.8 мянга гаруй ажилчдын дархлаажуулалтын вакцинжуулалтыг 5 чиглэлээр төлөвлөн, Зэвсэгт Хүчний Жанжин штабын даргын тушаалаар томилогдсон дархлаажуулалтын явуулын багтай хамтарч эхний 2 чиглэл/ Тавантолгой ба Нарийн сухайтын бүлэг орд/-ийн 84 аж ахуйн нэгжийн 9658 уурхайчдыг вакцинд хамруулсан ба 2 дахь тунг 2021.04.17-ны өдрөөс эхлүүлнэ.<br>Эрүүл мэндийн яамтай хамтран Төвийн бүсийн томоохон 7 аж ахуйн нэгжүүдийн 17294 вакцины тунгийн хангалтыг тухайн орон нутгийн Эрүүл мэндийн газарт нь хүргүүлж, Шивээ-Овоо ХК, Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК, Шарын гол ХК-ийн ажилчдыг 100 хувь вакцинжуулалтад хамруулаад байна. Эрдэнэт үйлдвэр 12000 вакцины тунгийн татан авалтыг хийснээр өнөөдрийн байдлаар 6147 ажилчдыг вакцинд хамруулсан ба вакцинжуулалт үргэлжилж байна. Зүүн болон баруун бүсийн 9 уурхайн 5454 ажилчдын вакцинжуулалтыг Зэвсэгт Хүчний Жанжин штабын явуулын багтай хамтран зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж, вакцины хангалтыг хүлээж байна.<br>Ховд аймгийн Булган боомтын хилээр нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 7 хоногийн Даваа-Ням гарагт хил, гаалийн ажиллах цагийн хуваарийг сунгах, тогтмол хуваарьтай болгох асуудлыг ГХЯ-нд тавьж, 2021 онд Булган-Такашикэн боомтыг “Бямба”, “Ням” гарагт 10:00-19:00 цагт түр горимоор ажиллуулж, нүүрсний тээвэр, уул уурхайн бүтээгдэхүүн нэвтрүүлэхээр болоод байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Засгийн газрын 2021.07.02-ны өдрийн 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах үүргийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. Энэ хүрээнд Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, 2021.09.20-ны Улсын комисст хүлээлгэн өгч, улмаар 2021.10.03-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Тавантолгой” ХК-иуд бүтээн байгуулалт, санхүүжилтийн гэрээг байгуулсан. Терминалын үйл ажиллагааг 2021.11.08-ны өдрөөс эхлүүлэн өдөрт 100 тээврийн хэрэгслээр экспорт хийж эхэлсэн боловч 2021.12.15-ны өдрөөс эхлэн зогсонги байдалд шилжсэн.<br>Шивээхүрэн боомтод 11.6 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Монголын алт (МАК)” ХХК, “Саусгоби сэндс” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Жавхлант орд” ХХК, “Цагаан өвөлжөө” ХХК “Сан транс” ХХК-иуд гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 80 орчим хувьтай байгаа бөгөөд БНХАУ-ын талд гацсан бараа бүтээгдэхүүнийг татан авч суурилуулах ажил хүлээгдэж байна.<br>2021 оны 11 дүгээр сарын байдлаар 15.2 сая тн нүүрс, 1,256.7 мян.тн зэсийн баяжмал 7,091.8 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 635.5 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. | | | |
| 54 | 10 | 12 | **2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр 30 дугаар тэмдэглэл**<br>**2021-05-12**<br>**Дугаар 2021_30**<br>XIX.5. . Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Өмнөговь аймагт ажилласан талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад даалгав: 1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх замаар “Ногоон бүс” түр журмыг бүрэн хэрэгжүүлж “Гашуунсухайт” боомтын үйл ажиллагааг хэвийн горимд оруулах арга хэмжээ авч | Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2021.04.30-ны өдрийн 38 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгой, Нарийнсухайтын орд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, ногоон бүс болгох эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Шуурхай бүлгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдалаар ахлуулан байгуулсан.<br>Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгой, Нарийнсухайтын ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам, хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтод Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 38 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд шуурхай бүлгийн бүрэлдэхүүн 2021.05.01-ний өдрөөс 2021.05.07-ны өдөр хүртэл томилолтоор ажиллалаа. Томилолтоор ажилласан тайланг Монгол Улсын Шадар сайд бөгөөд | | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт; | Улсын Онцгой комиссын даргад 2021.05.17-ны өдрийн 02/1286 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2021.07.02-ны өдрийн 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах үүргийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. Энэ хүрээнд Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, 2021.09.20-ны Улсын комисст хүлээлгэн өгч, улмаар 2021.10.03-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Тавантолгой” ХК-иуд бүтээн байгуулалт, санхүүжилтийн гэрээг байгуулсан. Терминалын үйл ажиллагааг 2021.11.08-ны өдрөөс эхлүүлэн өдөрт 100 тээврийн хэрэгслээр экспорт хийж эхэлсэн боловч 2021.12.15-ны өдрөөс эхлэн зогсонги байдалд шилжсэн.<br>Шивээхүрэн боомтод 11.6 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Монголын алт (МАК)” ХХК, “Саусгоби сэндс” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Жавхлант орд” ХХК, “Цагаан өвөлжөө” ХХК “Сан транс” ХХК-иуд гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 80 орчим хувьтай байгаа бөгөөд БНХАУ-ын талд гацсан бараа бүтээгдэхүүнийг татан авч суурилуулах ажил хүлээгдэж байна.<br>2021 оны 11 дүгээр сарын байдлаар 15.2 сая тн нүүрс, 1,256.7 мян.тн зэсийн баяжмал 7,091.8 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 635.5 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. | | | |
| 55 | 10 | 13 | XIX.5.3. Монгол Улс, БНХАУ-ын хилийн Гашуунсухайт-Ганцмод төмөр замын боомтын галт тэрэг солилцох технологийн асуудлаар БНХАУ-ын талтай тохиролцсоны үндсэн дээр Гашуунсухайт боомтын 1435 мм-ийн царигтай төмөр замын өртөө, шилжүүлэн ачих байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, тэдгээрийг үе шаттайгаар цогцоор нь барьж байгуулахад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн | Зам, тээврийн хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах тул биелэлт гаргах боломжгүй. | | /-/<br><br>Цаашид уг тэмдэглэлийн биелэлт ЗТХЯ-наас гарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Цогтбаяр) нарт; | | | | |
| 156 | 10 | 14 | XIX.5.4 . “Тавантолгой-Зүүнбаян” төмөр замын ажлын гүйцэтгэлийн үлдэгдэл санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт. | Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК хооронд 2019.10.24-ний өдөр “Үнэт цаас худалдах, худалдан авах тухай гэрээ”-г холбогдох хууль, журмын дагуу байгуулсан.<br>2019.12.27-нд Санхүүгийн зохицуулах хорооноос 407 дугаар тогтоол гаргаж “Монголын төмөр зам” ТӨХК-ийн үнэт цаасыг албан ёсоор бүртгэж авсан. Үнэт цаас худалдан авах ажлыг “ЭТТ” ХК-аас үе шаттай зохион байгуулж 2020 оны 7 дугаар сард нийт 750 тэрбум төгрөгийн үнэт цаасыг бүрэн худалдан авч төлбөрийг “Монголын төмөр зам” ТӨХК-д шилжүүлж дууссан.<br>Одоогийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Монголын төмөр зам” ТӨХК-аас гаргасан 750 мянган ширхэг үнэт цаасыг эзэмшиж “Хаан банк” ХХК-ийн кастодиан үйлчилгээний газарт хадгалуулж байна.<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өмнөх 750 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас гадна дараах санхүүжилтийг “Зүүнбаян төмөр зам” ХХК-д хийгээд байна. Үүнд:<br>– Нэмэлт санхүүжилтээр 406.4 тэрбум төгрөг<br>– Нийт 1.15 их наяд төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.<br>Үлдэгдэл санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК, “Зүүнбаян төмөр зам” ХХК нарын хооронд хийгдэх “Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ”-г эцэслэн байгуулсны дараа өөрийн эзэмшлийн хувь, хэмжээний дагуу үе шаттай олгохоор ажиллаж байна. | | 70% | |
| 157 | 11 | 15 | **2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2021-06-23 Дугаар 2021_36**<br>XII.9.2. Нийслэлийн хүн амын хэрэгцээнд шаардлагатай сайжруулсан шахмал түлш болон “Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үндсэн түүхий эд (мидлинг), барьцалдуулагчийн нөөц бүрдүүлэлт, тээвэрлэлтэд онцгой анхаарал тавьж ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, | Энэ онд “Таван толгой түлш” ХХК нь Баруун болон Зүүн бүсийн үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар ажиллуулан Улаанбаатар хотын 6 дүүргийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангахаар хүчин чадлаа нэмэгдүүлэн ажиллаж, шахмал түлшний үндсэн түүхий эд /мидлинг/-ийг Дундын бүс болон Баруун, Зүүн үйлдвэрийн бүсэд нийт 725,600 тонн татан төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Миддлинг тээвэрлэлт /2021.10.25-аас хойш/ 4796 тээврийн хэрэгслээр 214 895 тонн мидлинг тээвэрлэсэн.<br>Барьцуулагч 17, шуудай 27 хоногийн нөөцтэй байгаа ба БНХАУ-ын Эрээн - Замын Үүдийн хилийн боомт түр хаагдсантай холбоотой нөөц тасрах эрсдэл үүсээд байгаа боловч бусад хилийн боомт буюу Ханги-Мандал, Гашуунсухайт-Ганцмодны боомтоор, өөр хотоос вагоноор татан авах арга хэмжээ авахаар судлан хамтран ажиллаж байна. Мөн шуудай нийлүүлэх гэрээт аж ахуйн нэгжүүдээс татан авах талаар зохион | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, "Тавантолгой түлш" ХХК (М.Ганбаатар)-д; | байгуулж ажиллах чиглэл өгсөн ба 800,000 ширхэг шуудай ачигдан орж ирсэн.<br>Мидлинг тээврийн тасралтгүй байдлыг хангах, тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:<br>✓ Сайжруулсан шахмал түлшний мидлинг тээвэрлэх зардлыг 2018 онд 65000 төгрөг байхаар тогтоосон бөгөөд бараа материал, тээврийн зардлын үнийн өсөлттэй уялдуулан 85000 төгрөг болгон өсгөх холбогдох тооцоо судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Холбогдох тооцоо судалгааг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021.10.29-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор 400 мянган тонн мидлинг тээвэрлэхэд шаардагдах 40.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.<br>✓ Мидлинг тээвэрт Зэвсэгт хүчний жанжин штабын тээврийн хэрэгслийг оролцуулах асуудлаар Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр холбогдох бусад албан тушаалтантай 2 удаагийн уулзалт зохион байгуулж, ЗХЖШ-ын 80 тээврийн хэрэгслийг мидлинг тээвэрлэлтэд дайчлан ажиллуулж байна. ЗХЖШ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу эдгээр автомашиныг нэг удаа татан авах түлш шатахууны зардлыг шийдвэрлэсэн.<br>✓ Мөн "Эрдэнэс Тавантолгой" ХК-тай тээвэрлэлтийн хариуцлагын гэрээтэй аж ахуй нэгж байгууллагуудыг мидлинг тээвэрт оролцуулах зорилгоор 3 удаагийн уулзалт зохион байгуулсан бөгөөд "Говь шанх транс" ХХК, "Монгол тээвэр нэгдэл"-ийн 16 тээврийн компани мидлинг тээвэр хийх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.<br>✓ Мидлинг тээврийн тонн тутмын үнийг 85000 төгрөг болгон тогтоосноор тээвэрлэлтэд оролцох иргэд, аж ахуйн нэгжийн сонирхол нэмэгдэж 4894 тээврийн хэрэгсэл гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд өдөрт 10000-11000 тонн мидлинг тээвэрлэж байна.<br>✓ "Энержи Ресурс" ХХК-тай өдөрт ачилт хийх машины тоог 200 хүртэл нэмэгдүүлэх, нэг машинд 66 тонн хүртэл ачилт хийх асуудлаар харилцан тохиролцсон.<br>Мидлинг тээврийн маршрутыг баталж, Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас Даланзадгад сум хүртэл 59.2 км замын дагуу шинээр тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, хуучин тэмдэг тэмдэглэгээг авах ажлыг зохион байгуулж байна. | | | |
| 58 | 12 | 16 | **2021 оны 7 дугаар сарын 16-ны өдөр 42 дугаар тэмдэглэл 2021-07-16**<br>**Дугаар 2021_42**<br>I. 2.1.. Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ("Сайжруулсан шахмал түлшний талаар авах | 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд "Таван толгой түлш" ХХК нь 2021.09.15-ны өдөр гэхэд 50,000 тонн түлш нөөцлөхөөр төлөвлөсөн ба Баруун бүсийн үйлдвэрийн 8 шугам ажиллаж өдөрт 1400-1600 тонн түлш үйлдвэрлэж байгаа бөгөөд 2021.09.14-ний өдрийн байдлаар 49,866 тонн түлшний нөөцтэй байна. Баруун бүсийн үйлдвэрийн 2 шугамыг 2021.09.15-ны өдөр залгаж, 2021.10.01-ний өдрөөс 12 шугам бүрэн ажиллана. Зүүн бүсийн үйлдвэрийн тоног | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 200 дугаар тогтоол, "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоол) асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. 2. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авахыг дараахь албан тушаалтанд даалгав: Сайжруулсан шахмал түлшний нөөцийг хэвийн хэмжээнд байлгах зорилгоор түгээлт, борлуулалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, айл өрхийн түлшний түгээлтэд "нэг өрх-нэг карт" зарчмыг хатуу баримталж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), "Тавантолгой түлш" ХХК (М.Ганбаатар)-д даалгав; | төхөөрөмжийн шинэчлэл хийгдэж дууссанаар 2021.10.01-ний өдөр үйлдвэрлэлийг эхлүүлнэ. Сайжруулсан шахмал түлшний нөөцийг хэвийн хэмжээнд байлгах зорилгоор айл өрхийн түлшний түгээлтийг "Нэг өрх-нэг карт" зарчимд шилжүүлэн сайн картын Зааварчилгааг баталгаажуулан ажиллаж байна. Борлуулалтын цэгийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа явагдаж байна. Нийт 933 цэг байгуулах хүсэлт ирсэн байгаагаас Нийслэлийн 6 дүүргүүд дэх цэгийн байршлуудыг "Таван толгой түлш" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021.08.20-ны өдрийн А/120 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг биечлэн очиж үзэж танилцан, борлуулалтын цэгийн сонгон шалгаруулалтыг хийж байна. | | | |
| 59 | 12 | 17 | I.2.2. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажилчдын орон тоог нэмэх замаар үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангах арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, "Тавантолгой түлш" ХХК (М.Ганбаатар)-д даалгав. | Баруун бүсийн үйлдвэрийн 8 шугам дээр нийт 787 ажилтан ажиллаж байгаа бөгөөд Зүүн баруун бүсийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд 116 ажилтан ажиллаж байна. | | 100% | |
| 60 | 13 | 18 | **2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 45 дугаар тэмдэглэл 2021-08-04 Дугаар 2021_45** | "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өмнөх | | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | XII.6. . Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн гүйцэтгэсэн ажлын төлбөр, тооцоо, зардал болон төслийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг 2021 оны 3 дугаар улиралд багтаан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр нарт даалгав; | 750 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас гадна дараах санхүүжилтийг "Зүүнбаян төмөр зам" ХХК-д хийгээд байна. Үүнд:<br>• Нэмэлт санхүүжилтээр 406.4 тэрбум төгрөг<br>• Нийт 1.15 их наяд төгрөгийн санхүүжилт<br>"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс төслийн үлдэгдэл санхүүжилтийг тус компани болон "Монголын төмөр зам" ТӨХК, "Зүүнбаян төмөр зам" ХХК нарын хооронд хийгдэх "Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ"-г эцэслэн байгуулсны дараа өөрийн эзэмшлийн хувь, хэмжээний дагуу үе шаттай олгохоор ажиллаж байна. | | |
| 61 | 14 | 19 | **2021 оны 8 дугаар сарын 18-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2021-08-18 Дугаар 2021_47**<br>XIY.6.. "Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ "Тавантолгой Түлш" ХХК-ийн Баруун бүсийн үйлдвэрийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцсан дүнгийн талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Тавантолгой Түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд дараахь арга хэмжээ авахыг Засгийн газрын холбогдох гишүүд болон албан тушаалтанд даалгав: Сайжруулсан шахмал түлшний түүхий эд (мидлинг) болон | Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор нүүрс тээвэрлэх нэгжийн үнийн өсөлтийг тооцон сайжруулсан шахмал түлшний 400 мянган тонн үндсэн түүхий эд (мидлинг)-ийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай 40.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн, гэрээ байгуулсны үндсэн дээр санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт зөвшөөрсөн. Үүний дагуу 2021.10.01-ний өдрөөс 2021.12.10-ны өдрийн дотор БХЯ-ны 80 автомашиныг тээвэрлэлтэд татан оролцуулж, 1,600 хувь хүний тээврийн хэрэгсэл, 400 аж ахуйн нэгжтэй нэмэлт гэрээ байгуулан Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас уртын тээврээр нийт 362,000 тонн миддлинг татан авсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | барьцалдуулагчийн нөөцийг шаардлагатай хэмжээгээр бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | | | |
| 162 | 14 | 20 | XIY.6.4. “Тавантолгой Түлш” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тодорхой болгох ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 316 дугаар “Тавантолгой түлш” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор эзэмшлийн хэмжээг тогтоосон. | 100% | |
| 163 | 14 | 21 | XIY.6.5. “Тавантолгой Түлш” ХХК-ийн түүхий эд (мидлинг) болон тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд шуурхай олгохыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ын дарга Б.Бат-Эрдэнэ, баруун, зүүн бүсийн үйлдвэрүүдийн тоосжилтыг бууруулах ажлын санхүүжилтийн асуудлыг шуурхай шийдвэрлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан нарт. | “Тавантолгой Түлш” ХХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд байгуулсан гэрээний хүрээнд 2021 онд нийт 53 тэрбум төгрөгийг түүхий эд (мидлинг) болон тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн санхүүжилтэд олгоод байна | 100% | |
| 164 | 15 | 22 | **2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл**<br>**2021-09-15**<br>**Дугаар 2021_51**<br>IX.4.3. Терминал ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд нүүрс олборлогч болон худалдан авагч аж ахуйн нэгжүүдээс нүүрс тээврийн төлөвлөгөөг өдөр бүрээр нарийвчлан гаргуулж, 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн дотор гаалийн урьдчилсан бүрдүүлэлт | “Эрдэнэс-Таван толгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК-иудад 2021.09.09-ний өдрийн 03/2341 дүгээр албан бичгээр Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээллийг Гаалийн ерөнхий газарт хүргүүлэх чиглэлийг хүргүүлсэн.<br>Улмаар Гашуунсухайт боомтод баригдсан Чингэлэг тээврийн терминал ашиглалтын асуудлаар Гаалийн ерөнхий газраас зохион байгуулсан уулзалтуудад тухай бүр оролцож, холбогдох мэдээллийг хүргүүлэн ажилласан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хийлгүүлсэн байх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | | | |
| 165 | 15 | 23 | IX.4.4. Нүүрс олборлогч аж ахуйн нэгжийн ашиглах хүчин чадалтай уялдуулж Терминалын ашиглалтын талбайн хөрөнгө оруулалтын хувь оролцоог тогтоох, ашиглалтын талбайд барих барилга байгууламж, зам, талбайн барилга угсралт, бүтээн байгуулалтын нийт зардлыг аж ахуйн нэгж бүрийн ашиглалтын талбайд ашиглах талбайн хэмжээг харгалзан тухайн аж ахуйн нэгжид хуваарилан хариуцуулж холбогдох гэрээ байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Манай яамнаас "Эрдэнэс Тавантолгой ХК, "Энержи ресурс" ХХК, "Тавантолгой" ХК хооронд 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан Гашуунсухайт боомт дахь чингэлэгт тээврийн терминалын барилга, байгууламж, зам, талбайн барилга угсралт, бүтээн байгуулалтын зардлыг хамтран санхүүжүүлэх тухай гэрээг байгуулах ажлыг зохион байгуулсан. Энэхүү гэрээний дагуу терминалын талбай ашиглалт, бүтээн байгуулалтын зардлын 60 хувийг "Эрдэнэс Тавантолгой" ХК, 25 хувийг "Энержи ресурс" ХХК, 15 хувийг "Тавантолгой" ХК хариуцаж байна. | 100% | |
| 166 | 16 | 24 | **2021 оны 10 дугаар сарын 6-ны өдөр 54 дүгээр тэмдэглэл 2021-10-06 Дугаар 2021_54** XIII.2.2. "Тавантолгой түлш" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн асуудлыг өөрчлөх талаар санал боловсруулж 2021 оны 10 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; | Тавантолгой ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2021.10.13-ны өдрийн 316 дугаар тогтоолоор тус компанийн нийт хувьцааны 51 хувийг Эрдэнэс Монгол ХК-д эзэмшүүлэх шийдвэр гарсан. | 100% | |
| 167 | 17 | 25 | **2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55** IY.3. "Тавантолгой түлш" ХХК-ийг цаашид үр ашигтай, бизнесийн зарчмаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө | "Тавантолгой түлш" ХХК-ийг цаашид үр ашигтай, бизнесийн зарчмаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бизнесийн төлөвлөгөөний хүрээнд дотоод үйл ажиллагаа менежментийг сайжруулах, төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх төслийг боловсруулан 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд танилцуулсан. Эрчим хүчний сайдаас эдийн засгийн үр ашигтай хувилбар тооцооллыг хийж дахин танилцуулах чиглэл өгсний дагуу ажиллаж байна. | /-/ Уг асуудал нь ЭХЯ-ны эрхлэх асуудалд хамаарах тул ХЯНАЛТААС | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | боловсруулан танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгав. | | ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 168 | 18 | 26 | **2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 56 дугаар тэмдэглэл 2021-10-20 Дугаар 2021_56** YIII.7. . Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтийн явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үе шатанд хүрснийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын “Чайна металлуржикал инженеринг” компани, ШУТИС-ийн харьяа Уул уурхайн хүрээлэн хамтран /CMEC/ боловсруулж 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс “Чайна металлуржикал инженеринг” компанитай байгуулсан гэрээний дагуу 2 дугаар шатны ажил болох нүүрс баяжуулах үйлдвэрийн FEED буюу урьдчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 2021 оны 08 дугаар сард дуусган хүлээж авсан байна. 2021.08.13-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 956,447,866,100 төгрөгийн өртөг бүхий тендерийг зарласан бөгөөд 2021.09.27-ны өдөр нээсэн. Тендерийн хугацаанд нийт 20 газар тендерийн бичиг баримт авснаас дөрвөн газар оролцохоор материалаа ирүүлсэн болович тендер шалгаруулалтын хүчинтэй хугацаа дуусгавар болсон учир амжилтгүй болсон. Улмаар 2021.11.15-ны өдөр дахин тендер зарласан бөгөөд 2021.12.15-ны өдөр хааж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. | | 70% | |
| 226 | 6 | 8 | XII.2.2. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлын төлөвлөгөөг баталж, үндсэн чиглэлд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Ашигт малтмалын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн биржийн тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг тус тус боловсруулах ажлын хэсгийг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгааг хийн, хуулийн төслийг боловсруулж байна. Хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Хуулийн төслийн боловсруулалтын явцаас танилцуулбал:<br>1/ Ашигт малтмалын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, мөн Ашигт малтмалын тухай хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсруулах зорилгын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2021.02.25-ны өдрөөс 2021.05.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллаж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж удирдлагуудад танилцуулсан.<br>Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгааг хийгээд байна.<br>Хуулийн төслийг Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албаны албан хаагчдад танилцуулан санал хүлээн авч байгаа бөгөөд 2022 оны 3 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.<br>2/ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын ерөнхий төлөвлөгөөг гарган Засгийн газрын 2021.03.10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сан байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан.<br>Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Уг судалгааны үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авч хуулийн төсөлд саналыг тусгасан.<br>Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр УУХҮЯамнаас 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 01/3068 дугаар албан бичиг хүргүүлээд байна.<br>3/ Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий холбогдох төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг УУХҮСайдын 2021 оны А/51 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулан, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бусад арга хэмжээг тус тус авч, Засгийн газрын 2021.09.29-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГ-ын 53 дугаар тэмдэглэл гарч, улмаар УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтож, УИХ-ыг өргөн мэдүүлэх тов тогтоолгох бичгийг 2021.12.28-нд хүргүүлээд байна. 4/ Үндсэн хуулиар иргэн байгалийн баялаг ашиглалтаас үр өгөөж хүртэх энэ талаар мэдэх эрхтэй байхаар заасны дагуу Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг УУХҮСайдын 2020 оны А/270 дугаар тушаалаар байгуулж, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааг хийж, үзэл баримтлалыг батлуулсан. Хуулийн төслийг боловсруулж яамны цахим хуудаст тавьж олон нийтийн саналыг авч байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 227 | 7 | 9 | **2021 оны 3 дугаар сарын 17-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2021-03-17 Дугаар 2021_18** XY.6.1. Эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой 100 төсөл, арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг доор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжийг харгалзан 100 төсөл, арга хэмжээг сонгож улсын төсөв, Засгийн газарт өрийн дарамтгүйгээр, хувийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн арга хэлбэрүүдийг ашиглан 2021 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх, хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд; | "Тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээ"-ний төсөлд УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний мэдээллийг шинэчлэн боловсруулж 2021.04.12-ны өдрийн 01/972 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжийг харгалзан уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн 8 төсөл, 2 арга хэмжээг тэргүүлэх ач холбогдолтой 100 төсөл, арга хэмжээнд оруулах талаар санал хүргүүлсэн болно.<br>Монгол Улсын Засгийн газрын 100 хоног буюу 2021.05.10-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Ковид цар тахлын дараах эдийн засгийг сэргээх 100+ төсөл арга хэмжээг танилцуулсан бөгөөд УУХҮЯамны эрхлэх асуудлын хүрээнд Үндэсний аюулгүй байдал, стратегийн ач холбогдол бүхий 6 төсөл, хөрөнгө оруулагчдад санал болгож буй 2 төсөл нийт 8 төсөл багтсан. Үүнд:<br>1. Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэр<br>2. Эрдэнэтийн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр<br>3. Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл<br>4. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн ҮТП байгуулах төсөл<br>5. Газрын тос боловсруулах үйлдвэр<br>6. Оюутолгой төслийн далд уурхайг ашиглалтад оруулах<br>7. Дорноговь аймагт хар төмөрлөгийн үйлдвэр барих<br>8. Дарханы металлургийн цогцолбор<br>Эдгээр төслүүд нь УИХ-ын 2021.12.30-ны өдрийн тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан бөгөөд төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргаж холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна. | 100% | |
| 228 | 8 | 10 | **2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19** II.. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов. 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнг хэлэлцэн дэмжээд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, хууль, | Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд УУХҮЯ-нд нийт 9 нэр төрлийн 29.7 тэрбум төгрөгийн, УУХҮСайдын багцын хэмжээнд 30.9 тэрбум төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөн, УУХҮСайдын 2021.04.13-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эдгээр батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу, хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг баримтлан зарцуулж байна. Засгийн газрын 2021 оны 15 дугаар тогтоолоор аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан бөгөөд УУХҮСайдын багцад хамаарах төсөл арга хэмжээ тусгагдаагүй болно. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтоолд заасны дагуу эрх шилжүүлэн зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгав. | | | |
| 229 | 9 | 11 | **2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр 21 дүгээр тэмдэглэл 2021-03-31 Дугаар 2021_21** Х.2.2. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх, үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлж байхыг Засгийн газрын гишүүд, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов. | Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой заадаг бөгөөд зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг үндэслэн үнэлгээг хийж байна. | 100% | |
| 230 | 10 | 12 | **2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр 22 дугаар тэмдэглэл 2021-04-07 Дугаар 2021_22** IX.3.2. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан цахим систем бүхий аргачлалын дагуу боловсруулах, холбогдох бэлтгэл ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн саналыг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлал"-ын дагуу боловсруулан 2021.05.06-ны өдрийн 01/1194 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 100% | |
| 231 | 11 | 13 | **2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2021-04-21 Дугаар 2021_25** | "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд УУХҮЯамнаас хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцыг нэгтгэн 7 хоног бүрийн Баасан гарагт Сангийн яаманд хүргүүлэн ажиллаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | XY.2. . "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар тус бүрийн арга хэмжээний хэрэгжилтийн явцыг Сангийн яамны "нэгдсэн мэдээллийг хянах цахим самбар"-т мэдээлж, танилцуулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | | | |
| 232 | 12 | 14 | **2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр 30 дугаар тэмдэглэл 2021-05-12 Дугаар 2021_30** XIX.2. . "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр тухайн салбарын хэмжээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцыг долоо хоног бүрийн Баасан гаригт Сангийн яаманд хүргүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад 7 хоног тутам үнэлгээ хийж, "нэгдсэн мэдээллийг хянах цахим самбар"-т мэдээлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид тус тус даалгав. | "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд УУХҮЯ 6 зорилт, арга хэмжээг хариуцан, хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 7 хоног бүрийн Баасан гарагт Сангийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.<br>УУХҮЯамны хариуцан хэрэгжүүлж буй дотоодын үнэт цаасны зах зээлд өрийн бичиг "ЭТТ БОНД" гаргаж, уул уурхай, зам, тээврийн салбарын томоохон бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг 2021 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх ажлын хүрээнд эхний арилжаагаар нийт 677.7 тэрбум төгрөгийн захиалгыг оролцогч талуудаас ирүүлж, төлөвлөгөөт зорилтыг бүрэн хангасан бол II дахь транчийн хүрээнд нэгтгэсэн дүнгээр 519.4 тэрбум төгрөг, 53.1 сая ам.долларын захиалгыг хийж анхны төлөвлөсөн хэмжээг 117 хувиар давуулан биелүүлсэн. Ингэснээр уул уурхай, зам, тээврийн салбарын томоохон бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байна.<br>Алтны олборлолтыг дэмжиж, алт тушаалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монголбанкнаас 2021.12.09-ний өдрийн байдлаар 5 аж ахуйн нэгжид 23.5 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн санхүүжилт, 13 аж ахуйн нэгжид 309.7 тэрбум төгрөгийн урт хугацаат санхүүжилт, нийт 333.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2021.12.30-ны өдрийн байдлаар Монголбанкны худалдан авсан үнэт металл 20.6 тоннд хүрээд байна. | 100% | |
| 233 | 13 | 15 | **2021 оны 6 дугаар сарын 1-ний өдөр 33 дугаар тэмдэглэл 2021-06-01 Дугаар 2021_33** YI.1. . Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар Монгол | "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд УУХҮЯамнаас дараах зорилтуудын хүрээнд төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.<br>• Зээл, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогдсон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхжүүлж, эдийн засгийг сэргээх хөшүүрэг болгож ажиллах.<br>• Хилийн ачаа тээврийн боомтын үйл ажиллагааг сэргээж, хүчин чадлыг нэмэгдүүлэн экспорт, импортын үйл ажиллагааг ариутгал | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. YI.2. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | халдваргүйжүүлэлтийн дэглэм дор зохион байгуулж гадаад худалдааны бараа эргэлтийг нэмэгдүүлэх.<br>• Улаанбаатар хот руу гаалийн хяналтад илгээх нөхцөлийг бүрдүүлэх, Замын-Үүд-Эрээн, Эрээнцав-Соловьевск төмөр замын боомтоор гарах экспортын бараа эргэлтийг нэмэгдүүлэх.<br>• Монгол-Хятадын хилийн бүсийн “Ногоон гарц” түр журмын хэрэгжилтийг эрчимжүүлж, Оросын талтай “Ногоон гарц” түр журмыг тохиролцон хэрэгжүүлж эхлэн улс хоорондын ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх.<br>• Алтны олборлолтыг дэмжиж, алт тушаалтыг нэмэгдүүлэх.<br>• Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийн санхүүгийн байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний үнийг үе шаттай бууруулах.<br>Арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж биелэлтийг 7 хоног бүрийн Баасан гарагт нэгтгэж явцын тайланг Сангийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.<br>УУХҮЯамны хариуцан хэрэгжүүлж буй дотоодын үнэт цаасны зах зээлд өрийн бичиг “ЭТТ БОНД” гаргаж, уул уурхай, зам, тээврийн салбарын томоохон бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг 2021 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх ажлын хүрээнд эхний арилжаагаар нийт 677.7 тэрбум төгрөгийн захиалгыг оролцогч талуудаас ирүүлж, төлөвлөгөөт зорилтыг бүрэн хангасан бол II дахь транчийн хүрээнд нэгтгэсэн дүнгээр 519.4 тэрбум төгрөг, 53.1 сая ам.долларын захиалгыг хийж анхны төлөвлөсөн хэмжээг 117 хувиар давуулан биелүүлсэн. Ингэснээр уул уурхай, зам, тээврийн салбарын томоохон бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байна.<br>Алтны олборлолтыг дэмжиж, алт тушаалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монголбанкнаас 2021.12.09-ний өдрийн байдлаар 5 аж ахуйн нэгжид 23.5 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн санхүүжилт, 13 аж ахуйн нэгжид 309.7 тэрбум төгрөгийн урт хугацаат санхүүжилт, нийт 333.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2021.12.30-ны өдрийн байдлаар Монголбанкны худалдан авсан үнэт металл 20.6 тоннд хүрээд байна. | | | |
| 234 | 14 | 16 | **2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 36 дугаар тэмдэглэл**<br>**2021-06-23**<br>**Дугаар 2021_36**<br>X.. 1. Тогтоол хүчингүй болгох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. 2. Энэ тогтоолоор | Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй. | | /-/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хүчингүй болгосон тогтоол, тогтоолын заалтын үр дүнд аж ахуйн нэгжүүд, эдийн засаг, төсөвт үзүүлж буй нөлөөллийг нэг жилийн хугацаагаар үнэлж дүгнэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа 2022 оны 2 дугаар улиралд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | | | |
| 235 | 14 | 17 | XII.2. . "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Шаардлагатай тохиолдолд цар тахлын үед эдийн засгийг сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | УУХҮЯ-аас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br>Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг УИХ-ын даргад өргөн бариад байна. | 100% | |
| 236 | 15 | 18 | **2021 оны 8 дугаар сарын 11-ний өдөр 46 дугаар тэмдэглэл**<br>**2021-08-11**<br>**Дугаар 2021_46**<br>XYII.2. 5. . Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр "Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно." гэж заасан. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Эдийн засгийн төрөлжилт, инноваци, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгон санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийж, хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж уул уурхайгаас олох үр шимийг Баялгийн сангаар дамжуулан иргэн бүрд тэгш, шударга хүртээх тогтолцоог бүрдүүлнэ." гэж заасан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын ерөнхий төлөвлөгөөг гарган Засгийн газрын 2021.03.10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сан байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Уг судалгааны үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авч хуулийн төсөлд саналыг тусгасан.<br>Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр УУХҮЯамнаас 2021.12.10-ны өдрийн 01/3068 дугаар албан бичиг хүргүүлээд байна. | | |
| 237 | 16 | 19 | **2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2021-08-25 Дугаар 2021_48**<br>XYI.5. . Улсын Их Хурлын 2021 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал болон Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын тогтоолд заасан хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, 2021 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон УУХҮЯамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлыг эрчимжүүлж, 2021 онд багтаан төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тооцож, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.<br>Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг 2021.12.28-нд УИХ-д өргөн мэдүүлэх албан бичгийг хүргүүлсэн. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2021.12.10-нд хүргүүлээд байна. | 100% | |
| 238 | 17 | 20 | **2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл 2021-09-15** | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд УУХҮСайдын багцад тусгагдсан "Монгол далд уурхайн музей, сургалт, судалгаа аялал жуулчлалын төв"-ийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг "Төсвийн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **Дугаар 2021_51** Х.3. . Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл болон санхүүжилтийн төрийн сан дахь гүйлгээний явц байдлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт болон санхүүжилтийн гүйлгээг гүйцэтгэгч нарт олгох явцыг үндэслэлгүйгээр удаашруулж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид учруулж буй хүнд суртлыг таслан зогсоохыг захиалагч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллага, бүх шатны төсвийн захирагч нарт; 2. Гүйцэтгэлийг хянан баталгаажуулдаг захиалагч, захиалагчийн хяналтын байгууллага болон аймаг, нийслэл, яамдын төрийн сангийн гүйлгээний үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, гарсан зөрчил дутагдлыг арилгах, буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийг Авлигатай тэмцэх газарт мэдээлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт; 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт болон санхүүжилт олгохтой холбоотой хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг “Иргэд, олон нийттэй харилцах-1111” төв, “е- | хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу хянаж санхүүжилтийн гүйлгээг гүйцэтгэгч аж ахуйн нэгжид түргэн шуурхай хүндрэлгүйгээр олгосон. 2021 онд хөрөнгө оруулалтын зардалд 1.7 тэрбум төгрөг батлагдсанаас гэрээний дагуу 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгосон ба гүйцэтгэл 96.9 хувиар биелсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | mongolia" системээр хүлээн авч, дүн шинжилгээ хийж, танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж нарт; 4. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасан хатуу баримтлан улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйлгээг шилжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч нарт; 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс санхүүжилтийн гүйцэтгэлийг захиалагч байгууллага хянан баталгаажуулсны үндсэн дээр Сангийн яамнаас гүйцэтгэгч нарт шууд шилжүүлэх цахим системийг нэвтрүүлж, санхүүжилтийн явцыг ил тод нээлттэй болгохыг Сангийн сайд Б.Жавхланд; 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажилт, санхүүжилтийн хугацаа болон зөрчил, хариуцлагын асуудлыг холбогдох хуульд тусгах талаар судлахыг Сангийн сайд Б.Жавхланд. | | | |
| 239 | 18 | 21 | **2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 52 дугаар тэмдэглэл 2021-09-22 Дугаар 2021_52** IX.6. . Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн боловсруулалтын явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд | Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сан байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Уг судалгааны үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авч хуулийн төсөлд саналыг тусгасан. | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | танилцуулав. Үүнтэй холбогдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай. | Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр УУХҮЯамнаас 2021.12.10-ны өдрийн 01/306 дугаар албан бичиг хүргүүлээд байна. | | |
| 240 | 19 | 22 | **2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55** II.. Энэ тогтоолоор хүчингүй болсонд тооцсон болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан дараахь бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр, салбарын бусад баримт бичигт уялдуулан тусгах замаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээг 2022 оны 3 дугаар сард багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов. Үүнд: Нэг. Төрөөс баримтлах бодлого: 1.“Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай” Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 333 дугаар тогтоол; 2.“Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого батлах тухай” Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 70 дугаар тогтоол; 3.“Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай” Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 169 дүгээр | Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт мөрдөгдөж байсан 29 зорилттой 8 тогтоолд ЗГ-ын 206 дугаар тогтоолын дагуу үр дүнд суурилсан эцсийн үнэлгээг хийж удирдлагад танилцуулав. ЗГ-ын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон 8 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн эцсийн үнэлгээ 59,2 хувьтай дүгнэгдсэн.<br><br>Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тушаалаар байгуулагдсан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт тус яамнаас “Эдийн засаг болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”, “Байгаль орчны зорилтот хөтөлбөр”, “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”, “Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр”-ийн төсөл боловсруулах дэд ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд хүчингүй болсон баримт бичгүүдийг салбарын бусад баримт бичигтэй уялдуулан дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн төсөлд тусгаад байна. | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтоол; Хоёр. Стратеги, зорилт, чиглэл: 4.“Стратеги батлах тухай” Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 127 дугаар тогтоол; 5.“Зорилт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 407 дугаар тогтоол; 6.“Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай” Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 95 дугаар тогтоол; Гурав. Үндэсний хөтөлбөр, хөтөлбөр: 7.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоол; 8.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 418 дугаар тогтоол; 9.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2015 оны 8 дугаар 4-ний өдрийн 324 дүгээр тогтоол; 10.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 325 дугаар тогтоол; 11.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоол; 12.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 346 дугаар тогтоол; 13.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 156 дугаар тогтоол; 14.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн 223 дугаар тогтоол; 15.“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 77 | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | дугаар тогтоол; 16.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоол; 17.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 34 дүгээр тогтоол; 18.“Хөтөлбөр шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 278 дугаар тогтоол; 19.“Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 44 дүгээр тогтоол; 20.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2011 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 277 дугаар тогтоол; 21.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 1999 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 129 дүгээр тогтоол; 22.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 282 дугаар тогтоол; 23.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн 207 дугаар тогтоол; 24.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 209 дүгээр тогтоол; 25.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 341 дүгээр тогтоол; 26.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 177 дугаар тогтоол; 27.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 298 дугаар тогтоол; 28.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 362 дугаар тогтоол; 29.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 318 дугаар тогтоол; 30.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 148 дугаар тогтоол; 31.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 214 дүгээр тогтоол; 32.““Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 278 дугаар тогтоол; 33.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 200 дугаар тогтоол; 34.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоол; 35.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 400 дугаар тогтоол; 36.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 202 дугаар тогтоол.” гэжээ. | | | | |
| 241 | 19 | 23 | XY.9.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах асуудлыг ирэх оны төсөв батлагдсан даруйд шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарлаж 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулж | УУХҮСайдын багцын хэмжээнд 2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ байхгүй бөгөөд үргэлжлэн хэрэгжиж байгаа “Бэрхийн далд уурхайн музейн барилгын ажил”-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэх тухай 2021.11.18-ны өдрийн 01/2841 дүгээр албан бичгийг хүргүүлсэн.<br>УУХҮСайдын 2022 онд Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөний төсөлд худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг 2022.04.01-ний өдрийн дотор зохион байгуулж дуусан байхаар тооцож төлөвлөн, 2021.11.24-ний өдрийн А/283 дугаар тушаалаар батлуулсан. | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дууссан байхаар тооцож, бэлтгэл хангахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгав; | | | |
| 242 | 19 | 24 | XY.13.6. "Худалдан авах ажиллагааны цахим систем"-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагын удирдлагад; | Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн гэрээ бүртгэх цэсэд 2021 оны тендер шалгаруулалтын үр дүнгээр байгуулагдсан нийт 20 гэрээг тухай бүр оруулан бүртгэж, гүйцэтгэгч рүү илгээсэн. | 100% | |
| 243 | 20 | 25 | **2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 56 дугаар тэмдэглэл 2021-10-20 Дугаар 2021_56** YIII.6. . Эрдэс баялгийн бирж байгуулах талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх асуудлыг түргэвчлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав. | Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн 2021.09.27-ны өдөр цахимаар зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авч, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон байна.<br>Улмаар Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авахаар хандсан бөгөөд ХЗДХЯ-наас зохих зөвшөөрлийг авсан. Харин Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 2021.10.06-ны өдрийн 2406, 2021.10.13-ны өдрийн 01/2460, 2021.11.09-ний өдрийн 01/2723, 2021.12.08-ны өдрийн 1/3038 дугаар албан бичгээр тус тус хандсан боловч УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг ирүүлээгүй байсан бөгөөд 2021.12.21-ний өдөр СЯ-наас УИХ-д тус хуулийн төслийг хууль тогтоомжийн дагуу өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгосон.<br>Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу УУХҮС Г.Ёндон 2022.01.05-ны өдөр УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлсэн. | 100% | |
| 244 | 21 | 26 | **2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 60 дугаар тэмдэглэл 2021-11-17 Дугаар 2021_60** II.2. Үндэсний баялгийн сангийн тухай, Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд урьдчилсан байдлаар танилцуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын ерөнхий төлөвлөгөөг гарган Засгийн газрын 2021.03.10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сан байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Уг судалгааны үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авч хуулийн төсөлд саналыг тусгасан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр УУХҮЯамнаас 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 01/3068 дугаар албан бичиг хүргүүлээд байна. | | |
| 245 | 22 | 27 | **2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл 2021-12-08 Дугаар 2021_63** XIY.. Ашигт малтмал, газрын тосны газрын даргыг шинээр томилох хүртэлх хугацаанд түүний албан үүргийг Төрийн албаны тухай хуулийн 43.3.1-д заасны дагуу дэд даргаар нь түр орлон гүйцэтгүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 10 ны өдрийн Б/07 дугаар тушаалаар Ашигт малтмал, газрын тосны газрын орлогч дарга Б.Түвшинжаргалаар түр орлон гүйцэтгүүлсэн. Улмаар МУЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 32 дугаар тогтоол гарч тус агентлагийн даргаар Л.Баярмандалыг түр томилсон. | 100% | |
| 246 | 23 | 28 | **2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 64 дүгээр тэмдэглэл 2021-12-14 Дугаар 2021_64** XIY.5.3. Бүх шатны төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдэд хийх хяналт шалгалтыг хэвээр үргэлжлүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгав. | УУХҮЯ-ны 2021 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу АМТХ-ийн 35.4-т заасны дагуу Уурхай нээх комиссын үйл ажиллагаанд дотоод аудит хийж удирдлагад танилцуулав.<br>Мөн төлөвлөгөөний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/157 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу "Геологийн төв лаборатори" ТӨҮГ-ын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайланг боловсруулж удирдлагад танилцуулав.<br>УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд сар бүр хяналт тавьж, зөрчил илэрсэн "Эрдэнэс Монгол" ХХК, "Эрчис ойл" ХХК, "Багануур" ХК, "Тавантолгой төмөр зам" ХХК, "Зүүн баян төмөр зам" ХХК, "Эрдэнэс алт ресурс" ХХК-уудад Төрийн нарийн бичгийн даргын зөрчил арилгуулах тухай 03/919 дугаар албан бичгийг хүргүүлэв. Газрын ховор элементийн судалгааны төслийн нэгж, Мон-Атом ХХК-д шилэн дансны хуулийн талаар зөвлөгөө өгч зөрчлийг арилгуулав. | 100% | |
| 247 | 24 | 29 | **2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 65 дугаар тэмдэглэл 2021-12-22 Дугаар 2021_65** XXIY.2. . Шинэ сэргэлтийн бодлого болон боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд хилийн боомтын хөгжлийн ерөнхий цогц төлөвлөгөөний төслийг Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Шинэ | Аж үйлдвэржилтийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж 2021.02.10-ны дотор ЗГ-ны хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Зэсийн баяжмал боловсруулах, катодын зэс үйлдвэрлэх, мөн хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжих төслүүд болон хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулаад байна. | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сэргэлтийн бодлогын Эрчим хүчний сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Аж үйлдвэржилтийн сэргэлтийн цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хот, хөдөөгийн сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Ногоон хөгжлийн сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Төрийн бүтээмжийн сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус даалгав. | | | | |
| | | | 5.3. Засгийн газрын албан даалгавар | | | | |
| 248 | 1 | 1 | **Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03**<br>1.1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэьтрүүлэх ажлыг 2019 онд багтаан иргэдэд чиргэдэл үүсгэлгүйгээр шуурхай зохион байгуулах. | УУХҮСайдын 2019 оны А/216 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний геомэдээллийн сан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.6.2 "Цахим үйлчилгээний төлбөрийн систем нэвтрүүлэх" арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд оруулсан. Геологийн баримтын төв архив иргэд, аж ахуйн нэгжид үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг цахимаар авч, ebarimt ашиглаж байна.<br>АМГТГ-т тусгай зөвшөөрлийн төлбөр, үйлчилгээний хөлсийг төрийн "ДАН" цахим төлбөр тооцооны нэгдсэн системд холбох ажлыг туршиж байна. Төлбөр тооцооны цахим систем болох E-Huulga, E-Tax, E-Barimt системд нэвтэрч нэхэмжлэл гаргах, баримт шивэх, хуулга авах цахим үйлчилгээнүүдийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн.<br>Үндэсний геологийн албанаас Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоо нэвтрүүлэх ажлын хүрээнд геологийн цаасан болон цахим баримтын төлбөр тооцоог цахимаар хүлээж авах системийг нэвтрүүлэн ажиллаж байна. /Цахим системийн хаяг: mris.mn/ | | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөр тооцоог иргэдээс qpay ашиглан авч байгаа ба qpay ээр хийгдсэн төлбөр Үндэсний геологийн албаны төрийн сангийн дансанд орж байгаа. Мөн гаднаас SWIFT үйлчилгээг ашиглан төлбөр тооцоог хүлээн авч байна. | | | |
| 49 | 1 | 2 | 1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчилан таниулах. | Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургах, төлбөр тооцооны талаар иргэдэд сурталчлан таниулах ажлыг эхлүүлж, холбогдох сургалтад тухай бүр хамруулж байна. Байгууллагын санхүү, төлбөр тооцоо хариуцсан ажилтнууд цахимаар нэхэмжлэл гаргах, баримт шивэх, хуулга авахад суралцаж, аж ахуйн нэгжүүдийн баримттай тулгаж баталгаажуулах үйл ажиллагаар хэвшүүлсэн. | | 100% | |
| 50 | 1 | 3 | 1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх. | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн цахим системд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийг тоон гарын үсэг ашиглан хүлээн авч эхэлсэн.<br>Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний дата төвийн хооронд 2020 онд байгуулагдсан БА99, 2020/34 тоот хамтран ажиллах гэрээний дагуу Тоон гарын үсгийн гэрчилгээ олгогдсон бөгөөд Уул уурхайн компьютержсон кадастрын системд нэвтрүүлээд байна.<br>Хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тайланг цахимаар хүлээн авах, хянах, баталгаажуулах цахим систем /e-reporting system/-д тоон гарын үсэг нэвтрүүлэх ажлын хүрээнд:<br>• Тус системд нэмэлт өргөтгөл сайжруулалтын ажлыг хийж улсын хэмжээнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч 4 байгууллага болох Мон Пасс Са ХХК, Тридемиум Кей ХХК, Мон компасс ХХК, Үндэсний дата төв УҮГ-ын тоон гарын үсгийн танилт нэвтрэлтийн програмуудыг системийн программтай холбож тусгай зөвшөөрөл эзэмшигчид аль ч байгууллагаас тоон гарын үсгийн гэрчилгээг авч системд нэвтрэх боломжтой болсон.<br>• 2022 оны уулын ажлын 1284 төлөвлөгөөг 2021.11.01-ний өдрөөс эхлэн цахимаар хүлээж авсан ба тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд тоон гарын үсэг хэрэглэж эхэлсэн.<br>• Аж ахуйн нэгжийн ирүүлсэн тайлан төлөвлөгөөг хянах, баталгаажуулах эрх бүхий УУСХ, НСХ, АМХХэлтсийн 3 дарга, гүйцэтгэх 23 албан хаагчид Үндэсний дата төв УҮГ-аас тоон гарын үсгийн гэрчилгээг авч 2021.12.01-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>Улсын бүртгэлийн ерөнхий газраас ХУР системээр дамжуулж аж ахуйн нэгжийн мэдээлэл авах ажлын хүрээнд:<br>ГУУКХэлтсийн дарга 1, гүйцэтгэх 5 албан хаагчид Үндэсний дата төв УҮГ-аас тоон гарын үсгийн гэрчилгээг авч 2021 оны 2 дугаар улирлаас хэрэглээнд нэвтрүүлээд байна. | | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 251 | 1 | 4 | 1.4. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах. | Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулж, тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэн хөрөнгө оруулалтыг татах боломжийг бүрдүүлэх зорилтыг тавин ажиллаж байна. Энэ хүрээнд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн баталж тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулж байна. Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран tender.gov.mn платформыг түшиглэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж туршилтын ажлыг хийж байна. tender.gov.mn нэгдсэн системээр тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг явуулснаар сонгон шалгаруулалтыг цаасан хэлбэрээр зохион байгуулахад сонирхогч аж ахуйн нэгжээс авдаг үйлчилгээний хураамж болох 250000 төгрөг буурна. | 70% | |
| 252 | 1 | 5 | 1.5. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бол эрхлэх асуудлын хүрээнд болон нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн актуудад зохих өөрчлөлт оруулах. | УУҮХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн ба шаардлагатай эрх зүйн актуудад өөрчлөлт оруулах холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.<br>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой төлбөр, үйлчилгээний хөлсний баримтын цахим хувийг нотлох баримтын хэмжээнд тооцож болох боломжийг судлан ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаад байна. | 70% | |
| 253 | 1 | 6 | 3.. Албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд. | УУҮХЯ-ны эрхлэх асуудлын хүрээний цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2020.12.25-ны өдрийн 03/3218 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Албан даалгаврын хэрэгжилтийг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах ажлын хүрээнд тогтмол гаргаж байна. | 100% | |
| 254 | 2 | 7 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2**<br>1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх; | Эрдэс баялгийн салбарын хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөг ЗГХЭГ-т хүргүүлсэн. УУХҮЯ-нд төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх ажлын хүрээнд ХШҮДАГ-т Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтэс байгуулан 3 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү ажлыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж шинээр авч яамны дотоод ажлын хэрэгцээнд ашиглан төрийн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Төрийн энтерпрайз архитектурын платформыг нэвтрүүлэх сургалтад 2 мэргэжилтэн сургасан. Мөн "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" УҮГ-тай | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамтран УУХҮЯамнаас олгодог тусгай зөвшөөрлийг цахимжуулах системүүдийн суурилуулалт хийхээр серверийг бүрэн шинэчилсэн. Үүнд: R740 сервер 32 core, Vmware виртуал үйлдлийн систем хуулах программ, PA-220 firewall, Microsoft 365 нэвтрүүлсэн. “Office 365”-ийн Sharepoint хөгжүүлэхэд 1 ажилтанг сургасан. Цахим төлбөр тооцоонд шилжсэний дараа байгууллагын дотоод дүрэм, журамд өөрчлөлт оруулах санал боловсруулж батлуулан, холбогдох сургалтад ажилтнуудыг хамруулна. | | |
| 255 | 2 | 8 | 1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх; | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж “e-Mongolia” цонхонд нэгтгэх салбарын 18 ажлуудын санал боловсруулж ХХМТГ-т ТНБД-ын 2020.12.24-ний өдрийн 03/3205 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн лавлагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д холбож тухай бүр хянах, баталгаажуулах ажлыг хийж байна. | 100% | |
| 256 | 2 | 9 | 1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах; | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн цахим системд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийг тоон гарын үсэг ашиглан хүлээн авч эхэлсэн. Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний дата төвийн хооронд 2020 онд байгуулагдсан БА99, 2020/34 тоот хамтран ажиллах гэрээний дагуу Тоон гарын үсгийн гэрчилгээ олгогдсон бөгөөд Уул уурхайн компьютержсон кадастрын системд нэвтрүүлээд байна. Хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тайланг цахимаар хүлээн авах, хянах, баталгаажуулах цахим систем /e-reporting system/-д төлөвлөгөө тайлан хянах удирдах 4, гүйцэтгэх 28 албан хаагчид тоон гарын үсгийн төхөөрөмж худалдан авч Үндэсний дата төв ТӨҮГ-р бүртгэж, баталгаажуулан тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Төрийн байгууллага хооронд албан бичгийг 2022 оны 1 дүгээр сараас цахимаар хүргүүлэхтэй холбогдуулан албан бичиг баталгаажуулах эрх бүхий газрын орлогч дарга болон нийт хэлтсийн дарга нарт тоон гарын үсгийн гэрчилгээ аваад байна. | 100% | |
| 257 | 2 | 10 | 1.6. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах; | Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулж, тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэн хөрөнгө оруулалтыг татах боломжийг бүрдүүлэх зорилтыг тавин ажиллаж байна. Энэ хүрээнд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн баталж тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулж байна. Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран tender.gov.mn платформыг түшиглэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж туршилтын ажлыг хийж байна. tender.gov.mn нэгдсэн системээр тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг явуулснаар сонгон шалгаруулалтыг цаасан хэлбэрээр | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулахад сонирхогч аж ахуйн нэгжээс авдаг үйлчилгээний хураамж болох 250000 төгрөг буурна. | | |
| 258 | 2 | 11 | 1.7. ХУР системд холбогдсон мэдээллийн системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах; | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн цахим системд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авахад шаардлагатай мэдээллийг ХУР систем ашиглан хүлээн авч шийдвэрлэж эхэлсэн.<br>Үндэсний дата төв болон Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээлэл солилцох, систем ашиглах 2020.03.04-ний өдрийн ХУР/20-12 2020/33 дугаар гэрээний дагуу ХУР системтэй холбох аж ахуй нэгжийн мэдээллийн сантай Уул уурхайн компьютержсон кадастрын системийг холбох ажил хийгдсэн. Одоогоор туршилт сайжруулалтын ажил хийгдэж байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Улсын бүртгэлийн газрын Мэдээллийн аюулгүй байдлын дүрэм, журамд нийцүүлэн ХУР системд холбогдож үйлчилгээ авч ажиллаж байна. | 70% | |
| 259 | 2 | 12 | 1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах; | УУХҮЯамны цахим хуудас /www.mmhi.gov.mn/, олон нийтийн бусад сүлжээ /facebook, twitter/, АМГТГ-ын www.mrpam.gov.mn, Үндэсний геологийн албаны https://ngs.gov.mn/ цахим хуудсаар дамжуулан холбогдох хууль, тогтоомжийн хэлэлцүүлэг, аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллийг түгээж салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулдаг. Эрдэс баялгийн мэдээллийн хайлтын систем болох https//www.mris.mn// төрөлжсөн өгөгдлийн сангийн мэдээллийн хураангуйг хэрэглэгчдэд интернетийн орчинд нээлттэйгээр хүргэж байна.<br>Хайгуул, уулын ажлын тайлан төлөвлөгөөний цахим систем www.inforef.mrpam.gov.mn, уул уурхайн кадастрын систем https://cmcs.mrpam.gov.mn/cmcs, уул уурхайн боловсролыг дэмжих зорилго бүхий http://edu.mrpam.gov.mn/ цахим хуудас, уул уурхайн хөрөнгө оруулагчдад зориулсан http://invest.mrpam.gov.mn/, газрын тосны бүтээгдэхүүний газар зүйн байрлалын систем https://gisoil.mrpam.gov.mn/, газрын тосны бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд зориулан https://oil.mrpam.gov.mn/ зэрэг цахим хуудсаар дамжуулан уул уурхай, газрын тосны салбарт ажиллаж байгаа 4000 гаруй аж ахуйн нэгжтэй цахимаар холбогдон ажиллаж байна. | 100% | |
| 260 | 2 | 13 | 1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг "Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем"-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох. | УУХҮЯ, АМГТГ, ҮГА нь дотоод ажлын хэрэгцээнд ABLE cloud цахим систем ашиглаж албан бичиг болон бусад материалыг цахимаар солилцдог. УУХҮЯ нь "Майкрософт Оффис 365"-ийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж худалдан авч програмын хөгжүүлэлтийг хийж УУХҮЯ-ны албан хэрэгцээнд нэвтрүүлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 261 | 3 | 14 | **Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2021-09-15 Дугаар 2021_01** 12.1. 12.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд: 12.1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлэх; | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын ерөнхий төлөвлөгөөг гарган Засгийн газрын 2021.03.10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Үүнтэй холбоотойгоорМонгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сан байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан.<br>Засгийн газрын 2021.09.22-ны өдрийн хуралдаанд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн талаар танилцуулсан. Улмаар хуулийн төслийг хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулгыг УУХҮЯамны вэб хуудсанд 2021.10.13-ны өдөр байршуулж олон нийтээс цахимаар санал авч байна. Хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2021.10.29, 2021.11.01-ний өдөр олон нийтэд цахимаар хэлэлцүүлсэн.<br>Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Уг судалгааны үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авч хуулийн төсөлд саналыг тусгасан.<br>Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр УУХҮЯ-наас 2021.12.10-ны өдрийн 01/3068 дугаар албан бичиг хүргүүлээд байна. | 100% | |
| 262 | 3 | 15 | 12.2. 12.2.Эрдэс баялгийн бирж байгуулах асуудлыг судлан танилцуулах; | Эрдэс баялгийн бирж байгуулах асуудлаар судалгаа хийж, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн хуулийн дагуу боловсруулж, яамдаас санал авсан. Хуулийн төслийг 2021.09.29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, Засгийн газрын гишүүдийн зүгээс дэмжсэн. Сангийн сайдын зүгээс ч мөн дэмжсэний дагуу хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авсан. Харин Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зүгээс зөвшөөрлийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн ч агуулгын хувьд Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор дэмжих боломжгүй байгаа талаар хариуг ирүүлээд байна. Иймээс уг асуудлаар Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн даргатай уулзсан болovч уг зөвшөөрлийг өгөх боломжгүй талаар мэдэгдсэн. Иймд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хэлбэрээс өөрөөр асуудлыг УИХ-д өргөн мэдүүлэхэд эрсдэл үүсээд байсан.<br>Улмаар СЯ-наас 2021.12.21-ний өдөр УИХ-д тус хуулийн төслийг хууль тогтоомжийн дагуу өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгосон. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | үзэл баримтлал, танилцуулгыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу УУХҮ-ийн сайд Г.Ёндон 2022.01.05-ны өдөр УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлсэн. | | |
| 263 | 3 | 16 | 12.3. 12.3.Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн бүтээн байгуулалтад байнгын хяналт тавьж, газрын түүхий тос дамжуулах хоолойн барилга угсралтын ажлыг шуурхай эхлүүлэх; | Засгийн газрын бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Ерөнхий сайдын 2020 оны 32 дугаар захирамжийг Ерөнхий сайдын 2021.07.24-ний өдрийн 122 дугаар, 2021.08.09-ний өдрийн 133 дугаар захирамжаар Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан Шадар сайдын 2021.08.17-ны өдрийн 87 дугаар тушаалаар ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, төслийн ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан гарсан Шадар сайдын 2021 оны 01/21 дүгээр Албан даалгавраар өгөгдсөн үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Тос дамжуулах хоолойн тендерийг 2021.10.23-ны өдөр нээж гүйцэтгэгчийг шалгаруулсан бөгөөд гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний нөхцөл, гэрээний төслийг боловсруулж байна. | 70% | |
| 264 | 3 | 17 | 12.4. 12.4.Зэс хайлуулах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх; | “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулан УУХҮСайдын 2021.11.04-ний өдрийн 01/2698 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 % | |
| 265 | 3 | 18 | 12.5. 12.5.“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг түшиглэн нүүрс угаах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх; | Засгийн газрын 2021.10.20-ны өдрийн хуралдаанд Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтийн явцын талаар УУХҮСайд танилцуулга хийсэн. Тус хуралдааны 56 дугаар тэмдэглэлээр төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахтай холбогдолтой үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг УУХҮСайдад даалгасан. “Эрдэнэс Тавантолгой” ХХК 2021.08.13-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 956,447,866,100 төгрөгийн өртөг бүхий тендерийг зарласан бөгөөд 2021.09.27-ны өдөр нээсэн. Тендерийн хугацаанд нийт 20 компани тендерийн бичиг баримт авснаас дөрвөн газар оролцохоор материалаа ирүүлсэн болович тендер шалгаруулалтын хүчинтэй хугацаа дуусгавар болсон учир амжилтгүй болсон. Улмаар 2021.11.15-ны өдөр дахин тендер зарлаж сонгон шалгаруулалтыг явуулснаар нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх түлхүүр гардуулах нөхцөлтэй тендер зарлаж гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Норинко Интернэшнл Лимитэд” болон “Течгарт (Бээжин) Инженеринг”-ийн түншлэл шалгарсан. | 70% | |
| 266 | 3 | 19 | 12.6. 12.6.Хар төмөрлөгийн (кокс, ширэм, шууд ангижруулсан төмөр) үйлдвэрлэлийг Дархан-Уул, Орхон, | “Хар төмөрлөгийн үйлдвэр байгуулах төслүүд (Дархан Уул аймагт “Кью Эс Си” ХХК-ийн Дарханы төмөрлөгийн үйлдвэр дээр хэрэгжүүлж байгаа Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл, Орхон аймагт | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Дорноговь аймагт хөгжүүлэх асуудлыг судлан ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх; | “Бэрэн групп” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төсөл”, Дорноговь аймагт МДМУ ХХК “Хар төмөрлөгийн цогцолбор”-ийн төсөл, “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Хар төмөрлөгийн цогцолбор” байгуулах төсөл)-ийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулан холбогдох материалын хамт УУХҮСайдын 2021.10.25-ны өдрийн 01/2561 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | | |
| 267 | 3 | 20 | 12.7. 12.7.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх; | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх геологийн судалгааны ажлыг эрчимжүүлэх чиглэлээр:<br>-1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 3, Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх 1 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр хүлээн авсан.<br>-2021 онд үргэлжлэн хэрэгжих 49 төслийн суурин болон хээрийн судалгааны ажилд шуурхай хяналт хийсэн. Шуурхай хяналтын үр дүнг нэгтгэн, зарим төслүүдийн ажлын хэмжээ, аргачлалд шаардлагатай өөрчлөлтийг хийж ажлыг үргэлжлүүлсэн.<br>-МУ-ын ашигт малтмалын нөөц, баялгийг нэмэгдүүлэх зорилгоор Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт 2020 оноос эхлүүлсэн үнэт, ховор, холимог металлын Эрэл-Үнэлгээ-1 төслийг тус сумын нутгийн удирдлага, иргэд эсэргүүцэн ажлыг зогсоосон тул гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэхээр ажиллаж байна.<br>-2021 онд 27.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 53 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар гүйцэтгэгч нараас 24.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл ирүүлснийг санхүүжүүлсэн. Ковид-2019 цар тахлын хөл хорио, өвчлөл, тендерийн үйл ажиллагаа, орон нутгийн иргэдийн эсэргүүцэл зэргээс шалтгаалан 3.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гаргаагүй тул төсөвт буцаасан. Ажлын явцын талаар ЗГ-ын хуралдаанд 2021.10.20-ны өдөр танилцуулсан бөгөөд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан ажлын явцын талаар танилцуулах үүрэг өгөгдсөн. Эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр: Ашигт малтмалын хайгуулын ажлын тайлан 104 тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн алт /үндсэн/ 76,433.75 мян.тн/кг металлаар, алт /шороо/ 3,799.34 кг металлаар, мөнгө 862.01 мян.тн/тн металлаар, зэс 65,749.25 мян.тн/тн металлаар, төмөр 1,366.17 мян.тн хүдрээр, никель 15,918.09 мян.тн/тн металлаар, вольфрам 2,147.29 мян.тн/тн металлаар, кобальт 1,501.36 тн металлаар, хайлуур жонш 974.31 мян.тн металлаар, манган 97.06 мян.тн металлаар, чулуун нүүрс 195.06 сая тн, шохойн чулуу 249.8 | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | сая.тн, дайрга 68.7 сая м3, бал чулуу 1,057.73 мян.тн, гөлтгөнө 161.22 мян.тн, занар 21,976.5 мян.м3, лити 713.15 мян.тн металлаар, стронци 831.74 мян.тн, кали 20,685.47 мян.тн металлаар, молибден 21,211.56 мян тн/тн металлаар, цагаан тугалга 290.06 тн металлаар, кварц 465.21 мян.тн, гантиг 5,274.15 мян.м3, элсэн чулуу 56,877.52 мян.м3, элс 5,740.11 мян.м3, шавар 5,736.63 мян.м3, элс-хайрга 1,627.04 мян.м3, газрын тос 1.04 сая баррелийг улсын нэгдсэн санд бүртгэн нөөцийг өсгөсөн. | | |
| 268 | 3 | 21 | 12.8. 12.8.Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулж, хүнээс хамааралгүй, ил тод, шуурхай болгох; | АМтХ-ийн 10.1.2-д заасны дагуу ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журмыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлах эрхийг авч УУХҮС-аар батлуулж Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр ажиллаж байна. Мөн тусгай зөвшөөрлийг цахимаар олгох ажлыг Худалдан авах ажиллагааны газартай хамтран гүйцэтгэж туршилтын ажлыг эхлүүлээд байна. | 70% | |
| 269 | 4 | 22 | **Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2021-09-15 Дугаар 2021_01**<br>17. 17.Албан даалгаварт тусгагдсан төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд онцгой анхаарч ажиллахыг Засгийн газрын нийт гишүүдэд тус тус үүрэг болгосугай. | “Хар төмөрлөгийн үйлдвэр байгуулах төслүүд (Дархан Уул аймагт “Кью Эс Си” ХХК-ийн Дарханы төмөрлөгийн үйлдвэр дээр хэрэгжүүлж байгаа Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл, Орхон аймагт “Бэрэн групп” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төсөл”, Дорноговь аймагт МДМУ ХХК “Хар төмөрлөгийн цогцолбор”-ийн төсөл, “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Хар төмөрлөгийн цогцолбор” байгуулах төсөл)-ийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулан холбогдох материалын хамт УУХҮСайдын 2021.10.25-ны өдрийн 01/2561 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Мөн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулан УУХҮСайдын 2021.11.04-ний өдрийн 01/2698 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Ерөнхий сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгаврын УУХҮСайдад өгсөн 12.7-д заасан чиглэлийн хэрэгжилтийг хангана ажиллаж байна. Үүнд:<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх геологийн судалгааны ажлыг эрчимжүүлэх чиглэлээр:<br>1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 3, Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх 1 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр хүлээн авсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2021 онд үргэлжлэн хэрэгжих 49 төслийн суурин болон хээрийн судалгааны ажилд шуурхай хяналт хийсэн. Шуурхай хяналтын үр дүнг нэгтгэн, зарим төслүүдийн ажлын хэмжээ, аргачлалд шаардлагатай өөрчлөлтийг хийж ажлыг үргэлжлүүлсэн.<br>-МУ-ын ашигт малтмалын нөөц, баялгийг нэмэгдүүлэх зорилгоор Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт 2020 оноос эхлүүлсэн үнэт, ховор, холимог металлын Эрэл-Үнэлгээ-1 төслийг тус сумын нутгийн удирдлага, иргэд эсэргүүцэн ажлыг зогсоосон тул гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэхээр ажиллаж байна.<br>-2021 онд 27.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 53 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар гүйцэтгэгч нараас 24.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл ирүүлснийг санхүүжүүлсэн. Ковид-2019 цар тахлын хөл хорио, өвчлөл, тендерийн үйл ажиллагаа, орон нутгийн иргэдийн эсэргүүцэл зэргээс шалтгаалан 3.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гаргаагүй тул төсөвт буцаасан. Ажлын явцын талаар ЗГ-ын хуралдаанд 2021.10.20-ны өдөр танилцуулсан бөгөөд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан ажлын явцын талаар танилцуулах үүрэг өгөгдсөн. Эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр: Ашигт малтмалын хайгуулын ажлын тайлан 104 тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн алт /үндсэн/ 76,433.75 мян.тн/кг металлаар, алт /шороо/ 3,799.34 кг металлаар, мөнгө 862.01 мян.тн/тн металлаар, зэс 65,749.25 мян.тн/тн металлаар, төмөр 1,366.17 мян.тн хүдрээр, никель 15,918.09 мян.тн/тн металлаар, вольфрам 2,147.29 мян.тн/тн металлаар, кобальт 1,501.36 тн металлаар, хайлуур жонш 974.31 мян.тн металлаар, манган 97.06 мян.тн металлаар, чулуун нүүрс 195.06 сая тн, шохойн чулуу 249.8 сая.тн, дайрга 68.7 сая м3, бал чулуу 1,057.73 мян.тн, гөлтгөнө 161.22 мян.тн, занар 21,976.5 мян.м3, лити 713.15 мян.тн металлаар, стронци 831.74 мян.тн, кали 20,685.47 мян.тн металлаар, молибден 21,211.56 мян тн/тн металлаар, цагаан тугалга 290.06 тн металлаар, кварц 465.21 мян.тн, гантиг 5,274.15 мян.м3, элсэн чулуу 56,877.52 мян.м3, элс 5,740.11 мян.м3, шавар 5,736.63 мян.м3, элс-хайрга 1,627.04 мян.м3, газрын тос 1.04 сая баррелийг улсын нэгдсэн санд бүртгэн нөөцийг өсгөсөн.<br>Ерөнхий сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгаврын УУХҮСайдад өгсөн 12.8-д заасан чиглэлийн хэрэгжилтийг хангана ажиллаж байна. Үүнд:<br>12.8. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын төслийг боловсруулж 2021.09.28-ны өдрийн 01/2326 дугаар албан бичгээр яамдаас санал авахаар хүргүүлсэн. Мөн 2021.09.29-ний өдрөөс УУХҮЯамны цахим хуудсанд байршуулан олон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нийтээс санал авсан. Дээрх журмын төслийн хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлэх судалгааг хийх, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2021.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар байгуулсан. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгох боломжийг судалж, tender.gov.mn платформийг ашиглахаар шийдвэрлэж байна. Сонгон шалгаруулалтын журмыг батлах эрх олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т 12.03-ны өдрийн 02/3005 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2021. 12.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн 381 дүгээр тогтоолоор УУХҮСайдад журам батлах эрхийг олгосон.<br>Ерөнхий сайдын 2021.07.24-ний өдрийн 122 дугаар, 2021.08.09-ний өдрийн 133 дугаар захирамжаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан Шадар сайдын 2021.08.17-ны өдрийн 87 дугаар тушаалаар ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, төслийн ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан гарсан Шадар сайдын 2021 оны 01/21 дүгээр Албан даалгаврын хэрэгжилтийг 2021.12.01-ний өдрийн байдлаар гаргаж ШС-ын ажлын албанд хүргүүлсэн. Тос дамжуулах хоолойн тендерийг 2021.10.20-ны өдөр нээж үнэлгээг хийж тендерт оролцсон компаниудад мэдэгдэл хүргүүлээд байна. Ерөнхий сайдын албан даалгавраар өгсөн үүргийн дагуу үйлдвэрийн бүтээн байгуулалт болон тос дамжуулах хоолойн төслийн талаар ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2021.10.26-ны өдрийн 01/2570 дугаар албан бичгийг ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч төслийн талаарх мэдээллийг ЕС-д сар бүр хүргүүлж байгаа тул уг асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн | | | |
| | | | | **Нийтлэг асуудлын дундаж: 94.3 хувь** | | | |
| | | | | **НИЙТ ДҮН: 91.8 хувь** | | | |

## УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР БАТЛАГДСАН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ЖАГСААЛТ
/2021 оны жилийн эцсийн байдлаар/

2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр

| № | *Шийдвэрийн дэс дугаар* | *Зүйл, заалтын дэс дугаар* | *Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга* | *Хэрэгжилтийн явц* | *Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)* |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | | | а. Монгол Улсын хууль | | |
| 1 | 1 | 1 | **Хөрөнгө оруулалтын тухай 2013-10-03 Дугаар 2013.11.01** 11.2.1.. Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих; (11.2.Доор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:) | Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 2019.11.28-ны өдөр батлагдсан хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, гаалийн албан татварыг хөнгөлөх тухай Монгол Улсын Засгийн газрын 2020.05.13-ны өдрийн 172 дугаар тогтоол батлагдан гарсан. Тус тогтоолоор Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт барих газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга, байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах дотоодын үйлдвэрээс хангах боломжгүй импортоор оруулж ирэх бараа материалын жагсаалтыг баталсан. | 100% ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 2 | 2 | 2 | **Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих 2021-01-29 Дугаар 2021.01.29** 3.3. Энэ хуульд заасан харилцааг нарийвчлан зохицуулах Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална. | Засгийн газрын 2021.08.11-ний өдрийн хуралдаанаар Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмын төслийг хэлэлцүүлж, 241 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100% ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 3 | 3 | 3 | **Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29** | Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2020.04.30-ны өдрийн тушаалаар "Хилийн автозамын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам"-ыг баталсан. Энэхүү журмын 1.4.-д "Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагаа | 100% ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 8.1.4.. Дамжин өнгөрөх болон улс хоорондын ачаа тээвэр, эрдэс баялгийн экспортын хүрээнд ачаа тээврийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журмыг батлах; (8.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Улсын онцгой комисс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:) | Онцгой нөхцөл байдалд зохион байгуулах" тухай асуудлыг тусгуулсан. | |
| 4 | 4 | 4 | **Хог хаягдлын тухай**<br>**/Шинэчилсэн найруулга/**<br>**2017-05-12**<br>**Дугаар 2017.05.12**<br>8.6.2.. 8.6.Хог хаягдлын талаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.6.2. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам батлаж, хэрэгжилтэд хяналт тавих; | “Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам”-ын төслийг боловсруулан, УУХҮСайдын 2020.04.27-ны өдрийн А/87 дугаар тушаалаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 2020.05.15-ны өдрийн 4797 дугаарт бүртгүүлсэн. | 100%<br><br>Журмыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| | | | б. Улсын Их Хурлын тогтоол | | |
| 5 | 1 | 1 | **Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (УИХ 2016.07.21-ний 12 дугаар тогтоолд “21.Үндэсний геологийн алба” гэж нэмсүгэй)**<br>**2020-01-30**<br>**Дугаар 2020 №12**<br>3.. Үндэсний геологийн албыг УУХҮСайдын батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан байгуулж ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай. | УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албыг Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолоор байгуулсан. Тус тогтоолоор Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт зөвшөөрсөн. Үндэсний геологийн албаны орон тооны дээд хязгаарыг 68 байхаар тогтоосон боловч Засгийн газрын 38 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 35 байхаар өөрчлөлт оруулсан. Өнөөдрийн байдлаар Үндэсний геологийн албаны үйл ажиллагаа жигд явагдаж байна. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 6 | 2 | 2 | **Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай**<br>**2012-01-05**<br>**Дугаар 2012 №01**<br>1.1.. 1.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай: 1.1. Газрын тос боловсруулах бага болон дунд хүчин | ҮАБЗ-ийн 2014.03.17-ны өдрийн хуралдаанаас газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах зөвлөмж гаргасан. БНЭУ-аас олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар шийдвэрлэж, Монгол Улсын70 Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд 2016.04.28-ны өдөр байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийг Монгол Улсын Их хурал 2017.05.31-ний өдөр соёрхон баталсан. Засгийн газрын 2017.03.20-ны өдрийн 92 | 100%<br><br>УИХ-ын тогтоолын заалт нь бүрэн хэрэгжээгүй, цаг хугацааны ач холбогдолгүй болсон, ҮАБЗ, УИХ, ЗГ-аас гарсан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | чадлын үйлдвэрийг газрын тосны ордод түшиглэсэн байдлаар ойрын хугацаанд барьж байгуулах ажлыг түргэтгэх; | дугаар тогтоолоор ГТБҮ-ийн төслийг хэрэгжүүлэх төрийн өмчит компанийг байгуулсан. Үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг БНЭУ-ын төрийн өмчит “Инженерс Индиа Лимитэд” компани боловсруулж, 2018 оны 11 дүгээр сард УУХҮЯамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэж, хүлээн авсан. Газрын тос боловсруулах үйлдвэр нь үндсэн технологийн 12 байгууламж болон дагалдах, туслах барилга байгууламжуудаас бүрдэнэ. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь Төслийн менежментийн зөвлөх (ТМЗ) үйлчилгээ үзүүлж буй Engineers India Limited компанитай хамтран үйлдвэрийн анхдагч процессын байгууламжууд, хангамжийн систем, дагалдах байгууламж, цахилгаан станцыг Монгол орны нөхцөл, стандартын шаардлагад нийцүүлэн төлөвлөж, ерөнхий дизайн, инженерчлэлийн багц (Basic design engineering package, BDEP) болон суурь инженерчлэлийн зураг төсөл (Front End Engineering Design, FEED)-ийг боловсруулсан. Төслийн хүрээнд үйлдвэрийн гаднах дэд бүтэц (17,5 км тусгай зориулалтын хүнд даацын авто зам, 27,7 км салаа төмөр зам, дэд өртөөний барилга байгууламж, 18,2 км 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10кВ-ын дэд станц)-ийн барилга байгууламжийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр барьж байгуулан, 2019 оны 11 дүгээр сард ашиглалтад хүлээн авсан. Мөн газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл нь үндсэн 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд: | шийдвэрүүдээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн зорилго үйл ажиллагаа өөрчлөгдсөн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| | | | | EPC-1: Технологийн бус барилга байгууламж<br>EPC-2: Анхдагч процессын болон дагалдах байгууламж<br>EPC-3: Үйлдвэрийн цахилгаан станц<br>EPC-4: Лицензит технологийн байгууламж<br>2021 оны жилийн эцсийн байдлаар EPC-2-ын тендерийг хүлээн авсан, EPC-3-ын хураангуй жагсаалтад орсон компаниудын дунд хэлэлцээ хийгдэж байгаа, EPC-4-ийн техникийн үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд EPC-1-ийн барилга угсралтын ажил 36,0%-ийн гүйцэтгэлтэй байна. | |
| 7 | 2 | 3 | 1.2.. Дотоодын түүхий эдийг боловсруулах үйлдвэр барих санаачилга гаргаж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих замаар бензин, түлш шатахууныхаа хэрэгцээг хангах зорилтыг хэрэгжүүлэх; | Уул уурхайн яам /хуучнаар/-наас газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг нийт 15 компанид олгосон хэдий ч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хөрөнгө санхүүжилт, техник технологи болон зарим тодорхойгүй шалтгааны улмаас дорвитой ажил хийгдээгүй. Нүүрс шингэрүүлж шатахуун үйлдвэрлэхээр тусгай зөвшөөрөл авсан "Багануур Энержи Корпорэйшн", "Гермон Газ", “МАК Си Ти Эл” компаниуд тодорхой ажлууд хийж эхэлсэн ч үйл ажиллагаа нь удааширч зогссон. Заримыг дурдвал “Дархан-Газрын тос боловсруулах үйлдвэр” | 100%<br><br>УИХ-ын тогтоолын заалт нь бүрэн хэрэгжээгүй, цаг хугацааны ач холбогдолгүй болсон, ҮАБЗ, УИХ, ЗГ-аас гарсан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ХХК жилд 2 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дархан хотод, “Хэт” ХХК жилд 120 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорнод аймагт, “М-Ойл” ХХК жилд 300 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Улаанбаатар хот, Рашаант өртөөнд, “Сүмбэр Ойл” ХХК-ийн жилд 100 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, “М Ойл энд Жи” ХХК нь жилд 330 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорноговь аймгийн Зүүнбаянд тус тус барих төсөл ирүүлснийг яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. ҮАБЗ-ийн 2014.03.17-ны өдрийн 14/06 дугаар зөвлөмжөөр газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах зөвлөмж гарсантай холбогдуулан Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг байгуулах төслийг хэрэгжүүлж байна. | шийдвэрүүдээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн зорилго үйл ажиллагаа өөрчлөгдсөн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 8 | 3 | 4 | **Хуулийн төслүүд буцаах, үндсэн зарчим, удирдамж батлах тухай**<br>**2008-12-04**<br>**Дугаар 2008 №40**<br>3.1/. Таван толгойн нүүрс, Оюу толгойн зэс-алтны ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төслүүдийг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж болон энэ тогтоолын хавсралтуудад нийцүүлэн боловсруулах, шаардлагатай бол холбогдох хуулийн зохих зүйл, заалтад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт боловсруулж 2009 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; (3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай:) | Тавантолгой нүүрсний ордод 2014 онд зарласан хөрөнгө оруулагчийг шалгаруулах уралдаант шалгаруулалтад БНХАУ-ын “Чайна Шенхуа Энержи” ТӨК, Японы “Сүмитомо корпораци” болон Монголын “Mongolian Mining Corporation” компанийн хамтарсан консорциум шалгарсан. Улмаар Засгийн газраас Улсын Их Хуралд дээр дурдсан консорциумтой байгуулах холбогдох гэрээний төслүүдийг бэлтгэн 2015.04.23-ны өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын даргын 2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс гэрээний төслийг судлан дүгнэлт гаргаж, Засгийн газарт буцаах шийдвэр гаргасан. | 100%<br><br>Цаашид уг тогтоолын биелэлт Сангийн яамнаас гарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 9 | 3 | 5 | 1.2/. Хөрөнгө оруулалтын гэрээний төслүүдийг боловсруулах болон хэлэлцээ хийх ажлыг ил тод явуулж, уг ажлын явцыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд тухай бүр танилцуулж байх. (3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай:) | Тавантолгой нүүрсний ордод 2014 онд зарласан хөрөнгө оруулагчийг шалгаруулах уралдаант шалгаруулалтад БНХАУ-ын “Чайна Шенхуа Энержи” ТӨК, Японы “Сүмитомо корпораци” болон Монголын “Mongolian Mining Corporation” компанийн хамтарсан консорциум шалгарсан.<br>Улмаар Засгийн газраас Улсын Их Хуралд дээр дурдсан консорциумтой байгуулах холбогдох гэрээний төслүүдийг бэлтгэн 2015.04.23-ны өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын даргын 2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулагдсан | 100%<br><br>ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ажлын хэсгээс гэрээний төслийг судлан дүгнэлт гаргаж, Засгийн газарт буцаах шийдвэр гаргасан. | |
| 10 | 4 | 6 | **Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай**<br>**2009-07-16**<br>**Дугаар 2009 №57**<br>2. Оюу толгой ордыг ашиглахтай холбогдуулан хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор баталсан үндсэн зарчим, удирдамж, Эдийн засгийн байнгын хорооны 2009 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн санал, дүгнэлтийг харгалзан байгуулахыг Засгийн газар /С.Баяр/-т зөвшөөрсүгэй. | Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын 2008.12.04-ний өдрийн 40 дүгээр тогтоол, 2009.07.16-ны өдрийн 57 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2009.10.06-ны өдрийн 308 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас эрх олгосноор түүнийг төлөөлж Монгол Улсын Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Айвенхоу Майнз Монголия Инк ХХК, Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед хооронд Оюутолгойн ордын Хөрөнгө оруулалтын гэрээг 2009.10.06-ны өдөр байгуулсан. | 100%<br><br>Гэрээг байгуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 11 | 4 | 7 | 3. Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтыг нөхсөний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлыг хөрөнгө оруулагчтай тохиролцон шийдвэрлэхийг Засгийн газар /С.Баяр/-т үүрэг болгосугай. | Монгол Улсын Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Айвенхоу Майнз Монголия Инк ХХК, Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед хооронд 2009.10.06-ны өдөр байгуулсан Оюутолгойн ордын Хөрөнгө оруулалтын гэрээний 1.6-д "Төр нь Хөрөнгө оруулагчийн энгийн хувьцааны 34 /гучин дөрөв/ хувийг өмчлөх ба энэхүү Гэрээний хугацааг энэхүү Гэрээний 15.11-д заасны дагуу сунгасан бол ийнхүү сунгаснаас хойш 1 /нэг/ жилийн дотор Хувь нийлүүлэгчдийн гэрээгээр харилцан тохиролцсон нөхцөлөөр Хөрөнгө оруулагчийн энгийн хувьцааны 16 /арван зургаа/ хувийг нэмж өмчлөх сонголт хийх эрхтэй. Энэхүү Гэрээний 1.6 дахь заалт нь Хөрөнгө 4 оруулагчийн хувьцаанаас Төрд хувьцаа нэмж гарган өмчлүүлэх, эсхүл шилжүүлэх талаар хуулийн болон Улсын Их Хурлын тогтоолын дагуу үүсч болох бүх үүргийг хангаж байгааг Засгийн газар баталгаажуулав" гэж тусгасан байна. | 100%<br><br>Цаашид уг тогтоолын биелэлт Сангийн яамнаас гарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 12 | 5 | 8 | **Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай**<br>**2010-07-07**<br>**Дугаар 2010 №39**<br>1.1/. Таван толгойн нүүрсний ордод төрийн өмчит компани ашиглалтын үйл ажиллагаа явуулах, "Эрдэнэс-Таван толгой" компанийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, оператор аж ахуйн нэгжээр олборлолтын үйл | Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий "Эрдэнэс-Таван толгой" хувьцаат компанийг "Эрдэнэс МГЛ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн охин компани хэлбэрээр үүсгэн байгуулсан.<br>Цанхийн зүүн хэсэгт ашиглалт явуулах ил уурхайн ТЭЗҮ-ийг жилийн 15.0 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтайгаар 2012 | 100%<br><br>Тогтоолын хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагааг тодорхой хугацаанд гүйцэтгүүлэх; /Энэ заалтад 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон./ | онд боловсруулж, мөн оны 01 дүгээр сараас Австрали улсын Макмахон компанитай Операторын гэрээ байгуулан ажиллаж байгаад БНХАУ-ын хөрөнгө оруулалттай "ТТ Жи Ви Ко" ХХК-д ордын гэрээт олборлолтын үйл ажиллагаа шилжсэн. Мөн Эрдэнэс Тавантолгой ХК нь Цанхийн баруун хэсэгт олборлолт хийх ил уурхайн ТЭЗҮ-ийг жилийн 20.0 сая тонн нүүрс олборлох хүч чадлаар 2012 онд батлуулж 2013 оноос үйл ажиллагаа эхлүүлсэн. 2013 оны 07 дугаар сард Уул уурхайн үндэсний олборлогч консорциум "Монгол уурхайчид" түншлэлтэй Цанхийн баруун хэсэгт олборлолтын үйл ажиллагааны гэрээг байгуулан ажиллаж байсан. | |
| 13 | 6 | 9 | **Монгол Улсын 2012 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>**2011-11-30**<br>**Дугаар 2011 №57**<br>9/. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг олон улсын зах зээл дээр нээлттэй арилжиж эхлэх өдөр хүртэл хугацаанд Монгол Улсын иргэдийн эзэмшиж байгаа уг компанийн хувьцааг зөвхөн Монгол Улсын Засгийн газар нэрлэсэн үнээр нь худалдан авах, Засгийн газар үндэсний аж ахуйн нэгжүүдэд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааны 10 хүртэлх хувийг нэрлэсэн үнээр санал болгож худалдах ажлыг зохион байгуулах; | 2010.06.30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд хувьцааны 10 хүртэлх хувийг худалдаж, нийт 29.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Гэвч хувьцааг ОУ-ын зах зээлд гаргах зэрэг хөдөлгөөн хийгдээгүй, аж ахуйн нэгжүүд удаа дараа хүсэлт гаргасан учраас Засгийн газрын 2013 оны 132, 409 дүгээр тогтоолоор нийт 21.3 тэрбум төгрөгийг буцаан ААН-үүдэд шилжүүлсэн, 1 сая төгрөг авах хүсэлт гаргасан эмзэг бүлгийн хэсэг иргэдэд 1.7 тэрбум төгрөгийг олгож, 6.2 тэрбум төгрөг үлдсэн бөгөөд хувьцаа худалдсанаас төвлөрсөн хөрөнгийг арилжааны банканд хадгалсны хүүгийн төлбөр 1.7 тэрбум төгрөгийн хамт нийт 7.9 тэрбум төгрөгийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.1.1-т заасны дагуу тус санд төвлөрүүлсэн.<br>Засгийн газрын 2017 оны 154 дүгээр "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сангийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бүртгэл дэх хувьцаа эзэмшигчийн мэдээллийг тулгаж бүртгэсэн дүнгээр нийт 486 аж ахуйн нэгж 7,065,038 ширхэг хувьцаа буюу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 0.05 хувийг эзэмшиж байна. | 100%<br><br>Тогтоолын хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 14 | 7 | 10 | **Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br>**2016-09-09**<br>**Дугаар 2016 №47**<br>1.а/. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд | УУХҮСайдын 2018.02.19-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар байгуулагдсан Стратегийн ордуудын талбайн хил зааг тогтоох ажлын хэсгийн хуралдаанд ажлын хэсгийг 2020.02.18-ны өдөр Стратегийн ордуудын лицензийн хил зааг, солбицол, ордын геологийн тогтоц, нөөц, ашиглалтын мэдээллээр хангаж ажилласан.<br>"Оюу толгойн ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Монгол Улсын Их хурлын 2019 оны 92 дугаар | 100%<br><br>ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | оруулах ажлыг эрчимжүүлэх; (1/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:) | тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 174 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 23 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэг Оюу толгойн ордын ашиглалтын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх ажлын саналыг 2020.04.16-ны өдөр танилцуулсан. Ажлын хэсгийн хуралдаанд тухай бүр оролцсон.<br>Мөн дээрх ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.02.09-ний өдрийн 45 дугаар захирамжаар, ажлын дэд хэсгийг ХЗДХ-ийн Сайдын 2021.02.24-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулаад байгаа бөгөөд УУХҮЯамнаас холбогдох саналуудыг хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>Түүнчлэн Стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын хүрээнд тус яамнаас Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулна”, “Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ” гэж тусгуулж, батлуулан хэрэгжилтийг хангаж байна. | |
| 15 | 7 | 11 | 1.б/. Төмөр зам, авто зам, уул уурхай, эрчим хүчний томоохон төслүүдийг идэвхжүүлэх замаар эдийн засгийн бусад салбарыг дэмжих; (1/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:) | УУХҮЯ нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор батлагдсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн үүргийг гүйцэтгэж байна. Үүнтэй холбоотойгоор Зүүнбаян-Тавантолгой, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замд шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх талаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж чиглэлийг тухай бүр өгч ажиллаж байна. 2021 оны байдлаар дээр дурдсан төмөр замын төслүүдэд “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас 2.5 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хийсэн байна. | 100%<br><br>ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 16 | 8 | 12 | **Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2018-06-29**<br>**Дугаар 2018 №73**<br>1.б/. Энэ тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтад тусгагдсан биржээр арилжаалах | Улсын Их Хурлын 2019.03.22-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны | 100%<br><br>ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | бэлтгэл ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, 2018 онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. | нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж тусган батлуулсан. | |
| 17 | 9 | 13 | **Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай**<br>**2020-01-10**<br>**Дугаар 2020 №04**<br>1.1/. Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах замаар орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг судалж, саналаа холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн хамт Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль баталсантай холбогдуулан төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах замаар орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах тухай холбогдох хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулан ажилласан. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг тус тус боловсруулан батлуулахаар Сангийн яаманд 2020.09.04-ний өдрийн 01/2161 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Гэвч, Сангийн яамнаас тус хуулийн төслийг дэмжих боломжгүй хариу тайлбарыг 2020.09.11-ний өдрийн 4-2/5928 дугаар албан бичгээр ирүүлсэн. Татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудал нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний чиг үүрэгт хамаарах тул Сангийн сайдын саналын дагуу дээрх хуулийн төслийг боловсруулах шаардлагагүй гэж шийдвэрлэсэн. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 18 | 10 | 14 | **Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br>**2020-12-04**<br>**Дугаар 2020 №39**<br>1.4/. Монгол Улсын 2021 оны төсвийн төслөөс хасагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцон эрэмбэлж, төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн дараа оны төсвийн төсөлд тусгах асуудлыг шийдвэрлэх; | Монгол Улсын 2021 оны төсвийн төслөөс хасагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцон эрэмбэлж, төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн 2022 оны төсвийн төсөлд тусгах чиглэлийн дагуу арга хэмжээг авч ажиллаж байна. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн саналыг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлал"-ын дагуу боловсруулан 2021.05.06-ны өдрийн 01/1194 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 100%<br><br>ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | |
| 19 | 1 | 1 | **Валютын ханш, газрын тосны бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах талаар цаашид авах арга хэмжээний тухай**<br>**2012-02-08**<br>**Дугаар 2012 №10 ЭЗБХ**<br>1.8.. Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн тоог ОХУ-ын болон бусад нийлүүлэгч компанийн тооноос хамааруулан цөөлөх, газрын тосны бөөний худалдаа эрхлэгч томоохон аж ахуй нэгжүүдээс уул уурхайн салбарын томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй шатахуунд онцгой албан татварын болон аливаа татварын хөнгөлөлтийг үзүүлэхгүй байх, газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаанд үнийг хямд, тогтвортой байлгах зорилгоор өрсөлдөөнийг дэмжих бусад бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2013.02.07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр ГТБ-нийг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр тусгасан. Мөн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т импортлогч нь "газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр импортлох" үүрэг хүлээхээр хуульчилсан. Түүнчлэн УУХҮС-ын 2018.01.12-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлагдсан "Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам"-д ГТБ импортлох тусгай зөвшөөрлийг бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд олгох нэмэлт зохицуулалт оруулсан. Онцгой албан татварын тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу тус хуулийн 6.2-т заасан хэмжээгээр автобензин, дизелийн түлшийг импортлох үед онцгой албан татварыг авч байгаа тул уул уурхайн салбарын томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй шатахуунд онцгой албан татварын болон бусад аливаа татварын хөнгөлөлтийг үзүүлээгүй болно. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 20 | 2 | 2 | **Чиглэл өгөх тухай**<br>**2017-06-30**<br>**Дугаар 2017 №07 ЭЗБХ**<br>1.1/. Зээлийн ерөнхий хэлэлцээрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн явц, хэрэгжилтийн талаар хагас жил тутам Байнгын хороонд мэдээлэл хийж байх; | БНЭУ-ын Эксим банкны санал болгосон компаниудын дунд Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, УУХҮЯамны Төрийн нарийн бичгийн даргын 2017.05.26-ны өдрийн Б/208 дугаар тушаалаар байгуулагдсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, хэлэлцээр хийх" ажлын хэсэг 2017.06.06-ны өдөр "Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах шугам хоолой"-н нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахаар шалгарсан БНЭУ-ын Зөвлөх болох EIL компанийн төлөөлөгч нартай холбогдох уулзалтыг зохион байгуулж, гэрээний төсөл болон бусад асуудлуудаар хэлэлцээр хийсэн. Улмаар УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдлын байнгын хороодоор тус тус хэлэлцүүлж, Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу тус хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017.05.31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон баталсан. Төслийн хэрэгжилтийн явц, | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | холбогдох танилцуулга мэдээллийг тухай бүр ЗГХЭГ-т танилцуулж байна. | |
| 21 | 2 | 3 | 1.2/. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нарийвчилсан техник эдийн засгийн үнэлгээ, зээлийн эдийн засгийн үр нөлөө, эргэн төлөгдөх нөхцөл болон төслийн хэрэгжилтийн явцын талаар хэрэгжилтийг ханган ажиллаж буй холбогдох яамд, байгууллагууд Байнгын хорооны хуралдаанд танилцуулах. | ЗГ-ын тэмдэглэлийн дагуу уг асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлсэн. Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017.05.31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон баталсан. | 100%<br><br>Зээлийн хэлэлцээрийг соёрхон баталсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 22 | 3 | 4 | **Чиглэл өгөх тухай**<br>**2018-10-30**<br>**Дугаар 2018 №32 ЭЗБХ**<br>2.2/. Газрын тосны зарим төрлийн бэлэн болон завсрын бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах, экологийн ангилал, импортолж байгаа боомтоос хамааруулан автобензин, дизелийн түлшний албан татварыг ялгавартай тогтоох, шатахууны үнийн огцом хэлбэлзлийг онцгой албан татварын хувь хэмжээгээр тухай бүр шуурхай зохицуулах зэрэг асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | Тус заалтын хэрэгжилтийг хангах, автобензин, дизелийн түлшний Онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан, импортолж буй боомтоос хамааруулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд тус яамнаас Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2017 оны 12 дугаар сар, 2018 оны 12 дугаар сар, 2019 оны 03 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сар, 2021 оны 1 дүгээр сард тус тус Сангийн яаманд албан бичгээр явуулж, эрхлэх асуудлын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг хүргүүлж ажилласан. СЯ-наас тухай бүр дэмжих боломжгүй хариу ирүүлж байсан. Тухайлбал 2021.01.05-ны өдрийн 4-2/04 дүгээр албан бичгээр тус асуудал нь Засгийн газрын тухай хуулийн 20.4.6-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарахыг анхааруулж, уг саналыг цар тахлын эдийн засгийн үед авч үзэх боломжгүй тухай хариу ирүүлсэн. Иймд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2021 оны арга хэмжээний төлөвлөгөөнд автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан тогтоох эрх зүйн орчин бүрдүүлэх, агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг тусгуулан батлуулж, ОББҮХ-ны ажлын албатай хамтран ажилласан. ОББҮХ-ноос агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаар Засгийн газрын 2021.12.08-ны өдрийн хуралдаанд танилцуулсан ба Засгийн газрын 2021.12.08-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлээр Автобензин, дизель | 100%<br><br>Тогтоолын дагуу УУХҮЯ-наас шалтгаалах холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | түлшний онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан тогтоох, Евро-5 стандартаас доош чанартай шатахууныг жижиглэнгээр худалдан борлуулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох сайд нар болон Нийслэлийн Засаг даргад даалгасан. | |
| 23 | 3 | 5 | 3.. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд даалгасугай. | Автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан, боомтоос хамааруулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2019.09.07-ны өдрийн 01/2545 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |
| д. УАБЗ ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | |
| 24 | 1 | 1 | **Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40**<br>2.8. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, буруутай этгээдэд хариуцлага тооцох, учруулсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авах | Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтад "тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан;" тохиолдолд Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулалтыг Улсын Их Хурлын 2019.05.02-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан. Дээр дурдсан хуулийн заалтын дагуу 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бусаар алт олборлогч нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 12.01-ний өдрийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлж ажилласан. 2019.08.23-ны өдрөөс 12.1-ний өдрийг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг авч хэрэгжүүлсэн. | 100%<br><br>Дотоод хяналтандаа авч ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт “Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ” гэж заасны дагуу уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн сангийн Байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд нийт 17 тэрбум төгрөгийг байршуулсан байна.<br>2020 онд “Эм жи эйч” ХХК-ийн Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт эзэмшиж байгаад цуцлагдсан ашиглалтын тусгай зөвшөөрлийн нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон 40.65 га талбайгаас 10 га талбайд хийх техникийн нөхөн сэргээлтийг тус компанийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн сангийн Байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд байршуулсан нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгөөр гүйцэтгэсэн байна. | |
| 25 | 2 | 2 | **Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай**<br>**2010-03-18**<br>**Дугаар 2010_10/09**<br>2. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн эрсдэлийн бодит байдлыг нийтэд таниулах, нийслэлийн орчмын бүс нутагт өндөр хурдны зам, эрчим хүчний шугам тавих замаар үйдвэр, үйлчилгээ, хүн амын суурьшлын шинэ төвүүдийг бий болгох, их, дээд сургуулийн хотхон байгуулах зэргээр төвлөрлийг задлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, | Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж үндсэн ажлын хэсэгт тооцоо судалгаа, материал бэлтгэн өгч 2021.11.03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд Газар хөдлөлтийн эрсдэл, гамшгаас хамгаалах арга хэмжээний тухай хэлэлцүүлсэн.<br>Жил бүрийн гуравдугаар сарын дөрөв дэх долоо хоногийн пүрэв гарагт Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дуут дохиогоор ажилладаг уламжлалтай. Үүний дагуу 2021.03.25-ны пүрэв гарагт цар тахлын нөхцөл байдлын улмаас дуут дохиогоор аюулгүйн цэгт цугларах дадлага сургууль хийгдээгүй тул албан хаагчид ажлын байрандаа байж, гамшгийн үеийн дуут дохио дуугарсан үед авах арга хэмжээний талаарх мэдлэгээ бататгаж, газар хөдлөлтийн талаарх зөвлөгөө, зөвлөмжийг байгууллагын дотоод сүлжээ able программаар албан хаагчдад сурталчлан таниулж ажилласан. | 100%<br><br>Тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| | | | е. Засгийн газрын тогтоол | | |
| 26 | 1 | 1 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай**<br>**2020-04-29**<br>**Дугаар 2020_153** | Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг концессын гэрээгээр гүйцэтгэх "Макс роуд" ХХК-д тус замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын 54 талбайг хайх, ашиглах | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | эрхийг холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан талбайтай давхцуулахгүй олгосон. Тус компани замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай 1,549,000 м.куб элс, дайрга, хайргыг ашиглахаар уг тогтоолд тусгасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалыг бүрэн ашиглаж замын ажлыг дуусгасан байна. | хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 27 | 2 | 2 | **Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-01-08**<br>**Дугаар 2020_14**<br>2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан охин компанийг байгуулах, түүнд хөрөнгө оруулах, бүтээгдэхүүн нийлүүлэх сонирхол илэрхийлсэн гадаадын хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулж, дүнг 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | Засгийн газрын 2020.01.08-ны өдрийн 14 дүгээр тогтоол, мөн өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэл, УУХҮСайдын 2020.04.21-ний өдрийн А/81 тушаалыг үндэслэн төрийн өмчит "Эрчис ойл" ХХК-ийг үүсгэн байгуулсан. “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжтай холбоотой асуудлаар Оросын талтай хамтран ажиллах талаар “Эрчис ойл” ХХК, “РН-Аэро” ХХН-ийн хооронд тус тус цахим уулзалтуудыг тогтмол зохион байгуулж ажиллаж байна. Тус цахим уулзалтуудаар “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжтай холбоотой асуудлууд, тухайлбал Монгол улсын “Эрчис ойл” ХХК болон ОХУ-ын “РН-Аэро” ХХН-ийн хамтын ажиллагааны хэлбэр, хамтарсан компани байгуулахтай холбоотой хувь эзэмшил, хэлбэр, гэрээний хугацаа, үйл ажиллагааны эхлэл төсвийн хэмжээ, хүний нөөц, бүрэлдэхүүн, сумалгааны тариф, агаарын хөлгийн түлшний хил үнэ, зах зээлийн өрсөлдөөн, шатахууны олон талт эх үүсвэр, зээлийн эргэн төлөлт, агаарын тээвэрлэгч нарын худалдан авах ажиллагаа, ТС-1 төрлийн агаарын хөлгийн түлшний борлуулалтын талаар тус тус хэлэлцсэн болно.<br>Үүний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2021.10.06-ны өдрийн хуралдаанаар “Эрчис ойл” ХХК болон “РН-Аэро” ХХН хооронд байгуулах хамтын ажиллагааны гэрээний төсөл болон "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн талаар танилцуулах шийдвэрийг гаргасан. Үүнтэй холбогдуулан "Эрчис ойл" ХХК-ийн зүгээс УУХҮЯ болон ОХУ-ын “Роснефть” НХН-ийн хооронд байгуулах санамж бичгийн төслийг боловсруулж, талууд солилцоод байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2021.11.17-ны өдрийн 60 дугаар тэмдэглэлд тусгаснаар “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.2-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэх шийдвэр гаргуулсан.<br>2021.11.22-ны өдрийн Ардын намын бүлгийн хурлаар хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой танилцуулгыг хэлэлцүүлж, | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | холбогдох байнгын хороодоор яаралтай хэлэлцүүлэх шийдвэрийг гаргуулсан. Улмаар 2021.11.29-ний өдөр УИХ-ын даргад "Газрын тосны бүтээгдэхүүний тухай" хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг өргөн барьсан болно. | |
| 28 | 3 | 3 | **Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2021-03-24 Дугаар 2021_74** 1. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлт, Оросын Холбооны Улсаас нийлүүлж буй шатахууны импортын үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор дотоодын зах зээл дээр борлуулж буй шатахууны хангамж доголдож болзошгүй нөхцөл байдал үүссэн тул өргөн хэрэглээний АИ-92 автобензиний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлын хүрээнд тус бүтээгдэхүүний улсын нөөцийг 30,000 (гучин мянга) тонноор нэмэгдүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т тус тус үүрэг болгосугай. | Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу улсын нөөцийг нэмэгдүүлэх АИ-92 төрлийн автобензиний худалдан авалтын ажлыг зохион байгуулахыг төрийн өмчит "Монгол ГТБҮ" ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл болон "Эрчис ойл" ХХК-нд чиглэл болгосон. УУХҮЯ, АМГТГ, "Эрчис ойл" ХХК-ийн бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулж худалдан авах ажиллагаа зарласан. Эхний худалдан авах ажиллагаанд нэг ч оролцогч материал ирүүлээгүй бөгөөд хоёр дахь удаагийн худалдан авах ажиллагаанд нэг оролцогч оролцсон болович ирүүлсэн материал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуульд заасан тендерийн баримт бичиг ирүүлээгүй, шаардлагад нийцээгүй уг тендерийг зогсоож, дахин зарлаагүй. Үүнээс гадна 2021 оны 1 дүгээр сараас хойш ОХУ-аас нийлүүлэх бүтээгдэхүүний хилийн үнэ 60%-аас 72%-иар өссөн тул худалдан авах ажиллагааг зохион байгуулах нь ач холбогдолгүй болсон. | 100% УУХҮЯ-ны зүгээс холбогдох ажлыг зохион байгуулсан, хэрэгжилт тооцох боломжгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 29 | 4 | 4 | **Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийн гарц нээх тухай 2020-12-30 Дугаар 2020_254** 2. Шивээхүрэн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалтаар уг боомтод нүүрс тээвэрлэлтийн чингэлэгтэй автомашины хяналтын нэмэлт гарцыг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах хуулийн этгээдтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд зөвшөөрсүгэй. 2. Энэ тогтоолын 1-д заасны дагуу барьсан нэмэлт гарцыг төрийн өмчид бүртгэн Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн өмчийн бодлого, | Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хил хамгаалах ерөнхий газар, "Монголын алт (МАК)" ХХК хооронд нүүрс тээвэрлэлтийн чингэлэгтэй автомашины хяналтын нэмэлт гарц барьж, хүлээлгэн өгөх тухай гэрээг 2021.03.29-ний өдөр байгуулсан бөгөөд "Монголын Алт" (МАК) ХХК Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийн 4ш гаалийн хяналтын нэмэлт гарцыг барьж, Хил хамгаалах ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. | 100% Тогтоолын хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | | |
| 30 | 5 | 5 | **Чингэлэгт тээврийн терминал байгуулах тухай**<br>**2021-07-02**<br>**Дугаар 2021_185**<br>2. Чингэлэгт тээврийн терминал байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг "Эрдэнэс-Тавантолгой" ХК болон нүүрс олборлон экспортолж буй аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай. | Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг "Энержи ресурс" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой" ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, 2021.09.20-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгч, улмаар 2021.10.03-ны өдөр "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Энержи ресурс" ХХК, "Тавантолгой" ХК-иуд бүтээн байгуулалт, санхүүжилтийн гэрээг байгуулсан. | 100%<br><br>Тогтоолын хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 31 | 5 | 6 | 4. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хилийн боомтын үндэсний зөвлөл (Б.Жавхлан), Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай. | Тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд энэ хүрээнд Гашуунсухайт боомт дахь чингэлэгт тээврийн терминалын барилга байгууламж, зам, талбайн барилга угсралт, бүтээн байгуулалтын зардлыг хамтран санхүүжүүлэх тухай 2021.10.04-ний өдрийн гэрээтэй Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд танилцаж баталгаажуулсан. | 100%<br><br>Тогтоолын хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 32 | 6 | 7 | **Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төслийн тухай**<br>**2017-08-17**<br>**Дугаар 2017_232**<br>1.. Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай. | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.1.11.1-д "Усны нөөцийг хуримтлуулж, ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Онги, Хэрлэн усан цогцолбор төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлнэ." зорилт арга хэмжээ тусгагдсан бөгөөд үндсэн хэрэгжүүлэгчээр БОАЖЯ, хамтрагч байгууллагаар Сангийн яам, УУХҮЯ, ХХААХҮЯ, Эрчим хүчний яам ажиллаж байна.<br>Өмнийн говийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр БОАЖЯ-ны байр суурийг сонсох, харилцан мэдээлэл, санал солилцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох уулзалтыг УУХҮСайд Г.Ёндон, ХҮБГ-ын Дэд бүтцийн хэлтсийн дарга С.Сүхбат, Усны газрын дарга Ш.Мягмар, "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, Дэлхийн банкны "2030 Усны нөөцийн бүлэг"-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Д.Доржсүрэн болон бусад холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 2021.04.03-ны өдөр УУХҮЯ-нд зохион байгуулсан. Энэхүү уулзалтаас өмнийн говьд | 30%<br><br>Үндсэн хэрэгжүүлэгч нь БОАЖЯ тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулагдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр бүх шатанд судалгаанд суурилсан нэгдсэн ойлголт, мэдээлэлтэй болгох ажлыг усны асуудал эрхэлсэн яам, агентлаг болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажиллаж байна.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дугаар албан даалгаврын дагуу говийн бүсийн усны асуудлыг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд "Эрдэнэставан толгой" ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр /хүчин чадал эхний модуль болох 10.0 сая.тн/жил/-ийн усны асуудлыг Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос, мөн дараагийн 20.0 сая.тн/жил хүчин чадалтай нүүрс угаах үйлдвэрийн усны эх үүсвэрийг Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан цавын газрын доорх усны ордоос хангахаар урьдчилсан байдлаар шийдвэрлээд байна. Улмаар уг 2 газрын доорх усны ордоос ус авч буй шугам хоолой нь Хэрлэн голын урсцад тохируулга хийх төсөлтэй холбогдож, газрын доорх усны хэрэглээг 60-70 хувь бууруулахаар тооцоолсон. | |
| 33 | 7 | 8 | **Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-11-18**<br>**Дугаар 2020_183**<br>19. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын бараа худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, $10^1$ дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг харьяа бүх байгууллагууд, төрийн өмчит компаниудад зөвлөж, салбарын хэмжээнд 2020 онд дотоодын үйлдвэрлэлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг нэгтгэн гаргаж 2021.01.25-ны өдрийн 01/205 дугаар албан бичгээр ХХААХҮЯ-нд хүргүүлсэн<br>Энэ ажлын хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газраас 2021.04.01-30-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулсан "Төрийн худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл" үзэсгэлэнд салбарын аж ахуйн нэгж байгууллагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулсан.<br>2021 оны дотоодын үйлдвэрлэлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг нэгтгэж хуулийн хугацаанд буюу 2022.02.10-ны дотор хүргүүлнэ. | 100%<br>Дотоод хяналтандаа авч ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | |
| ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 1 | 1 | **2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл**<br>**2020-11-04**<br>**Дугаар 2020_58**<br>XYI.4. . Дорноговь аймагт явагдаж байгаа цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагааны талаар Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. ЗГХЭГ-ын даргын 2020.05.18-ны өдрийн 31 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсгээс гаргасан зөвлөмжийн дагуу хүхрийн хүчлээр газрын дор ураныг уусган олборлох технологийн нөлөөллийг судлах ажлыг тухайн чиглэлийн холбогдох эрдэмтэд, судлаачдыг оролцуулан зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч Д.Рэгдэл нарт даалгав. | Засгийн газрын 2020.11.04-ний өдрийн хуралдааны 58 дугаар тэмдэглэлийн дагуу ШУА-ийн ерөнхийлөгчийн баталсан ажлын хэсэг эрдэмтэн, судлаачдын баг Дорноговь аймгийн Улаанбадрах суманд ажиллаж дүгнэлт, зөвлөмжөө Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2022.01.05-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэл гарсан. | 100%<br><br>Дараагийн шийдвэрүүд гарч хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 35 | 2 | 2 | **2020 оны 2 дугаар сарын 12-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл**<br>**2020-02-12**<br>**Дугаар 2020_9**<br>XYI.5. . Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаас Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх дотоодын түүхий тосыг дамжуулах хоолойгоор тээвэрлэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан төслийн санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр дамжуулах хоолойн санхүүжилтийг шийдвэрлэх санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар | Засгийн газрын 2020.02.19-ний өдрийн хуралдаанаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар танилцуулга хийж 11 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Дээрх шийдвэрийн дагуу тус яамнаас дамжуулах хоолойн санхүүжилтийн талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаанаар танилцуулж өгөх хүсэлтийг УУХҮСайдын 2020.02.17-ны өдрийн 01/464 дүгээр болон 2020.04.10-ны өдрийн 01/1002 дугаар албан бичгүүдээр Сангийн сайдад хандсан. Дамжуулах хоолойд хөрөнгө оруулах, барьж байгуулах ажлыг гүйцэтгэх компанийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар шалгаруулах талаар ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төслийг 2020.12.09-ний өдрийн хуралдаанд танилцуулж 69 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Уг тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу УУХҮЯамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.01.25-ны өдрийн А/08 дугаар тушаалаар "Түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих | 100%<br><br>Дараагийн шийдвэрүүд гарч хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах" Үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хороо мэргэжил, санхүүгийн чадавхтай олон улсын компаниудыг тендерт оролцуулах зорилгоор урьдчилсан сонголтын урилгын зарыг АНУ-ын "Gulf Publishing" компанийн "Pipeline and Gas Journal" сэтгүүл болон вебсайтад нийтэлсэн бөгөөд урьдчилсан сонголтод 9 улсын 22 компани оролцох хүсэлтээ ирүүлсэн. Эдгээрээс шалгуур хангасан 15 компанид тендерийн баримт бичгийг 2021.04.23-ны өдөр хүргүүлсэн. Тендерийг 2021.10.23-ны өдөр нээж шалгаруулалтыг хийж захиалагчаас тендерт оролцогчдод мэдэгдэл хүргүүлсэн. Шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахаар ажиллаж байна. | |
| 36 | 3 | 3 | **2020 оны 2 дугаар сарын 19-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл**<br>**2020-02-19**<br>**Дугаар 2020_11**<br>XIX.1. . Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг дор дурдсан Засгийн газрын гишүүдэд даалгав: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт: 2.1. Санхүүгийн эх үүсвэр шийдэгдэж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэний дараа бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах. | Уг тэмдэглэлийн дагуу тус яамнаас дамжуулах хоолойн санхүүжилтийн талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаанд танилцуулж өгөх хүсэлтийг УУХҮСайдын 2020.02.17-ны өдрийн 01/464 дүгээр албан бичгээр хандсан. СЯ-ны 2020.03.03-ны өдрийн 8-3/1247 дугаар албан бичигт уг төсөл нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан байх шаардлагыг хангаагүй тул Өрийн удирдлагын тухай хуулийн 33.11-д заасныг үндэслэн өрийн баталгаа гаргахгүйгээр шийдвэрлэх талаар хариу ирүүлсэн. Дээрх албан бичгийн хариуг 2020.04.10-ны өдрийн 01/1002 дугаар албан бичгээр ЗГ-ын 2019 оны 290 дүгээр тогтоолоор уг төсөл нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан тул зохих дэмжлэг үзүүлэх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн. Газрын тос дамжуулах хоолойг барих төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын урилга, туршлагын талаарх маягтуудад санал авахаар 2020.12.04-ний өдрийн 01/2971 дүгээр албан бичгээр СЯ-нд хандаж саналыг 2020.10.04-ний өдрийн 6-1/7563 дугаар албан бичгийг хүлээн авсан. Мөн газрын тос дамжуулах хоолойг барих төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах танилцуулгыг 2020.12.09-ний өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулж 69 дүгээр тэмдэглэл гаргуулсан. | 100%<br><br>Дараагийн шийдвэрүүд гарч хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 37 | 4 | 4 | **2020 оны 3 дугаар сарын 19-ний өдөр 18 дугаар тэмдэглэл**<br>**2020-03-19**<br>**Дугаар 2020_18**<br>III.2. . Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь | ОХУ-ын "Роснефть" компаниас нийлүүлж буй шатахууны 2020 оны 04 дүгээр сарын хилийн үнэ өмнөх сартай харьцуулахад А-80, Аи-92, Аи-95, Аи-98 автобензин тонн тутамдаа 209 ам.доллар, дизелийн түлш тонн тутамдаа 187 ам.доллароор буурсан ба А-80 автобензин 330 ам.доллар/тн, Аи-92 автобензин 360 ам.доллар/тн, Аи-95 автобензин 430 ам.доллар/тн, Аи-98 автобензин 480 ам.доллар/тн, дизелийн түлш 369 ам.доллар/тн болж тус тус буурсан. Үүнтэй холбоотойгоор 4 дүгээр сарын 13-наас эхлэн шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд | 100%<br><br>Дараагийн шийдвэрүүд гарч хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан тул ХЯНАЛТААС |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т даалгав: 1. Дэлхийн зах зээл дээр түүхий газрын тосны үнэ буурч байгаатай холбогдуулан Монгол Улсад шатахууны жижиглэнгийн үнийг үе шаттайгаар бууруулах; 2. Шатахууны үнэ хямд байгаа үед шатахууны улсын нөөцийг нэмэгдүүлэх талаар зохих арга хэмжээ авах. | шатахууны жижиглэнгийн үнийг 300-350 төгрөгөөр үе шаттайгаар бууруулсан ба шатахууны жижиглэнгийн үнэ дунджаар А-80 автобензин 1390 төгрөг, Аи92 автобензин 1470 төгрөг, Аи95 автобензин 2000 төгрөг, ДТ 2150 төгрөг болж тус тус буурсан. Шатахууны улсын нөөцийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан "Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам"-ыг Засгийн газрын 2021.03.17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба 68 дугаар тогтоолоор журмыг баталсан. Мөн газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын 2021.03.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн, 74 дүгээр тогтоолоор улсын нөөцийг 30000 тонноор нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. | ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 38 | 5 | 5 | **2020 оны 8 дугаар сарын 5-ны өдөр 43 дугаар тэмдэглэл 2020-08-05 Дугаар 2020_43** YI.4. 5. Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөлд зохион байгуулах түр журмын дагуу газрын тосны экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт) болон тухайн боомт байрлах аймгийн Засаг дарга болон Онцгой комиссын дарга нарт. | Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд өөрийн аймгийн нутаг дэвсгэрт орших хилийн боомтоор явагдах газрын тосны экспортын тээвэрлэлтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх үйл ажиллагааг холбогдох талуудтай хамтран зохион байгуулж, холбогдох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн, хамтран ажиллах тухай 2020.08.13-ны өдрийн 01/1977 дугаар албан бичгийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар нарт тус тус хүргүүлсэн. Баянхошуу болон Бичигт боомтоор явагдаж буй газрын тосны экспортын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байгаа ба өнөөдрийн байдлаар дээрх боомтуудаар явагдаж буй газрын тосны экспортын тээврийг 48 автоцистернээр гүйцэтгэж байсныг нэмэгдүүлэн, өдөрт 70-74 автоцистерн болгон нэмэгдүүлээд байна | 100% Дотоод хяналтандаа авч ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 39 | 5 | 6 | YI.5. . Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан "Зээлийн ерөнхий хэлэлцээр"-ийн хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж, түүнтэй хэлэлцээ хийж дууссан талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй | Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ын ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан БНЭУ-ын "JMC Projects (India) Ltd" компанитай 2020.10.13-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. | 100% Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажлыг сонгон шалгаруулалтын нөхцөл, хэлэлцээний үр дүн, зайлшгүй шаардлагатай бусад шаардлагыг харгалзан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт даалгав. | | |
| 40 | 6 | 7 | **2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл**<br>**2020-11-04**<br>**Дугаар 2020_58**<br>XYI.2. 7. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт. | Монгол Улсын Ерөнхий сайд УИХ-д газрын тосны салбарын талаар танилцуулга хийхтэй холбогдуулан БХГ-ний хэрэгжилт, салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж, УУХҮСайдын 2021.05.21-ний өдрийн 01/1335 дугаар албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга Ж.Энхбаярт хүргүүлсэн. | 100%<br><br>Дотоод хяналтандаа авч ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 41 | 7 | 8 | **2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 73 дугаар тэмдэглэл**<br>**2020-12-23**<br>**Дугаар 2020_73**<br>XIX.4. . Стратегийн ач холбогдол бүхий өргөн хэрэглээний АИ-92 автобензинийн үнийг тогтвортой хадгалах зохицуулалтын хүрээнд санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан үнийг тогтворжуулах гэрээний хэрэгжилт болон олон улсын зах зээл дээрх үнийн өсөлтөөс шалтгаалан, дотоодод үүсэх эрсдэлийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан өргөн хэрэглээний АИ-92 автобензиний жижиглэнгийн үнийг тогтворжуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт даалгав. | Санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан бүх төрлийн шатахуун, дизель түлшний жижиглэнгийн үнийг тогтворжуулах боломж нөхцөлийг судлах, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, дүнг тухай бүр танилцуулж ажиллах чиглэл хүргэх тухай 2020.12.03-ны өдрийн 01/2963 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн.<br>Өнгөрсөн оны 11 дүгээр сараас эхлэн тодорхой хүчин зүйлсийн нөлөөллөөр дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ тасралтгүй өссөн ба үүнийг дагаад ОХУ-аас манай улсад нийлүүлж буй газрын тосны бүтээгдэхүүний импортын үнэ сар бүр нэмэгдэж ирсэн.<br>Иймд газрын тосны бүтээгдэхүүний хангамж, гадаад зах зээлийн нөхцөл байдал, жижиглэн борлуулалтын үнэ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, холбогдох танилцуулгыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮСайдын 2021.03.01-ний өдрийн 01/460 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Өргөн хэрэглээний АИ-92 автобензиний үнийг тогтворжуулах, хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд газрын тосны | 100%<br><br>Дараагийн шийдвэрүүд гарч хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх, харилцааг зохицуулах “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам”-ыг Засгийн газрын 2021.03.17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба 68 дугаар тогтоолоор журмыг баталсан.<br>Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээний үлгэрчилсэн загвар, мэдээ тайлангийн маягтын загварыг УУХҮСайдын 2021.04.28-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар баталсан. Тус тушаал, журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллах тухай 2021.04.30-ны өдрийн 01/1150 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн ба журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>Мөн газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын 2021.03.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба ЗГ-ын 74 дүгээр тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 30000 тонноор нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу улсын нөөцийг нэмэгдүүлэх АИ-92 төрлийн автобензиний худалдан авалтын ажлыг зохион байгуулахыг төрийн өмчит “Монгол ГТБҮ” ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл болон “Эрчис ойл” ХХК-д чиглэл болгосон. Үүний дагуу улсын нөөцийн 30000 тонн АИ-92 автобензинийг худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. | |
| 42 | 8 | 9 | **2021 оны 10 дугаар сарын 6-ны өдөр 54 дүгээр тэмдэглэл**<br>**2021-10-06**<br>**Дугаар 2021_54**<br>ҮI.2. Шатахууны эрсдэлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль болон хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулан, 2021.10.07-ны өдрийн 01/2431 дүгээр албан бичгээр Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн. Хуулийн төслийг холбогдох яамд дэмжээгүй, үзэл баримтлалыг хамтран батлаагүйтэй холбоотойгоор Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага хангагдаагүй тул ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх боломжгүй болсон. | 100%<br><br>УУХҮЯ-ны зүгээс хуулийн төслийг боловсруулсан, ХЗДЯ, СЯ дэмжээгүй тул заалтыг ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 43 | 9 | 10 | **2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 37 дүгээр тэмдэглэл**<br>**2020-06-23**<br>**Дугаар 2020_37** | “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК хооронд 2019.10.24-ний өдөр “Үнэт цаас худалдах, худалдан авах тухай гэрээ”-г холбогдох хууль, журмын дагуу байгуулсан. | 100%<br><br>Дотоод хяналтандаа авч ХЯНАЛТААС |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ҮI.1. 5. . Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад шаардлагатай нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэх талаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан нарт; | 2019.12.27-нд Санхүүгийн зохицуулах хорооноос 407 дугаар тогтоол гаргаж "Монголын төмөр зам" ТӨХК-ийн үнэт цаасыг албан ёсоор бүртгэж авсан. Үнэт цаас худалдан авах ажлыг "ЭТТ" ХК-аас үе шаттай зохион байгуулж 2020 оны 7 дугаар сард нийт 750 тэрбум төгрөгийн үнэт цаасыг бүрэн худалдан авч төлбөрийг "Монголын төмөр зам" ТӨХК-д шилжүүлж дууссан.<br>Одоогийн байдлаар "Эрдэнэс Тавантолгой" ХК нь "Монголын төмөр зам" ТӨХК-аас гаргасан 750 мянган ширхэг үнэт цаасыг эзэмшиж "Хаан банк" ХХК-ийн кастодиан үйлчилгээний газарт хадгалуулж байна.<br>"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өмнөх 750 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас гадна дараах санхүүжилтийг "Зүүнбаян төмөр зам" ХХК-д хийгээд байна. Үүнд:<br>– Нэмэлт санхүүжилтээр 406.4 тэрбум төгрөг<br>– Нийт 1.15 их наяд төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.<br>Үлдэгдэл санхүүжилтийг "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК, "Зүүнбаян төмөр зам" ХХК нарын хооронд хийгдэх "Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ"-г эцэслэн байгуулсны дараа өөрийн эзэмшлийн хувь, хэмжээний дагуу үе шаттай олгохоор ажиллаж байна. | ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 14 | 10 | 11 | **2020 оны 11 дүгээр сарын 18ны өдөр 64 дүгээр тэмдэглэл**<br>**2020-11-18**<br>**Дугаар 2020_64**<br>ҮIII.1. 6. Иргэдийг дотоод орчны угаарын хийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор "Яндангаа хөөлье" аяныг эрчимжүүлэх, агаар, орчны бохирдлын сөрөг нөлөөллийг таниулах олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл,"Таван толгой түлш" ХХК (М.Ганбаатар) нарт; | Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос зарласан "ЯНДАНГАА ХӨӨЛЬЕ" аянд Таван толгой түлш ХХК нэгдэж тус компанийн "Хэрэглэгчдэд үйлчлэх" албанаас яндан хөөлөх 400 гэрээт ажилтан гаргаж айл өрхүүдийн яндан ханан пийшин хөөлөх ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороотой хамтран 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан ОББҮХ/2020-87 дугаартай гэрээний дагуу 2020 оны 9 дүгээр сарын 5-наас эхэлж зохион байгуулан ажилласан. Нийслэлийн 6 дүүргийн гэр хорооллын айл өрхүүдээс ирсэн дуудлагуудаар "Яндангаа хөөлье" аяныг хэрэгжүүлж нам даралтын зуух болон ханан пийшинд дуудлагаар очиж яндан хөөлж , засах, шинээр ханан пийшин өрөх зэрэг үйлчилгээг үзүүлэн ажиллаж тайлант хугацаанд шинээр сургасан 400 яндан хөөлөгч 12,628 айлын яндан, пийшинг хөөлсөн. | 100%<br>Уг асуудал нь ЭХЯ-ны эрхлэх асуудалд хамаарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 15 | 11 | 12 | **2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл** | Баруун бүсийн үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах зүүн бүсийн үйлдвэр лүү шилжүүлэхэд шаардагдах зардлын тооцоог урьдчилсан байдлаар боловсруулсан бөгөөд | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **2021-02-10**<br>**Дугаар 2021_9**<br>XII.3. 2. "Таван толгой түлш" ХХК-ийн үйлдвэрийг шилжүүлэхэд шаардагдах зардлыг судалж танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ), "Таван толгой түлш" ХХК (М.Ганбаатар) нарт; | Баруун бүсийн үйлдвэрийг шилжүүлэхэд шинээр баригдах барилга, байгууламжийн зардал 64.85 тэрбум төгрөг, цахилгаан хангамжийн хэсэг 3.43 тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийг буулгах, зөөх, угсрах зардал 12.10 тэрбум төгрөг болж нийт зардал 80.38 тэрбум төгрөг болох тооцоолол гарсан.<br>Баруун бүсийн 2 дугаар үйлдвэрийг шилжүүлэхэд гарах зардлын тооцоо урьдчилсан байдлаар 35.6 тэрбум төгрөг болсон бөгөөд үйлдвэрийг шилжүүлэхэд барилгын болон технологийн зураг төсөл боловсруулах, гүний худаг гаргах, үйлдвэрийн дулаан хангамж, цахилгаан хангамжийн барилга байгууламжуудыг шинээр барих шаардлагатай. /ЭХСайдын 2021 оны А/71 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг оруулав./ | Цаашид уг тэмдэглэлийн биелэлт ЭХЯ-наас гарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 46 | 12 | 13 | **2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр 30 дугаар тэмдэглэл**<br>**2021-05-12**<br>**Дугаар 2021_30**<br>XIX.5.3. Монгол Улс, БНХАУ-ын хилийн Гашуунсухайт-Ганцмод төмөр замын боомтын галт тэрэг солилцох технологийн асуудлаар БНХАУ-ын талтай тохиролцсоны үндсэн дээр Гашуунсухайт боомтын 1435 мм-ийн царигтай төмөр замын өртөө, шилжүүлэн ачих байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, тэдгээрийг үе шаттайгаар цогцоор нь барьж байгуулахад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Цогтбаяр) нарт; | Зам, тээврийн хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах тул биелэлт гаргах боломжгүй. | /-/<br>Цаашид уг тэмдэглэлийн биелэлт ЗТХЯ-наас гарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 47 | 13 | 14 | **2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл**<br>**2021-10-13**<br>**Дугаар 2021_55**<br>IY.3. "Тавантолгой түлш" ХХК-ийг цаашид үр ашигтай, бизнесийн зарчмаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | "Тавантолгой түлш" ХХК-ийг цаашид үр ашигтай, бизнесийн зарчмаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бизнесийн төлөвлөгөөний хүрээнд дотоод үйл ажиллагаа менежментийг сайжруулах, төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх төслийг боловсруулан 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд танилцуулсан. Эрчим хүчний сайдаас эдийн засгийн үр ашигтай хувилбар тооцооллыг хийж дахин танилцуулах чиглэл өгсний дагуу ажиллаж байна. | /-/<br>Уг асуудал нь ЭХЯ-ны эрхлэх асуудалд хамаарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | (Б.Цэнгэл), "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгав. | | |
| з. Засгийн газрын албан даалгавар | | | | | |
| НИЙТ 47 ЗҮЙЛ, ЗААЛТ | | | | | |

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ